



JAPAN FOUNDATION

ТАЙЛАН

МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ
НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



АРВАНТАВДУГААР
2023ОН



МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



ТАЙЛАН

(2022.01.01-2022.12.31)

2023 он



ТӨВИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (Цаашид Монгол-Японы төв гэх) нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (Цаашид ЖАЙКА гэх), Боловсрол, Шинжлэх ухааны яам болон МУИС-ийн хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулдаг. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.

2002 он 01 сарын 22	ЖАЙКА болон МУИС-ийн оролцоотойгоор Төслийн нэгдүгээр үе шатыг эхлүүлсэн.
2002 он 03 сарын 14	Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол-Японы Төвийн барилга байгууламж тоног төхөөрөмжийг (нийт 4.43 сая ам доллар) хүлээлгэн өгсөн. (Барилгын талбайн хэмжээ нь 1,520 m ² , нийт талбайн хэмжээ нь 7,000 m ²)
2002 он 06 сарын 21	Албан ёсны нээлтийн үйл ажиллагаанд Японы эрхэм дээд ханхүү Акишинономия, Гүнж Кикогийн хамт оролцсон.
2007 он 01 сарын 22	Төслийн хоёрдугаар үе шат эхэлсэн. (2012 оны 1 сарын 21 хүртэл)
2007 он 07 сарын 16	Төвийн 5 жилийн ойн арга хэмжээнд Японы эрхэм дээд угсаа залгамжлах ханхүү Нарүхито морилон ирсэн.
2009 он 07 сарын 03	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 1,000,000-д хүрсэн.
2012 он 01 сарын 22	ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагаа бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төслийг эхлүүлсэн
2012 он 04 сарын 01	Япон сангийн хэлний төвийн төслийг эхлүүсэн.
2012 он 04 сарын 13	Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн, санхүүгийн бие даасан нэгж болсон.
2012 он 06 сарын 21	Төвийн 10 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.
2015 он 04 сарын 22	Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төслийг эхлүүлсэн.
2016 он 04 сарын 01	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,000,000-д хүрсэн.
2017 он 06 сарын 14	Канэко Харүкогийн вааран урлалын “Аз жаргалын цэнхэр хана” бүтээлийн нээлтийн ёслол.
2017 он 06 сарын 21	Төв байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.
2020 он 04 сарын 22	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх төсөл
2020 он 10 сарын 19	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,500,000-д хүрсэн.
2022 он 06 сарын 21	Төв байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.



Алсын хараа

Монгол улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, Монгол, Япон хоёр улсыг холбогч гүүр болон ажиллах болно.

Эрхэм зорилго

Үйлчлүүлэгчдийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ бий болгон хэрэгжүүлж, Монгол, Япон хоёр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.

Уриа

Монголын ирээдүйг энд хөгжүүлье!

Үнэт зүйлс

- Монгол дахь япон орчин
- Япон маягийн үйлчилгээ, японы талаарх мэдээллийг түгээх
- Японд хуримтлуулсан мэдлэг, мэдээллийг түгээх
- Чадварлаг Монгол, Япон ажилтнуудын баг
- МУИС болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа
- ЖАЙКА, Япон сан ба японы бусад байгууллагуудын хүчтэй дэмжлэг



ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц.Даваадорж.....7

МЭНДЧИЛГЭЭ

Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Кобаяши Хироюки	9
МУИС-ийн захирал, доктор Д.Бадарч.....	10
ЖАЙКА Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Танака Шиничи.....	11
Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан Япон хэлний 1-р хэлтсийн дарга Мүрата Харүфүми.....	13
Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх, ЖАЙКА-ын мэргэжилтэн Ониши Ёшифүми.....	15
Япон сангийн япон хэлний мэргэжилтэн Цүрүта Ясүюки.....	17

I. БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ

1. 2022 онд зохион байгуулсан бизнесийн сургалт, семинарын тайлан.....	19
Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт.....	19
1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт”.....	19
2) “Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”	22
3) Япон дахь дадлага сургал	24
2. Монгол, Японы хамтын бизнесийн ажиллагааг эрчимжүүлэх нь.....	38
1) Коронагийн өмнөх үетэй харьцуулахад бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа илүү өргөжсөн.....	39
2) Монголд зохион байгуулагддаг Япон-Монголын бизнесийн хамгийн том арга хэмжээ болох “Япон-Монголын Бизнес Форум”-ыг 3 жил завсарласны дараа “Япон фестиваль Монголд 2022” нэрийн дор зохион байгууллаа.....	40
3) Бизнесийн хамтын ажиллагаа болон гадаадын ажиллах хүчийг дэмжих хоёр ажиллагааны хамтарсан үр дүн.....	42
3. Онцлох мэдээ.....	44



1) Бизнесийн үндсэн сургалтыг анх удаа орон нутагт амжилттай зохион байгууллаа.....	44
2) “Датад суурилсан маркетинг” сэдэвт ахисан түвшний шинэ сэдэв нэмэгдлээ.....	45
3) Үе үеийн бизнесийн сургалт төгсөгчдөдөө зориулсан тусгай семинарыг зохион байгууллаа.....	44
4. Суралцагчдын дуу хоолой.....	45

II. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ

1. 2022 онд зохион байгуулсан япон хэлний сургалт, семинарын тайлан.....	50
1) Япон хэлний сургалтын талаар.....	50
2) Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар.....	51
2. Онцлох мэдээ.....	65
1) 2022 оны зуны “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”.....	65
2) “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”.....	66
3) “Кёотогийн их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөрт элсэн орогчдод зориулсан япон хэлний бэлтгэл сургалт-2022”.....	67
4) “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд.....	68
5) “2022 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн”.....	69
3. МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ОНЦЛОХ МЭДЭЭ.....	70
1) "ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2022".....	70
2) “14 дэх удаагийн япон хэлний боловсролын симпозиум” зохион байгуулагдлаа..	71
3) Өвөрхангай аймгийн Мэргэд сургуульд ажилласан томилолтын талаар.....	72
4) Монгол-Японы төвийн япон хэлний сургалт төгсөгчдийн уулзалт болон соёлын өдөрлөг.....	74



5) “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн”..75

4. Суралцагчдын дуу хоолой.....76

III. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ

1. 2022 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан.....86

- 1) Номын сангийн үйл ажиллагаа.....86
- 2) Япон киноны өдөр.....87
- 3) Нээлттэй семинар.....87
- 4) Японд суралцах мэдээллийн яармаг-2022.....87
- 5) Гэрээгээр гүйцэтгэх ажил.....88

2. Онцлох мэдээ.....91

- 1) “Японд суралцах талаар цахим мэдээллийн яармаг – 2022”.....91
- 2) 82-р нээлттэй семинар: “Нөхөрлөл” хүндэтгэлийн цайны ёслол.....93
- 3) Зохиолч уншигчдын уулзалт: Дазай Осамү “Хүн байх эрхгүй” номын хэлэлцүүлэг.....94
- 4) Баруун бүсийн Увс, Ховд, Баян-Өлгий аймаг дахь япон соёлын танилцуулга.....95
- 5) ЖАЙКА Чикюү Хироба.....97
- 6) Read Japan Project-2021.....98

IV. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ТАСАГ

1. 2022 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан.....100

2. Онцлох мэдээ.....103

- 1) 20 жилийн ойгоо угтлаа.....103

V. БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. 2022 оны багуудын үйл ажиллагааны тайлан.....105

- 1) Маркетингийн баг.....105
- 2) 5S Кайзен баг.....106
- 3) Эрүүл мэнд, спортын баг.....107
- 4) Үйл ажиллагаа зохион байгуулах баг.....109



ӨМНӨХ ҮГ



2022 он нь Дэлхий даяар цар тахлын аюулыг мэдэрч, цар тахалтай зэрэгцэн өөрсдийн ажил үйлс, амьдралаа зохицуулан явах сорилтын жил болсон юм. Монгол орны хувьд ч энэ бодит байдлаас зугатах аргагүй байлаа.

2022 он бол бидний хувьд олон олон тэгш ойнууд давхцсан, түүхэн тэмдэглэлт жил болон өнгөрлөө. Тухайлбал: МУИС байгуулагдсаны буюу Монгол улсад дээд боловсролын байгууллага үүссэний 80 жил, Монгол Япон хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн, Монгол улсад ЖАЙКА-гийн сайн дурынхан ажиллаж эхэлсний 30 жил, Монголд ЖАЙКА-гийн төлөөлөгчийн газар байгуулагдсаны 25 жил, манай Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв байгуулагдсаны 20 жил болон Япон сангийн япон хэлний төв ажиллаж эхэлсний 10 жил гээд олон тэгш ойд бид бахдам амжилтаар тэмдэглэн өнгөрүүлсэн юм.

Өнгөрсөн жилд манай хамт олон 30 гаруй төрлийн 221 ажил төлөвлөснөө амжилттай хэрэгжүүлсэн. Нийт ажлын биелэлт 97%-тай гарсан нь үүнийг нотлон харуулж байна. Төвийн ажиллагсдын хувьд ч ахиц гарсан гэж үздэг. Ажиллагсдын дундаж цалин 1,6 сая төгрөгт хүрч, өмнөх жилийнхээс 11,8% өссөн. Хэдийгээр Монгол улсын эдийн засгийн байдал сайнгүй, инфляци нэмэгдэж байгаа ч ажиллагсдынхаа бодит орлогыг бууруулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм. Ажиллагсдын шагналын хур ч арвин байлаа. Төвийн үйлчлэгчээр ажиллаж байгаад гавъяаныхаа амралтанд гарсан Д.Лхагва төрийн дээд шагнал болох “Алтан гадас” одонгоор шагнагдсан нь бидний бахархал болов. Мөн миний бие Ц.Даваадорж Японы дээд шагнал болох “Мандах нар” одонгоор шагнагдсан нь манай хамт олны ажлыг Япон улсын зүгээс өндөрөөр үнэлж байгаа хэрэг гэж үзэж байна. Бусад олон хүмүүс Засгийн газрын болон МУИС-ийн шагналуудаар шагнагдлаа.

Япон улсад 4 ажилтан маань тэтгэлэгээр суралцаж байгаа нь манай төвийн чадавхийг бэхжүүлэхэд Япон талаас ихээхэн анхаарч байгаагийн илрэл юм.

2022 оныхоо төлөвлөгөөт орлогыг 8,7%-иар давуулан биелүүлсэн бөгөөд зарлагаа ч 1,7%-иар хэмнэж ажилласан байна. 2018 оныг дуустал төвийн дулаан, цахилгаан, усны төлбөр болох тогтмол зардлыг Монголын Засгийн газраас санхүүжүүлж байсныг зогсоосон байсан. 2022 оноос эргээд дээрх зардлыг санхүүжүүлэхээр шийдэж, санхүүжилтийг улсын төсвөөс олгох болсон нь энэ жилийн нэгэн талархалтай үйл болсон. Цаашид ч Монгол Япон хоёр улсын хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу Монголын тал хүлээсэн үүргээ биелүүлж, санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн. БШУ-ны яамны төсөвт багтаан санхүүжилэхээр тогтсон байна.



2022 оны жилийн тайлангаас дэлгэрэнгүй танилцах боломжтой тул ингээд үгээ товчлоё. Энэ жилийн тайлангийн бас нэг онцлог нь цаасан хэвлэлтээр гаргахгүй цахим хэлбэрээр түгээх болсон явдал билээ.

Бидний үйл ажиллагааг ямагт дэмжиж, тусалж байдаг хамтран ажиллагч Японы болон Монголын бүх байгууллага, хувь хүмүүст халуун талархлаа дахин дахин илэрхийлье. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагаа байгаа учраас манай төв үргэлж урагш ахиж, амжилттай ажиллаж байгаа гэж бид үздэг.

Манай хамт олон ч цаашид ихээр хичээн, өөрсдийн чадвар, мэдлэгээ бүрэн дайчлан ажиллах болно. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагааг амжилттай болгон, төвийнхөө нэр хүндийг өндөрт өргөн явахаа амлаж байна.

Монголын ирээдүйг гэрэлтэй, гэгээлэг болгохын төлөө МЯТ-ийн хамт олон ажил үүргийнхээ хүрээнд бүхнийг хийх болно. Бүх хүмүүст сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа.

**Монгол-Японы Хүний Нөөцийн хөгжлийн төвийн
Захирал Ц.Даваадорж**



МЭНДЧИЛГЭЭ



Өнгөрөгч 2022 онд Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиосны зэрэгцээ Япон Улсын буцалтгүй тусламжаар байгуулагдсан Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (Монгол-Япон төв) 20 жилийн ойтойгоо золгосон билээ. Япон Улсын Засгийн газрыг төлөөлж Та бүхэнд чин сэтгэлээсээ баяр хүргэхийн ялдамд өнөөг хүртэл бүхий л талаар дэмжин тусалж ирсэн хоёр орны холбогдох хүмүүст гүн талархал илэрхийлье.

2020 оны эхээр эхэлсэн дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн корона вирусийн тархалт бүрэн намжаагүй хэдий ч 2022 он гарсаар тархалт нэлээд буурах нааштай хандлага ажиглагдаж эхэлсэн. Энэ нь 2022 онд тохиосон Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн түүхэн тэмдэглэлт ойд зориулсан олон янзын арга хэмжээг амжилттай зохион байгуулах боломжийг бий болгосонд туйлын баяртай байна.

Тухайлбал өнгөрсөн оны 11 дүгээр сард Монгол-Япон төвийн дэмжлэгтэйгээр “Япон Улсаас үзүүлж ирсэн Хөгжлийн Албан Ёсны Тусламж (ХАЁТ)-ийг танилцуулах гэрэл зургийн үзэсгэлэн”, 8 дугаар сард “Монгол Япон бизнес форум-2022” зэргийг амжилттай зохион байгуулсан билээ. Мөн цар тахлын хариу арга хэмжээний улмаас өнгөрсөн 2 жилийн хугацаанд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байсан “Японд суралцах тухай мэдээллийн өдөрлөг” болон “Уран илтгэлийн уралдаан” зэргийг танхимаар амжилттай зохион байгуулсан юм. Ийнхүү арга хэмжээг зохион байгуулахад идэвх чармайлт гарган ажилласан Монгол-Япон төвийн хамт олонд чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол-Япон төв нь Монгол дахь бизнесийн боловсон хүчнийг бэлтгэх, Япон хэлний боловсрол олгох, Монгол, Японы ард иргэд хоорондын харилцааг бэхжүүлэх тулгуур багана болж тууштай ажилласаар ирсэн билээ. Монгол-Япон төвийн хамт олон үйл ажиллагаагаа улам бүр бэхжүүлэн Монгол Улсын хөгжил болон хоёр орны найрамдалт харилцаанд цаашид ч улам их хувь нэмэр оруулна гэдэгт бат итгэлтэй байна.

**.Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд
Кобаяши Хироюки**



МЭНДЧИЛГЭЭ



Сайн байцгаана уу? Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

МУИС, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (ЖАЙКА) хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Япон улсын буцалтгүй тусламжаар баригдсан “Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв” үүдээ нээснээс хойш даруй 20 жил өнгөрчээ.

Өнгөрсөн жил Монгол Улсын ууган их сургууль МУИС-ийн 80 жилийн ой, Монгол, Япон улсын харилцаа, хамтын ажиллагааны 50 жилийн ой тохиосон түүхэн он байлаа.

МУИС-ийн Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь манай улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, хоёр орны хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд цаашид ч хоёр улсын эрдэмтэд, мэргэжилтнүүд, бизнесийн салбарынхныг холбогч “түүр” болон ажиллах үүргээ нэр төртэй хэрэгжүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг байнга дэмжиж ирсэн Япон улсын ЭСЯ, Монгол талаас дэмжин ажилладаг Боловсрол шинжлэх ухааны яам, Сангийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон бусад байгууллага, хүмүүст МУИС-ийн хамт олны өмнөөс талархал илэрхийлье.

Мөн Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн ажлыг тогтвортой дэмжиж, санхүүжилтээ бууруулахгүй хамтран ажиллаж буй ЖАЙКА болон “Япон сан”-гийн хамт олонд гүнээ талархаж байна.

Төвийнхөө үйл ажиллагааг тогтвортой, найдвартай авч явахыг Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн нийт ажилтан, мэргэжилтнүүдэд уриалж байна.

Та бүхэнд сайн сайхныг хүсье.

МУИС-ийн захирал Д.Бадарч



МЭНДЧИЛГЭЭ



Япон Улсын Засгийн газрын тусламжаар байгуулагдсан Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв (цаашид, Япон төв) нь 2022 онд 20 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ 20 жилийн хугацаанд Япон төв нь аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх болон Япон, Монгол 2 орны бизнесийн хамтын ажиллагаа, Япон хэлний боловсрол, харилцан ойлголцлыг идэвхжүүлэх үйл хэрэгт онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн гэж бодож байна.

2022 онд Япон, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил, ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар байгуулагдсаны 25 жил, ЖАЙКА-ийн Сайн дурын ажилтан Монголд томилогдсоны 30 жилийн ой зэрэг хоёр орны хувьд тэмдэглэлт хэд хэдэн тэгш ой тохиосон он болж өнгөрч байна. Эдгээр ойн арга хэмжээний хүрээнд Япон төв нь Япон улсын Элчин сайдын яам, тус Төлөөлөгчийн газартай хамтран Япон-Монголын Бизнес форум, Япон фестиваль зэрэг нийтийг хамарсан томоохон арга хэмжээг зохион байгуулж, хоёр орны бизнесийн болон соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллалаа. Түүнчлэн гарааны бизнесийг дэмжих MonJa хурдасгуур хөтөлбөр болон “Японы орчин үеийн хөгжлийг судлахуй” (JICA Chair) цуврал лекцийг зохион байгуулахад асар их туслалцаа үзүүлж, дэмжиж ажилласанд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Бизнесийн үндсэн сургалтыг хөдөө, орон нутагт өргөжүүлэх зорилгоор Эрдэнэт хотод туршилтын журмаар анхлан зохион байгуулсан багц сургалт амжилттай өндөрлөж, орон нутгийн компаниудыг чадавхжуулах, бүс нутгийн хөгжлийг идэвхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулсан гэж бодож байна. Цаашид ч Япон төв нь өөрийн боломжид тулгуурлан орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бизнес сургалтуудыг үргэлжүүлэн зохион байгуулна гэдэгт найдаж байна.

Япон төвтэй хамтран хэрэгжүүлж буй техникийн хамтын ажиллагааны төслийн агуулгад "Монгол хүний нөөцийн карьер хөгжлийн дэмжлэг" зорилт шинээр нэмэгдэж, Монгол хүмүүс Японы их дээд сургуульд суралцах, Японд хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг, Японоос эх орондоо буцаж ирсний дараа ажил мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг тус тус хэрэгжих гэж байна. Монгол, Японы нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөө Япон төвийн онцлог, давуу талыг ашиглан ажлын байранд зуучлах, карьер хөгжлийн дэмжлэг үзүүлэх ажил үе шаттайгаар эхэлж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан Япон төвийн үүрэг оролцоо улам бүр өргөжин тэлэх болно гэдэгт итгэлтэй байна.




Энэ дашрамд Япон төв болон ЖАЙКА-ийн хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг ямагт дэмжиж ирсэн бүхий л хүмүүст талархал илэрхийлье. Япон төв нь хоёр орны бизнесийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцлын гүүр нь байж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд ЖАЙКА бүх талаар дэмжиж ажиллах болно. Та бүхэн ч гэсэн бидний үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллана гэдэгт найдаж байна.

**ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга
Танака Шиничи**



МЭНДЧИЛГЭЭ



2022 он бол Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиохын зэрэгцээ Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв /цаашид Монгол-Японы төв гэх/-ийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиож буй тэмдэглэлт жил болж байна. Чин сэтгэлээсээ баяр хүргэхийн ялдамд Ц.Даваадорж захиралтай төвийн хамт олны олон жилийн бодит үр дүн хөдөлмөр зүтгэлийг зүрх сэтгэлээсээ хүндэтгэн бахархаж буйгаа илэрхийлэхэд таатай байна.

Япон сан нь тус төвийн үйл ажиллагааны үндсэн 3 багана болох бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилго бүхий үйл ажиллагаануудаас япон хэлний боловсрол болон харилцаа хамтын ажиллагааны салбарт хамтран ажилласаар ирсэн билээ.

2002 оноос өнөөг хүртэл Монгол-Японы төвд япон хэлний мэргэжилтэн багшийг томилон, улмаар 2012 оны 4 сараас эхлэн тус төвтэй хамтран “Япон сангийн хэлний төв” төслийн хүрээнд “Япон сангийн япон хэлний сургалт”-ыг явуулаад 10 дахь жилээ угтлаа. Энэхүү завшааныг ашиглан өнөөг хүртэл бидэнтэй хамтран ажиллаж буй та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Япон сангийн япон хэлний сургалт нь “Япон хэлийг ашиглан юуг чадах вэ?” буюу “Асуудал шийдвэрлэх чадвар”, харилцагчийнхаа соёлыг ойлгож хүндэтгэх буюу “Өөр бусдын соёлыг ойлгох чадвар”-ыг хөгжүүлэхийг гол зорилго болгосон “Япон сангийн япон хэлний боловсролын стандартад” тулгуурлан явагддаг.

Япон сангаас бэлтгэн гаргадаг сургалтын хэрэглэгдэхүүн болох “Марүгото япон хэл ба соёл” сурах бичгийг ашиглан япон хэлний анхан шатнаас дунд шат хүртэлх түвшний сургалтуудыг зохион явуулсаар ирлээ. Мөн Монгол-Японы төв нь япон хэлний өндөр мэдлэгтэй дээд түвшний сурагчдад зориулсан сургалт, зуны улиралд хүүхдэд зориулсан япон хэлний сургалт зэрэг Монгол улсад япон хэлийг сонирхон суралцаж буй нийт суралцагчдад хүртээмжтэйгээр тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлж, Монгол дахь япон хэлний боловсролын орчин нөхцөлд тохируулан төрөл бүрийн сургалтуудыг бэлтгэн явуулсаар байна. Шинэ корона вирусын нөхцөл байдлаас үүдэн сургалтуудыг цахим хэлбэрээр зохион явуулах зэрэгт уян хатан байдлаар аль болох сургалтыг тасралтгүй зохион явуулах тал дээр хичээнгүйлэн ажиллалаа. Энэхүү 10 жилд туулж мэдсэн туршлага, мэдлэг чадварт тулгуурлан цаашид ч гэсэн чанартай сургалт зохион явуулахыг зорин ажиллах болно.

Япон сангийн хэлний төв нь япон хэлний сургалтаас гадна Японд жилийн туршид тогтмол болдог баяр ёслол, үйл ажиллагааг танилцуулах япон хэлний соёлын сургалт, япон хэл суралцагч болон багш нарт зориулсан номын сангийн үйл ажиллагааг явуулахад ч мөн хамтран ажилладаг. Мөн Монгол дахь япон хэлний боловсролыг улам хөгжүүлэхийг зорьж, Япон сангаас томилогдон ажиллаж буй япон хэлний мэргэжилтэнтэй хамтран ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалтыг ч гэсэн амжилттай зохион явуулж байна. Мөн сүүлийн жилүүдэд “Тусгай ур



чадвартай ажиллах хүч”-ний тогтолцоогоор Япон улсад ажиллаж амьдрах хүсэлтэй иргэдэд зориулан бэлтгэн гаргасан “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичиг дээр тулгуурлан япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалтыг тус тус зохион явуулж байна.

Япон сан нь цаашид ч гэсэн Монгол-Японы төвтэй хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлж, олон монгол хүмүүст япон хэл, соёлтой танилцах, суралцах боломжийг олгохоор хичээн ажиллах болно. Монгол-Японы төв нь япон хэлний боловсрол, япон соёлыг түгээн дэлгэрүүлэх цөм нь болж, хоёр улсын гүүр болох хүний нөөцийг улам бүр хөгжүүлэн ажиллах болтугай хэмээн чин сэтгэлийн гүнээс хүсэн ерөөе.

**Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан
Япон хэлний 1-р хэлтсийн дарга Мүрата Харүфүми**



МЭНДЧИЛГЭЭ



Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе

2022 он нь Монгол Японы дипломат харилцаа тогтоосны 50 жил, JICA-ийн сайн дурын гишүүн илгээсний 30 жилийн ой зэрэг 2 улсын хувьд чухал жил болж өнгөрлөө. Мөн Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (цаашид Япон төв гэх)-ийн 20 жилийн ой тохиолоо. Япон төвийн бүтээн байгуулалтаас өнөөдрийг хүртэл Япон төвийн үндсэн сууриас хөгжүүлж ирсэн холбогдох хүмүүсийн бодол, хичээл зүтгэл, тусламж дэмжлэгийг эргэцүүлэн бодох боломж олдож, төвийн ажилтнууд, Япон мэргэжилтнүүд 2 улсын хамтын ажиллагааг Япон төвийг анх үүсгэн байгуулж байсан сэтгэлгээг эргэн дурслаа.

Энэхүү мартагдашгүй жилд 2022 оны хаврын гадаад иргэдэд зориулсан “Мандах нарны одон, хүзүүний тууз бүхий алтан туяа” шагналыг Ц.Даваадорж захирал хүртлээ.

Энэ нь Япон төвийн үйл ажиллагааг та бүхэн ойлгож, дэмжисэний үр дүн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн гэж бодож байна. Та бүхэнд талархал илэрхийлье.

Энэхүү тэмдэглэлт жилд 2 улсыг холбох үйл ажиллагаа болох бизнес форум, Япон фестивал Монголд 2019 оноос хойш 3 жилийн дараа үндэсний соёл амралтын хүрээлэнд зохион байгуулагдлаа. 2 үйл ажиллагаа нь тотвортой хөгжлийн зорилтын хүрээнд 2 улсын холбогдох байгууллага, холбоо, компани нь нэгдэж амжилттай зохион байгууллаа.

Зохион байгуулагчдын нэг болох Япон төвийн төсөлд холбогдох хүний хувиар талархал илэрхийлж байна.

2022 онд төвийн үйл ажиллагаа нь халдвар хамгааллын дэглэмийг баримтлангаа ковид19-ийн өмнөх үетэй адил сэргэж ирлээ. Ковид19-ийн халдварын үед ч судалгаа хийгдэж ирсэн анх удаа орон нутагт сургалт явуулах төсөл нь Эрдэнэт хотод зохион байгуулагдлаа. Энэ нь төвийн ажилчдын санаачлагаар төлөвлөж биелэсэн юм. Түүнчлэн хүний нөөцийн карьер дэмжлэг гэсэн шинэ зорилт ЖАЙКА-ийн төсөлд нэмэгдсэн. Энэ хөтөлбөрт Японд ажиллахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой Япон явахаас өмнө болон Монголд буцаж ирсний дарааг хүртэлх иж бүрэн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.

Япон байгууллагад Монголын хүнийг нөөцийг ашиглах болон Монголд буцаж ирсний дараа үр өгөөжөө өгөх, 2 улсын найрсаг харилцааг улам хөгжүүлэх гүүр болох хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр болгохоор ажиллаж байна.

Одоогийн ажлаа 1 жилийн хугацаанд Японоос алсаас ажиллаж, 2 жил Монгол улсад ажиллаж томилогдсон хугацаа энэ оны 4 сард дуусаж байна. Монгол улсад ажилласан 2 жилд бизнесийн сургалтын төгсөгчидтэй уулзаж, байгууллагаар айлчлах зэргээр дамжуулан Япон төвөөс үзүүлж буй үйлчилгээ нь зөв болохыг ойлгосон.



Төвийн үйлчилгээ, үйл ажиллагааны хувьд Ц.Даваадорж захирал тэргүүтэй шинэ санаа санаачилга байнга гаргаж байдаг япон төвийн ажилтнууд, мэргэжилтэн, багш нарын өдөр бүрийн уйгагүй хөдөлмөр, МУИС, Боловсрол шинжлэх ухааны яам, Хөдөлмөр нийгмийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг жижиг дунд үйлдвэрийн газар, Монголд дахь Япон улсын элчин сайдын яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрлэлийн тэнхим, Япон сан, ЖАЙКА зэрэг Монгол Японы холбогдох байгууллагын тусламж дэмжлэгээр Япон төвийн үйл ажиллагаанд оролцогчдоос сэтгэл ханамжийн өндөр үнэлгээ аваад байна.

Япон төв нь 2 улсын хүн, соёл, бизнесийн хамтын ажиллагааны төв болж улам хөгжиж “Монголын ирээдүйг хөгжүүлэх байгууллага” болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэнээр 2 улсаас “хүлээлт үүсгэсэн төв” болно гэдэг итгэлтэй байна. Та бүхнийг цаашид ч бас Япон төвөөр үйлчлүүлж туслаж дэмжихийг хүсэж байна.

Ковид19 болон дэлхийн ээдрээтэй нөхцөл байдал байгаа боловч та бүхнийг хүнд хэцүү нөхцөл байдлыг даван туулж эрүүл саруул, илүү амжилт гаргаасай гэж чин сэтгэлээсэй хүсэж байна.

**Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх
(ЖАЙКА-ийн мэргэжилтэн) Ониши Ёшифүми**



ЯПОН САНГИЙН ЯПОН ХЭЛНИЙ МЭРГЭЖИЛТЭН ЦҮРҮТА ЯСҮЮКИ



2022 оны 3 сараас тус төвийн япон хэлний сургалтын тасагт Япон сангийн япон хэлний мэргэжилтэн Цүрүта Ясүюки томилогдон ажиллахаар боллоо. Цүрүта мэргэжилтний хувьд Япон сангийн япон хэлний мэргэжилтнээр Узбекистан улс дахь Узбекистан-Японы төв, Италийн Ром хот дахь Японы соёлын төвд Япон сангийн япон хэлний сургалтын үйл ажиллагаа болон япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд гар бие оролцож ирсэн. Цаашид тус төвийн япон хэлний сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалт үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож ажиллахын зэрэгцээ Монгол дахь япон хэлний боловсролын хөгжил дэвшил болон япон хэлний боловсролоор дамжуулан соёлын харилцааг гүнзгийрүүлэх ажлуудад хүчин зүтгэх болно.

I. БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ





1.2022 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН БИЗНЕСИЙН СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Бизнесийн сургалтын тасаг нь бизнесийн төрөл бүрийн сургалт, семинар, зөвлөгөөг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгтэйгээр Монголын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж байна. 2022 оны эхэн үед коронавируст халдварын нөхцөл байдал төдийлөн буураагүй байсны улмаас япон мэргэжилтэн багш нар биечлэн ирэх боломжгүй, мөн халдвар хамгааллын үүднээс танхимын сургалтыг цөөн тооны хүнтэйгээр цахим танхим хосолсон сургалтыг тус оны 6 сар хүртэл зохион байгууллаа. Мөн 9 сараас танхимаар сургалт зохион байгуулах боломжтой болсон төдийгүй япон мэргэжилтэн багш нар монголд биечлэн ирэх боломж бүрдэж сургалтуудыг бүрэн танхимаар зохион байгуулж эхэллээ.

Бизнесийн үндсэн сургалтыг Удирдлагын ангид 6 сэдвээр, Менежерийн ангид 4 сэдвээр, Эрдэнэт хотод 5 сэдвээр нийт 21 удаа, бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг 8 сэдвээр 9 удаа, ахисан түвшний сургалтыг 7 сэдвээр 8 удаа, бизнесийн нээлттэй семинарыг 7 сэдвээр 8 удаа, ажлын байран дээрх сургалтыг 18 компани дээр 33 удаа амжилттай зохион байгууллаа. 2022 оны нийт сургалтад 2735 хүн хамрагдсан байна. Монгол-Японы төвийн бизнесийн сургалтуудыг арвин туршлагатай япон, монгол багш нар удирдан явуулж, бизнест бодитоор тус болохуйц мэдлэг олгодгоороо давуу талтай. Суралцагчдын 90-ээс дээш хувь нь сургалтыг өндрөөр үнэлэн, сургалтаас сурсан, мэдсэнээ ажлын байран дээрээ хэрэгжүүлж байна.

Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт

1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт”

1. Бизнесийн сургалтын тасгийн **үндсэн сургалт** болох “Жижиг, дунд аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах оношилгоо зааварчилгаа, шинжилгээ” сэдэвт бизнесийн практик сургалтыг суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн жилд хоёр удаа (намар, өвлийн элсэлт) зохион байгуулдаг. Тус сургалтын зорилго нь зах зээлийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болохуйц хүний нөөцийг хөгжүүлж, Монголын аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, цаашлаад Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.



Зураг 1. “Санхүүгийн удирдлага” сургалтын явцаас



Бизнесийн үндсэн сургалтын суралцагчдыг удирдлагын болон менежерийн гэсэн хоёр ангид элсүүлэн, стратегийн менежмент, маркетинг, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн удирдлага гэсэн менежментийн үндсэн 4 сэдвээр зохион байгуулдаг бөгөөд удирдлагын ангид нэмэлтээр “Япон маягийн менежмент”, “Комплаенс” сэдэвт хоёр сургалт, анх удаа орон нутагт зохион байгуулагдсан Эрдэнэт хотын ангид “Үйлдвэрлэлийн удирдлага” сургалт нэмэлтээр орсноороо онцлог боллоо.



Зураг 2. Бизнесийн үндсэн сургалтын Удирдлагын ангийн “Стратегийн менежмент” сургалтын явцаас

Энэ жил коронавируст халдварын цар тахлаас сэргийлэн тогтоосон хязгаарлалтуудын улмаас тус сургалт нь 2022 оны 1 сараас 6 сар хүртэл цахим, танхим хосолсон хэлбэрээр, 9 сараас хойш бүрэн танхимаар амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

2021 онд сургалтууд цахимаар зохион байгуулагдаж орон нутгаас оролцох оролцогчдын тоо нэмэгдсэн учир энэ онд орон нутаг руу чиглэсэн сургалтаа өргөжүүлж Эрдэнэт хотод анх удаа зохион байгууллаа. Сургалтыг 6 сар хүртэл япон мэргэжилтэн багш нар цахимаар холбогдон үндэсний сургагч багш нарын хамтаар удирдан явуулсан ба Монгол-Японы төвийн зүгээс техник технологийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэн, цахимын болон танхимын суралцагчид хоорондоо жигд харилцаатай суралцах боломжийг хангахын тулд хичээн ажиллалаа. Энэ онд сургалтад компани, аж ахуйн нэгжийн нийт 135 удирдах албан тушаалтан, менежер хамрагдлаа.


Монгол-Японы төв нь үндсэн сургалтаас гадна суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ахисан түвшний болон суурь мэдлэгийн сургалтыг зохион байгуулдаг.

2. Ахисан түвшний сургалтыг “KPI болон чадамжийн удирдлага” “Хүний нөөцийн удирдлага” “Санхүүгийн удирдлага” “Дэлгүүрийн удирдлага” сэдвээр цахим болон хосолсон хэлбэрээр, “Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь” “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Датад суурилсан маркетинг” сэдвүүдийг бүрэн танхимаар зохион байгуулж, нийт 242 хүн хамрагдсан байна.



Зураг 3. Ахисан түвшний сургалтын явцаас

Манай төвийн бизнесийн сургалтыг бизнесийн бодит хэрэгцээнд нийцсэн агуулгаар, арвин туршлагатай япон болон монгол багш нар заадаг. Сургалтын дараах судалгаагаар суралцагчдын 93% нь сургалтыг өндрөөр үнэлсэн байна.



Зураг 4. Цахим, танхим хосолсон “Хүний нөөцийн удирдлага” ахисан түвшний сургалтын хэсгээс

3. **Бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг** 2016 оноос эхлэн зохион байгуулж байна. 2017 оноос эхлэн бямба гарагт зохион байгуулдаг болсноор илүү олон компанийн удирдлага, менежерүүдэд амралтын нэг өдрөө менежментэд суралцан үр өгөөжтэй өнгөрөөх боломжийг бүрдүүлж өгсөн юм.



Энэ жилийн хувьд суурь мэдлэгийн сургалтуудын ойлголт, үр дүнг нэмэгдүүлэхийг зорьж доорх сэдвүүдээр бүрэн танхимаар зохион байгууллаа. “Санхүүгийн удирдлага” сэдвээр 2 удаа, “Дэлгүүрийн удирдлага”, “Маркетинг”, “Хүний нөөцийн менежмент”, “Төслийн менежмент”, “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Стратегийн менежмент”, “Япон маягийн менежментийг монгол удирдахуйн ухаантай хослуулах нь” сэдэвт сургалтуудыг тус бүр 1 удаа амжилттай зохион байгуулснаас гадна, халдвар хамгааллыг чандлан сахиж ажиллалаа. Тус сургалт нь нийт 9 удаагийн 8 сэдвээр сургалт явагдаж нийт 318 хүнийг хамрууллаа.



Зураг 5. “Санхүүгийн удирдлага” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт



Зураг 6. “Дэлгүүрийн удирдлага” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт

2) “Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”

Монголын компаниудад бизнесийн орчны өөрчлөлт, өрсөлдөөн нэмэгдэж байгаатай уялдан зөвхөн удирдах албан тушаалтнаа хөгжүүлээд зогсохгүй байгууллагын стратегид үндэслэн компанийг бүх талаар нь бэхжүүлэх, нийт ажилтнуудын мэдлэг, ур чадварыг ахиулахыг чухалчилж байна. Иймээс байгууллагын удирдах албан тушаалтныг сонгон, гаднын сургалтад хамруулахын зэрэгцээ компани дотроо олон төрлийн сургалтыг идэвхтэй зохион байгуулдаг болжээ.



Зураг 7. “Стратегийн менежмент” сэдэвт цахим сургалтын явц

Энэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тус төв нь аж ахуйн нэгжүүдийн менежментийн үр дүн, бүтээмжийг сайжруулах, хүний нөөцийн менежмент болон сургалт хөгжлийн системийг бий болгох зорилгоор ажлын байран дээрх сургалт, загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж монгол компаниудын оновчтой удирдлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхүү анхааран ажиллаж байна.



Ажлын байран дээрх сургалтад ЖАЙКА-ийн мэргэжилтэн болон үндэсний сургагч багш нар компанид тулгамдаж буй асуудлыг багаар хэлэлцүүлэх, дасгал ажиллуулах зэргийг хослуулан практик сургалтыг зохион байгуулж, 2022 онд давхардсан тоогоор нийт 19 компанийн 604 хүн хамрагдлаа. 2022 оны 6 сар хүртэл коронавируст халдварын цар тахлын нөлөөгөөр хил хаагдаж, япон мэргэжилтэн багш нар манай улсад томилогдон ирж ажиллах боломжгүй болсон боловч өмнөх жилүүдийн туршлага дээр үндэслэн цахим сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж ирсэн билээ. Япон мэргэжилтэн багш нар Японоос цахимаар холбогдож, орчуулагч багш нар болон сургалтын мэргэжилтнүүд тухайн байгууллагын ажлын байран дээр очиж сургалтыг чиглүүлэн, япон багш өөрийн биеэр ирэн сургалт орж буй мэт зохион байгуулсан нь энэ хичээлийн жилийн онцлох үйл явдал байлаа.



Зураг 8. “Хүний нөөцийн менежмент” сэдэвт Шинжлэх ухааны академи дээрх сургалт

“Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2021-2022 оны хичээлийн жилд сонгон шалгаруулалтыг явуулан нийт 5 компани шалгаруулсан боловч, коронавируст халдварын цар тахалтай холбоотой япон мэргэжилтэн багш нар Монгол улсад томилогдон ирж ажиллах боломжгүй байсан тул сургалт эхлэх хугацаа хойшлогдсон. Гэвч 2022 оны 9 сараас Япон мэргэжилтэн багш нар Монголд айлчлан ирэх боломжтой болж Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр үргэлжилж эхэлсэн байна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн 5 компанийн 1 компани нь өөрийн хүсэлтээр тус хөтөлбөрийг зогсоосон тул 2022-2023 оны хичээлийн жилд 4 компани дээр хөтөлбөр хэрэгжиж байна.



Зураг 9. Каппэ бэнэ Монголиа ХХК дээрх загвар аж ахуй нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрийн нээлт



3) ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТ

2022 оны 11 сард ЖАЙКА-ийн дадлага сургалтад 22 хүн хамрагдлаа.

Үнэ цэнийн гинжин хэлхээ (Value chain) сэдэвт сургалт явагдлаа.

Энэхүү дадлага сургалтад бизнесийн үндсэн сургалтаар суралцсан агуулгыг япон компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа бодит байдалтай танилцах, япон маягийн менежментийн үндэс болох кайзэн хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрч болохыг таниулах зорилгоор зохион байгуулж ирсэн. Энэхүү дадлага сургалтад 2003 оноос хойш Монгол-Японы төвийн үндсэн сургалтын нийт 186 төгсөгч хамрагдаад байна.

Энэхүү сургалтыг 2003 оноос 2019 оныг хүртэл жил бүр зохион байгуулж ирсэн боловч корона вируст халдварын цар тахлын улмаас 2 улсын хил хаагдаж зохион байгуулах боломжгүй байсан. Гэвч 2022 оноос 2 улсын хил нээгдэж сургалтыг эхлүүлэх боломжтой болсон боловч халдварын нөхцөл байдал хараахан намжаагүй хүлээн авах компаниуд нь цар тахлын эрсдэл доор монгол компаниудын төлөөллийг хүлээн авч өөрсдийн туршлага, мэдлэгээ харамгүй хуваалцсан, мөн сургалтын ахлах багш томилон онол практик хосолсон сургалт болсон гэдгээрээ өмнөх онуудаас онцлог боллоо.



Зураг 10. Тоёота автомат нэхмэлийн үйлдвэр дээрх айлчлалын үеэр



Хүснэгт1: Үндсэн сургалт Хосолсон Удирдлагын анги

№	Хичээлийн нэр	Хугацаа	Орол- цогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Япон маягийн менежмент	2022.01.10-11	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	- Японы эдийн засгийн хөгжлийн түүх - Корона вирусийн хямралаар Япон хүмүүсийн ойлгосон зүйлс - Япон компаниудын нийтлэг давуу талууд - Компанийн нийгмийн хариуцлага - Сэтгэлд гал асаах менежмент	Ямамото Нобутанэ	37
2	Комплаенс	2022.01.13-14		- Компанийн засаглалын ач холбогдол - Дэлхийн улс орнууд дахь компанийн засаглалын зарчим, чиг хандлага - Компанийн засаглалыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө ба материаллаг байдал - Санхүүгийн зах зээл дэх компанийн засаглалын үнэлгээ, хяналт	Адэгва Хиронобу	37
2	Стратегийн менежмент	2022.01.17-22		- Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл - BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM - Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги - Стратегийн менежмент ба KPI-д суурилсан компанийн гүйцэтгэлийн удирдлага - Жижиг дунд бизнесийн стратеги менежментийн жишээ	Кавагүчи Шиничиро, Н.Батдэлгэр	36
4	Хүний нөөцийн удирдлага	2022.02.21-26		- Хүний нөөцийн талаарх асуудлуудыг ойлгох нь - Менежментийн стратеги ба хүний нөөцийн стратеги - Гарах хаалганы стратеги - Хүний нөөцийн зураглалыг тодорхой болгох, байгууллагын бүтцийн загварчлал - Сонгон шалгаруулалт - Ур чадвар хөгжүүлэлт ба байгууллагын хөгжил - Хүний нөөцийн суурь тогтолцоо	Игараши Эй, Д.Дашмаа	36
5	Санхүүгийн удирдлага	2022.04.04-09		- Санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээ - Санхүүгийн шинжилгээний аргачлалууд - Санхүүгийн тайлангийн алдааг илрүүлэх нь - Удирдлагын нягтлан бодох бүртгэл - Менежментийг сайжруулах санхүүгийн шинжилгээ - Бизнес төлөвлөгөө болон компанийн ерөнхий зураглал	Такэгүчи Ёшихиро	35



3	Маркетинг	2022.04.18-23	• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллага дахь маркетингийн ач холбогдол • STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning) • Маркетингийн хольц (4P) • Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс: Хүн, биет нотолгоо, процесс • Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес • Зах зээлийн орчны шинжилгээнд үндэслэн маркетингийн стратеги боловсруулах нь	Үэхигаши Кожи, Б.Даваасүрэн	33
					214

Хүснэгт 2: Үндсэн сургалт Эрдэнэт хотын анги

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Стратегийн менежмент	2022.01.24-27	Жижиг дунд аж ахуйн нэгжийн дунд шатны албан тушаалтан	• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл • BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM • KPI-д суурилсан гүйцэтгэлийн удирдлагын стратеги • Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги • Стратегийн зураглал, нүдэнд харагдахуйц болгох	Кавагүчи Шиничиро, Н.Батдэлгэр	27
2	Хүний нөөцийн удирдлага	2022.02.28-03.03		• Ажлаас гаралтын бүтэц • Хүний нөөцийн удирдлагын систем • Хүний нөөцийн хөгжүүлэлт -Шинэ ажилтны чиглүүлэх сургалт -Ур чадвар хөгжүүлэх гол утга учир -Ажлын байран дээрх сургалт -Ажлын байрнаас гадуурх сургалт • Карьер хөгжүүлэлт -Карьер хөгжилд хүргэх албан тушаалын томилгоо • Харилцааны ур чадвар • Зөвшилцлийн үндсэн дээрх шийдвэр гаргалт • Манлайлал • Байгууллагын менежмент -Байгууллагын соёл -Байгууллагын шинэчлэл • Хүний нөөцийнүнэлгээ ба эргэх холбоо	Добаши Хаяато, Д.Дашмаа	26



3	Маркетинг	2022.04.25-28	• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллагад маркетингийн гүйцэтгэх үүрэг • STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning) • Маркетингийн хольц (4P) • Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс Хүн, биет нотолгоо, процесс • Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес • Бүтээгдэхүүний конус (Product Cone) -г ашиглан бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулах нь	Үэхигаши Кожи, Б.Даваасүрэн	25
4	Санхүүгийн удирдлага	2022.05.16-19	• Санхүүгийн шийдвэр гаргалт (Санхүүгийн богино хугацааны шийдвэр гаргалт, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, Санхүүгийн урт хугацааны шийдвэр гаргалт) • Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн тайлан, түүний бүтэц, уялдаа холбоо, хөрөнгийн эргэц, ашиглалт/ашигт ажиллагаа/төлбөрийн чадвар/бүтээмжийн шинжилгээ) • Зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарлын шинжилгээ (Хугарлын цэг/зорилтот ашиг/хамгаалалтын зааг/Борлуулалтын хольц ба зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарал/зардлын бүтэц ба хөшүүргийн шинжилгээ)	Ц.Баянмөнх	26
5	Үйлдвэрлэлийн удирдлага	2022.06.06-09	• TPS-ийн талаарх ерөнхий ойлголт • Just in time /Үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, 5S хөдөлгөөн/ • Автоматжуулалт/Үйлдвэрлэлийн процессыг сайжруулах/ • Чанарын баталгаа/SQC, 5 удаа яагаад шинжилгээ/ • Чанарын удирдлагын 7 арга хэрэгсэл • Үргүй зардлыг арилгах • Кайзэн-Сайжруулалт /7мүдэ/ • Зорилтын менежмент, хэрэгжүүлэх арга	Масүда Казүми	26
					130



Хүснэгт 3: Үндсэн сургалт Менежерийн анги

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Стратегийн менежмент	2022.10.03-07	Жижиг дунд аж ахуйн нэгжийн дунд шатны албан тушаалтан	- Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл - BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM - KPI-д суурилсан гүйцэтгэлийн удирдлагын стратеги - Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги	Кавагүчи Шиничиро, Н.Батдэлгэр	34
2	Хүний нөөцийн удирдлага	2022.10.24-28		- Ажлаас гаралтын бүтэц - Хүний нөөцийн удирдлагын систем - Хүний нөөцийн хөгжүүлэлт - Шинэ ажилтны чиглүүлэх сургалт - Ур чадвар хөгжүүлэх гол утга учир - Ажлын байран дээрх сургалт - Ажлын байрнаас гадуурх сургалт - Карьер хөгжүүлэлт - Карьер хөгжилд хүргэх албан тушаалын томилгоо - Харилцааны ур чадвар - Зөвшилцлийн үндсэн дээрх шийдвэр гаргалт - Манлайлал - Байгууллагын менежмент - Байгууллагын соёл - Байгууллагын шинэчлэл - Хүний нөөцийнүнэлгээ ба эргэх холбоо	Добаши Хаяато, Д.Дашмаа	33
3	Санхүүгийн удирдлага	2022.11.14-18		- Санхүүгийн шийдвэр гаргалт (Санхүүгийн богино хугацааны шийдвэр гаргалт, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, Санхүүгийн урт хугацааны шийдвэр гаргалт) - Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн тайлан, түүний бүтэц, уялдаа холбоо, хөрөнгийн эргэц, ашиглалт/ашигт ажиллагаа/төлбөрийн чадвар/бүтээмжийн шинжилгээ) - Зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарлын шинжилгээ (Хугарлын цэг/зорилтот ашиг/хамгаалалтын зааг/Борлуулалтын хольц ба зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарал/зардлын бүтэц ба хөшүүргийн шинжилгээ)	Ц.Баянмөнх,	33



4	Маркетинг	2022.12.12-16		• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллагад маркетингийн гүйцэтгэх үүрэг • STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning) • Маркетингийн хольц (4P) • Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс Хүн, биет нотолгоо, процесс • Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес • Бүтээгдэхүүний конус (Product Cone) -г ашиглан бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулах нь	Үэхигаши Кожиг, Б.Даваасүрэн	33
						133

Хүснэгт 4: Үндсэн сургалт Удирдлагын анги

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Япон маягийн менежмент	2022.09.19-20	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	• Удирдагч ямар байх ёстой вэ? • Захирлын албан тушаалын талаарх тогтсон ойлголтоо өөрчлөх • Корона вирусийн хямралаар Япон хүмүүсийн ойлгосон 3 зүйлс • Менежментийн 3 суурь	Ямамото Нобүтанэ	36
2	Комплаенс	2022.09.22-23		• Компанийн засаглалын ач холбогдол -Комплаенс болон Компанийн засаглалын ялгаа -Компанийн оролцогч талуудын итгэлцэл ба компанийн засаглал -Итгэлцлийг бий болгосон бизнесийн хөгжил -COVID-19 ба компанийн засаглал • Компанийн засаглалын зарчим • Компанийн засаглалыг бий болгох -Дэлхийн улс орнуудын компанийн засаглал -Тоёотагийн компанийн засаглал • Компанийн засаглал яагаад чухал байдаг вэ? • Компанийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар • ESG хөрөнгө оруулалтын үед компанийг хэрхэн үнэлж, шалгах вэ?	Адэгва Хиронобү	37



3	Стратегийн менежмент	2022.09.26-10.01	• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл • BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM • Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги • Стратегийн менежмент ба KPI-д суурилсан компанийн гүйцэтгэлийн удирдлага • Жижиг дунд бизнесийн стратеги менежментийн жишээ	Кавагүчи Шиничиро, Н.Батдэлгэр	37
4	Хүний нөөцийн удирдлага	2022.10.17-22	• Хүний нөөцийн талаарх асуудлуудыг ойлгох нь -Хүний нөөцийн асуудлууд -Төлөвлөгөөт эдийн засаг ба зах зээлийн эдийн засаг дахь хүний нөөцийн удирдлага • Менежментийн стратеги ба хүний нөөцийн стратеги -Байгууллагын чадавхид шинжилгээ хийх нь • Гарах хаалганы стратеги -Ажлаас гаралт болон тогтвор суурьшил • Хүний нөөцийн зураглалыг тодорхой болгох, байгууллагын бүтцийн загварчлал • Сонгон шалгаруулалт -Сонгон шалгаруулалтын стратеги -Ажлын зар • Ур чадвар хөгжүүлэлт ба байгууллагын хөгжил -Шинэ ажилтны чиглүүлэх сургалт -Ур чадварыг хөгжүүлэх гол утга учир -Ажлын байран дээрх сургалт -Ажлын байрнаас гадуурх сургалт -Байгууллагын соёл -Байгууллагын өөрчлөлт -Манлайллыг хөгжүүлэх нь • Хүний нөөцийн суурь тогтолцоо -Хүний нөөцийн суурь тогтолцоо гэдэг нь -Албан тушаалын шатлал -Үнэлгээний тогтолцоо -Цалингийн систем, хүний нөөцийн зардал	Добаши Хаяато, Д.Дашмаа	37
5	Санхүүгийн удирдлага	2022.11.07-12	• Санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээ • Санхүүгийн шинжилгээний аргачлалууд • Санхүүгийн тайлангийн алдааг илрүүлэх нь • Удирдлагын нягтлан бодох бүртгэл • Менежментийг сайжруулах санхүүгийн шинжилгээ • Бизнес төлөвлөгөө болон компанийн ерөнхий зураглал	Такэгүчи Ёшихиро	37



6	Маркетинг	2022.12.05-10	• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллага дахь маркетингийн ач холбогдол • STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning) • Маркетингийн хольц (4P) • Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс: Хүн, биет нотолгоо, процесс • Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес • Зах зээлийн орчны шинжилгээнд үндэслэн маркетингийн стратеги боловсруулах нь	Үэхигаши Кожи, Б.Даваасүрэн	37
					221

Хүснэгт 5: Суурь мэдлэгийн сургалт

No.	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Санхүүгийн удирдлага	2022.03.25-26 цахим танхим хосолсон сургалт	Компанийн шинэ ажилтан, гарааны бизнес эрхлэгчид	• Санхүүгийн удирдлага, түүний ач холбогдол • Санхүүгийн менежер хүний гаргах гол шийдвэрүүд • Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт • Хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шийдвэр гаргах үе шатууд • Төслийн мөнгөн гүйлгээг тооцох нь • Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн хэрэглээ • Төслийн үнэлгээний аргууд • Капиталын өртгийн тооцоолол • Хөрөнгө оруулалтын төслүүдээс ашигтайг сонгох нь	В.Данаасүрэн	21
2		2022.11.19				26
3	Дэлгүүрийн удирдлага	2022.04.29		• Дэлгүүрийн ангилал, төрөл • Дэлгүүрийн байгууламж - Гадаад орчны төлөвлөлт - Худалдааны талбайн төлөвлөлт • Барааны удирдлага - Мерчиндайзинг - Бараа өрөлт - Барааны хаяглалт	Ж.Гансүх	50
4	Маркетинг	2022.05.07		• Маркетингийн ач холбогдол • Глобал маркетингийн орчны өөрчлөлт, хувьсал • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллагад маркетингийн гүйцэтгэх үүрэг	Б.Даваасүрэн	37
5	Хүний нөөцийн менежмент	2022.06.04		• Хүний нөөцийн удирдлагын талаар суурь ойлголт • Хүний нөөцийн удирдлагын үндсэн функцууд - төлөвлөлт, - бүрдүүлэлт, - сонгон шалгаруулалт - үнэлгээ - сургалт хөгжил	Д.Дашмаа	33



				• Ажлын байрны манлайлал, идэвхжүүлэлт		
6	Төслийн менежмент	2022.06.10		• Төслийн тухай үндсэн ойлголт • Төслийн үе шатууд • Төслийн удирдлага арга, техник • Төслийн эрсдэлийн удирдлага	Б.Мөнхцог	33
7	Үйлдвэрлэлийн удирдлага	2022.06.18		• Тоёотагийн үйлдвэрлэлийн удирдлагын арга барил • Тоёотагийн 7 муда • Стандарт ажлын зааварчилгаа • Кайзэн • Загасны ясан диаграм • Чанарын долоон арга • VSM ба үнэ цэнийн урсгалын зураглал • TPM ба засварын нэгдсэн удирдлага	Н.Батчулуун	51
8	Стратегийн менежмент	2022.09.10		• Өнөөгийн бизнесийн орчин (Нөлөөлөл, технологийн дэвшил) • Менежментийн үндэс - Байгууллага, менежмент, менежер - Төлөвлөлт, зохион байгуулалт - Манлайлал, хяналт • Стратегийн менежмент - Нөхцөл байдлын шинжилгээ - Стратеги боловсруулах - Стратеги хэрэгжүүлэх - Стратегийн хэрэгжилтийг үнэлэх	Д.Энх-Отгон	26
9	Япон маягийн менежментийг монгол удирдахуйн ухаантай хослуулах нь	2022.10.15		• Менежментийн зорилгын тухай үндсэн ойлголт • Япон маягийн менежментийн онцлог • Үйлдвэрлэлийн пирамид ба 5S-ийн тухай суурь ойлголт • Монгол маягийн менежментийн онцлог • Ашгийг бүтээгч хүнээ сайжруулах нь • Япон маягийн менежментийг хэрэгжүүлэхэд гарсан алдаа, онооны туршлагаас суралцах нь	Ж.Хишигжаргал	41
						318



Хүснэгт 6: Ахисан түвшний сургалт

№.	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	КРІ ба Чадамжийн удирдлага	2022.02.14-18 Цахим, танхим хосолсон сургалт	КРІ-ийг хэрэгжүүлж буй байгууллагын удирдах албан тушаалтан, хүний нөөцийн менежер, бизнесийн зөвлөхүүд	- Хүний нөөцийг болон байгууллагыг үр дүнтэй удирдаж, ажиллуулах КРІ-ийн удирдлага - Японы компаниудын КРІ-ийн удирдлагын жишээ - Менежментийг харагдахуйц болгох арга хэрэгсэл болох КРІ-ийн удирдлага - КРІ-ийг хэрэгжүүлж буй Монгол компанийн жишээ - КРІ болон чадамжийн гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдсан цалин, урамшууллын дизайн	Кавагүчи Шиничиро	44
2	Хүний нөөцийн удирдлага	2022.03.28-04.01 Цахим, танхим хосолсон сургалт	Компанийн удирдах түвшний албан тушаалтан болон хүний нөөцийн менежер	- Стратегийн менежмент ба хүний нөөцийн стратегийн уялдаа - Хүний нөөцийн суурь тогтолцоог бүрдүүлэх нь - Хүний нөөцийн үнэлгээ - Хүний нөөцийн хөгжил - Манлайлал ба байгууллагын хөгжил	Ямазаки Кёоко	31
3	Санхүүгийн удирдлага	2022.04.11-15 Цахим, танхим хосолсон сургалт	Компанийн удирдах албан тушаалтан, нягтлан бодогч, санхүүч	- Санхүүгийн тайлангууд - CFM (Мөнгөн урсгалын менежмент) - Өртөг тооцох - Санхүүгийн шинжилгээ - Хугарлын цэгийн шинжилгээ: - Санхүүгийн тайлан ба санхүүгийн шинжилгээ - Санхүүгийн НББ ба Удирдлагын НББ - Үйл ажиллагаагаа сайжруулахад санхүүгийн шинжилгээг хэрэглэх нь: - Бизнес төлөвлөгөө ба компанийн ерөнхий зураглал - Бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлал	Такэгүчи Ёшихиро	35
4	Дэлгүүрийн удирдлага	2022.05.23-27 Цахим, танхим хосолсон сургалт	Дэлгүүр, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэгч, удирдах албан тушаалтан, менежер зохион байгуулагч	- Дэлгүүр байгуулах - Бараа өрөлт - Хэрэглэгчийн удирдлага - Борлуулалтыг нэмэгдүүлэх стратеги - Борлуулалтыг идэвхижүүлэх тусгай арга хэмжээ - Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь - POP, зар сурталчилгаа	Үэхигаши Кожи	28
5	Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь	2022.06.27-29	Байгууллагын удирдах албан тушаалтан, менежер, нягтлан бодогч	- Санхүүгийн загварчлалын үндсэн техник - Ашгийг таамаглах загвар боловсруулах - Санхүүгийн тайланг ашигласан санхүүгийн загвар - Санхүүгийн загварыг боловсруулах - Хугарлын цэгийн шинжилгээ - Компанийн үнэ цэнийн үнэлгээний аргазүй - Компанийн үнэ цэнийн үнэлгээний загвар боловсруулах	Н.Батдэлгэр	38
6	Үйлдвэрлэлийн удирдлага	2022.09.12-16	Үйлдвэрлэлийн салбарт бизнес	Үйлдвэрлэлийн удирдлагын ерөнхий ойлголт	Масүда Казүми	36



			эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтан, менежер	• Чанарын удирдлага • QC-н 7 арга хэрэгсэл /Чанарын удирдлагын/ • Япон маягийн менежментийн аргачлал • 5S үйл ажиллагаа хэрэгжилт • Үйлдвэртэй танилцах		
7	Датад суурилсан маркетинг	2022.11.29-12.02	Компанид байгаа датаг бизнесээ өргөжүүлэх, амжилттай явуулахад үр дүнтэйгээр ашиглах маркетингийн аргачлалд суралцахыг хүссэн хүн бүр	• Дижитал шилжилт (DX) • Цахим худалдааны үүсэл хөгжил болон хэрэглэгчийн датаг цуглуулах • Вэб сайт үүсгэх аргачлал • Бизнес дата шинжилгээ • Датаг цуглуулах нүдэнд харагдахуйц болгох • Дата шинжилгээ хийх аргачлал • Конжойнт шинжилгээний тухай • Кросс нэгтгэлийн тухай	Фүкүёо Казүхиро	30
						242

Хүснэгт 7: Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр

№	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хөтөлбөрийн агуулга	Хөтөлбөрт хамрагдах хугацаа	Давтамж
					Оролцогчдын тоо
2022-2023 оны загвар аж ахуйн нэгж	Дэнимон ХХК	Хувцас, деним үйлдвэрлэл	1. Маркетинг борлуулалтын стратегийг сайжруулах	2022.9-2023.6	Багшийн Монголд айлчлах хугацаанаас болж хоцорсон
			2. Японы дэлгүүрийн удирдлагын арга барил суралцах		
	Премиум палас ХХК	Зочид буудал, ресторан	1. Ажилтнуудын сэтгэл ханамжийг хадгалах буюу сайжруулах, цаашлаад тогтвор суурьшилтай болгох	2022.9-2023.6	Багшийн Монголд айлчлах хугацаанаас болж хоцорсон
	Диасис Монголиа ХХК	Эмнэлэгийн тоног төхөөрөмж импорт худалдаа	1. Үйл ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн страги төлөвлөгөө	2022.9-2023.6	Багшийн Монголд айлчлах хугацаанаас болж хоцорсон
			2. Системчлэгдсэн маркетинг төлөвлөгөө		
	Каппэ бэнэ Монголиа ХХК	Кафе, хүнсний үйлдвэрлэл	1. Хүний нөөцийн менежментийг сайжруулах, ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх замаар тогтвор суурьшилтай болгох	2022.01 - 2023.06	Багшийн байдлаас болж хойшлогдсон
			2. Үйлдвэрлэлийн удирдлагыг системтэйгээр хөгжүүлэх		



Хүснэгт 8: Ажлын байран дээрх сургалт

№	Компанийн нэр	Сургалтын нэр	Хугацаа	Багшийн нэр	Оролцогчдын тоо
1	Астра катеринг ХХК	Үйлчилгээний ёс зүй	2022.01.13	Ж.Гансүх	32
2	Соёолон интернэйшнл ХХК	Стратегийн менежмент	2022.01.17, 20	Кавагүчи Шиничиро	9
3	Соёолон интернэйшнл ХХК	Санхүүгийн удирдлага	2022.02.10, 11, 14	Такэгүчи Ёшихиро	12
4	Инвескор ББСБ ХК	КРІ ба чадамжийн удирдлага	2022.02.16	Кавагүчи Шиничиро	11
5	Улаанбаатар төмөр зам ТӨХК	5S хэрэгжүүлэх нь	2022.02.18	Ш.Алтанхуяг	25
6	Марчаахай ХХК	Хүний нөөцийн менежмент	2022.04.08	Д.Дашмаа	9
7	Соёолон интернэйшнл ХХК	Хүний нөөцийн менежмент	2022.04.15, 19	Ямазаки Кёоко	9
8	Ариг Аня ХХК	Үйлчилгээний ёс зүй	2022.05.08	Ж.Гансүх	79
9	Хаан даатгал ХХК	5S хэрэгжүүлэх нь	2022.05.20	Ж.Хишигжаргал	29
10	Амуулай ХХК	Хүний нөөцийн менежмент	2022.06.18	Д.Дашмаа	13
11	Мэттлэ спэйс ХХК	Хүний нөөцийн менежмент	2022.08.22	Д.Дашмаа	14
12	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Цагийн менежмент, Хүний нөөцийн менежмент	2022.10.06	Д.Дашмаа	15
13	Фитафит инвест ХХК	SWOT шинжилгээ	2022.10.07	Кавагүчи Шиничиро	30
14	Ричвелл инженеринг ХХК	Цагийн менежмент	2022.10.18	Д.Дашмаа	26
15	Платинум ланд ХХК	Хүний нөөцийн менежмент	2022.10.20	Добаши Хаяато	10
16	Наран молл ХХК	Стратегийн менежмент	2022.11.02, 05	Н.Батдэлгэр	66
17	Байгалийн чулуун хийц	5S хэрэгжүүлэх нь	2022.11.15	Д.Долгормаа	41
18	Захиралуудын клуб	Цагийн менежмент	2022.11.23	Д.Дашмаа	14
19	Монгол улсын их сургууль	Digital driven marketing	2022.12.02	Фүкүё Казүхиро	10
20	Жүр үр ХХК	Дэлгүүрийн удирдлага	2022.12.05	Ж.Гансүх	30
21	Платинум ланд ХХК	Маркетинг	2022.12.06, 07	Үэхигаши Кожигү	9
22	Наран молл ХХК	Хүний нөөцийн менежмент	2022.12.09	Д.Дашмаа	21
23	Шинжлэх ухааны академи	Хүний нөөцийн менежмент	2022.12.21-23	Д.Дашмаа	90
					604



Хүснэгт 9: Тусгай сургалт, бизнесийн нээлттэй семинар

№	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Багш	Хамрагдсан хүний тоо
1	Эрдэнэт хотын бизнес эрхлэгчид зориулсан нээлттэй семинар	2022.3.2	Д.Дашмаа	36
2	Бизнесийн нээлттэй семинар	2022.4.22	Үэхигаши Кожи	84
3	Төгсөгчдөд зориулсан нээлттэй семинар	2022.5.14	Н.Батдэлгэр Ж.Хишигжаргал Д.Дашмаа	34
4	Бизнесийн нээлттэй семинар	2022.5.20	Үэхигаши Кожи	63
5	Эрдэнэт хотын бизнес эрхлэгчид зориулсан нээлттэй семинар	2022.6.7	Масүда Казүми	40
6	Эрдэнэт хотын бизнес эрхлэгчид зориулсан нээлттэй семинар	2022.5.20	Накамура Ко	9
7	Монгол Японы найрамдлын нийгэмлэг	2022.6.7	Ониши Ёшифүми	110
8	JUGAMO TALKio	2022.6.8	Ониши Ёшифүми	80
Нийт				456

Хүснэгт 10: Япон дахь дадлага сургалтад оролцогчдын нэрс

1. Бизнесийн үндсэн сургалт төгсөгчид

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
1	Г.Алтанхуяг	Захирал	Хүүгийн гутал ХХК
2	Д.Насанбат	Дэд захирал	Каппэ Бэнэ Монголиа ХХК
3	Н.Түмэннаст	хамтран үүсгэн байгуулагч, үйл ажиллагаа хариуцсан захирал	Зочил технологи ХХК
4	Г.Бат	ТУЗ-ийн орлогч дарга	Эвсэг ХХК
5	Г.Пүрэвсүрэн	Ерөнхий захирал	Жинст цамхаг ХХК
6	Г.Бямбасүрэн	Захирал	Цагаан Асгат ХХК
7	С.Сувд-Эрдэнэ	Захиргаа, хүний нөөцийн газрын захирал	Монкон Констракшн ХХК
8	Д.Солонго	Гэрээт борлуулагч	Бодиз Автомотив ХХК
9	Х.Даваахүү	Гүйцэтгэх захирал	Загасан нүд-Загастай ХХК
10	Н.Мааний	Маркетингийн албаны дарга, Ерөнхий менежер	Хасэбэ интернэшнл ХХК
11	Г.Золбаяр	Захирал	Эй Эс Системс ХХК
12	Э.Батбилэг	Захирал	Эм Эн Ти ХХК
13	Н.Билгүүн	Гүйцэтгэх Захирал	Эм Би Фэйшн ХХК
14	С.Оюун	Киченолл салбар компаний гүйцэтгэх захирал	Долоонболдог ХХК
15	Б.Очирням	Үүсгэн байгуулагч, захирал	Түмэнторго ххк
16	Ч.Энхжаргал	Борлуулалт хариуцсан захирал	Эндлесс энерги ХХК

2. 2019-2020 оны Загвар аж ахуйн нэгж

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
17	Г.Ундрал	Жуулчны бааз хариуцсан захирал	Хаан Жимс Эс БиТи ХХК
18	Б.Мартжаргал	Санхүү, хүний нөөц хариуцсан дэд захирал	Монхорус интернэшнл ХХК
19	П.Гантулга	Гүйцэтгэх захирал	АВТО СООС ХХК

3. Хамтын ажиллагаа

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
20	Ч.Энхбаяр	Бизнесийн сургуулийн захирал	МУИС
21	Н.Цолмонбаяр	Бизнес сургалтын тасгийн дарга	Монгол-Японы төв
22	Э.Тэнгис	Ерөнхий удирдлагын тасгийн дарга	Монгол-Японы төв



БИЗНЕСИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

График 1. 2002-2022 оны бизнесийн сургалт, үйл ажиллагааны нийт оролцогчдын тоо





График 2. 2017-2022 оны бизнесийн сургалтын чанарын үзүүлэлт





2.МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ НЬ

1) Коронагийн өмнөх үетэй харьцуулахад бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа илүү өргөжсөн

2017 оны 9 сараас албан ёсоор хэрэгжиж эхэлсэн Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа нь 5 дах жилээ үдэж гэж байна. Энэ хугацаанд дэлхий нийтийг хамарсан Ковид 19-ийн нөлөөгөөр 2020, 2021 оны зарим үеүүдэд Монгол Японы хоорондын бизнесийн хамтын ажиллагаа удааширснаар Япон төвийн бизнесийн хамтын ажиллагаа ч мөн адил 2019 оных шиг нөхцөл байдалдаа эргэн орж чадалгүй 2 жил өнгөрсөн. Гэсэн хэдий ч 2022 оны 5 сард нөхцөл байдал өөрчлөгдөн, Япон улсын хилээр нэвтрэх журамд Монгол улс нь Омикрон давамгайлсан улс-бүс нутагт хамаарахгүй гэж заагдсан. Энэ нь хоёр орны хооронд зорчих хөдөлгөөн идэвхжих шалтгаан болсоныг Монголын статистикийн хорооны тоо баримт (доорх график) харуулж байна. 2022 оны 3-р улиралд¹ сүүлийн 3 жилд анх удаа зорчигсдын тоо 5000-г давлаа. Коронагийн өмнөх нөхцөл байдалд хараахан хүрэхгүй, 2019 оны мөн үеийнхээс зорчигсдын тоо 5 дахин бага байгаа ч Япончуудын Монгол орныг үзэх сонирхол дахин нэмэгдэж байгаа нь харагдаж байна.²

График 3. 2019-2022 оны хооронд Монгол руу зорчсон Япон хүмүүсийн тоо



Ийнхүү Монгол руу зорчигсдын тоо нэмэгдсэнтэй уялдан Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн Бизнесийн хамтын ажиллагаа ч мөн дахин сэргэсэн гэж 2022 оныг нэгтгэн дүгнэж болох болов уу.


¹ Графикт I: 1-р хагасыг илэрхийлж II,III,IV нь тус бүр 2, 3, 4-р хагас

² Монгол руу зорчсон Япон хүмүүсийн тоог Монголын статистикийн хорооны датад үндэслэн өөрөө хийв



Бизнесийн хамтын ажиллагааны хүрээнд мэдээллийн түгээлт, танигдалтыг хэмжих үзүүлэлтийг уулзсан үйлчлүүлэгчдийн тоогоор³ илэрхийлдэг.

График 4. Бизнес хамтын ажиллагааны хүрээнд зөвлөгөө, уулзалт хийсэн үйлчлүүлэгчдийн тоо (2019, 2022 оны харьцуулалт)



Дээрх график нь 2019 болон 2022 онд хийсэн уулзалтын тоог харьцуулсан график болно. 2022 оны хувьд хилээр нэвтрэх хязгаарлалт зөөлөрч, 4 сараас уулзалтын тоо огцом нэмэгдсэнээр 2019 оны гүйцэтгэлээс хол давсан байна. 9-11 сард Япон төвтэй үйл ажиллагааны гэрээ хийсэн компани, байгууллагын хүмүүс олноор Монголд айлчлал хийсний улмаас уулзалт хийж чадаагүй тохиолдол гарах хэмжээний үзүүлэлттэй байсан. Дараагийн хуудаст байгаа графикт харагдаж байгаагаар, сүүлийн 5 жилд хийсэн уулзалтын тоонд гарсан өөрчлөлтийг харахад ч 2022 оны уулзалтын нийт тоо нь 2019 оны гүйцэтгэлийн 160%-тай тэнцэж байна.

³ Энд дурдагдаж буй уулзалт гэдэг нь танхимаар эсвэл цахимаар гэсэн 2 хэлбэрээр, зөвлөгөө болон лавлагаанд хариулан, гэрээт ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотой хийсэн хурлын тоо



Төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг Япон төвийн Бизнесийн хамтын ажиллагааны орлого өнгөрсөн жилүүдээс хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан.

Эдгээр үр дүн нь зөвхөн Монгол руу зорчигсдын тоо нэмэгдсэнтэй холбоотой биш бөгөөд Бизнесийн хамтын ажиллагааны 2 жилийн турш тогтвортой хийсэн таниулан сурталчлах үйл ажиллагаа, үйлчилгээний чанарын сайжруулалт зэрэг олон шалтгааныг нийлүүлсэн үр дүн юм.

Гэхдээ хоёр улсын хоорондын зорчих хөдөлгөөн ихэссэн нь цаашид Япон Монголын бизнесийн хамтын ажиллагааны хөгжлийн томоохон шалтгааны нэг болох нь гарцаагүй бөгөөд цаашдаа ч өсөн дэвжих боломжтой үйл ажиллагаа гэж бодож байна.

График 5. Өнгөрсөн 5 жилд хийсэн уулзалтын тоон үзүүлэлт



2) Монголд зохион байгуулагддаг Япон-Монголын бизнесийн хамгийн том арга хэмжээ болох “Япон-Монголын Бизнес Форум” болон 3 жил завсарласны дараа “Япон фестиваль Монголд 2022” нэрийн дор зохион байгууллаа

2022 оны 8 сарын 19-нд Монгол - Японы Бизнес Форум анх удаа, 8 сарын 20, 21-ны хоёр өдрийн турш “Япон фестивал Монголд” 3 дах удаагаа зохион байгуулагдлаа. Япон төв нь уг хоёр үйл ажиллагаанд хамтран зохион байгуулагчийн хувиар төлөвлөлтийн үе шатнаас нь идэвхтэй оролцож, гол үүргийг гүйцэтгэсээр ирсэн билээ.

Энэ удаад Япон улсын хилээр нэвтрэх журам хөнгөвчлөгдөөд гуравхан сар болж байсан ч тус хоёр арга хэмжээнд Япон улсаас олон хүмүүс ирж оролцон өргөн дэлгэр болж өндөрлөсөн юм.

Энэ удаагийн Бизнес форумд Монголд бизнес эрхэлж буй болон цаашдаа Монголын зах зээлд нэвтрэхээр төлөвлөж буй хүмүүс голчлон, маш бодитой бөгөөд оновчтой агуулгатай сэдвүүдээр илтгэл тавих хэлбэрээр явагдсан. Өдийг хүртэл олон байгууллагууд нэг дор нэгдэн бизнесийн арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулж байсан тохиолдол Монголд ховор байсан бол энэ удаад 3 ерөнхий зохион байгуулагч, 6 хамтрагч байгууллагууд голчлон нарийн төлөвлөгөө гарган, зохион байгуулсан маш онцгой хэлбэртэй арга хэмжээ болсон юм.

Түүнчлэн Японы Эдийн засаг аж үйлдвэрлэлийн яамнаас болон гадаад дотоодын 7 байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдлаа. Уг үйл ажиллагааг цахимаар давхар шууд дамжуулан Японоос болон Монголын хөдөө орон нутгаас ч хамрагдах боломжтой байхаар шийдэж өгсөн юм.



Зураг 11. Монгол Японы бизнес форумын үеэр

Эцсийн байдлаар 450 хүн биечилж оролцон, цахимаар үзэгчдийн нийт тоог гаргаж чадаагүй ч, тухайн цагт зэрэг үзэж буй үзэгчдийн тоо 150-аас их байснаас харахад хамгийн багадаа нийт 600 хүн оролцлоо. Оролцогчдоос өндөр үнэлгээ авсан бөгөөд цаашдаа зохион байгуулахыг хүссэн дуу хоолой их байсан тул үргэлжлүүлэн зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хийж байна.

Бизнес форумын дараа “Япон фестивал Монголд” фестивал 8 сарын 20, 21-ний хоёр өдөр зохион байгуулагдлаа. Уг фестивал нь бизнес форум шиг бизнест чиглэсэн арга хэмжээ биш, Япон соёлыг таниулах, Япон улсыг бүхэлд нь Монголчуудад таниулж, танилцуулах зорилготой арга хэмжээ юм. Түүнчлэн оролцсон Япон хүмүүст Монголыг таниулах зорилготой арга хэмжээ ч гэж бас хэлж болно. 2019 онд анх удаа байгуулахад 2 өдрийн турш 8000 орчим Монголчууд хүрэлцэн ирсэн. 2022 оны фестивалийн хувьд цахимаар давхар зохион байгуулсан нь илүү олон буюу 11,500 хүн ирж, маш өргөн дэлгэр болж өндөрлөлөө.



Зураг 12. Япон фестивал Монгол үйл ажиллагааны үеэр



Асрын хувьд нийт 90 асар гарсан. Монголд албан ёсоор Японы бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж буй компани байгууллагуудаас гадна Японоос хүрэлцэн ирж оролцсон компани, Японы томоохон Карригийн сүлжээ ресторан туршилтын журмаар асар нээсэн тохиолдол ч байсан нь Японы байгууллагууд Монголыг сонирхох нь нэмэгдэж байгааг харж болохоор байлаа. Мөн асруудад ирэх зочид ихтэй, хөл хөдөлгөөн ихтэй байснаас хүний хөдөлгөөн хүндрэлтэй байснаас Монгол хүмүүсийн Япон орныг сонирхох сонирхол их байгааг илтгэж байлаа.

2023 оны 8 сарын 18-нд Бизнес форум, 8 сарын 19, 20-нд “Япон фестивал Монголд” фестивалийг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

“Япон фестивал Монголд 2023” фестивалийн хувьд 2022 оны фестивалиас илүү олон Япон компани байгууллага, зочид оролцоно гэсэн хүлээлттэй байна. 2023 оны 1 сарын байдлаар асар гаргах хүсэлтэй болон тайзны үзүүлбэрээр оролцох хүсэлт хэд хэд ирээд байна.

Бизнесийн хамтын үйл ажиллагааны хувьд уг хоёр арга хэмжээгээр дамжуулан үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхийн зэрэгцээ Монгол-Япон төвийн уриа болох “Монгол Япон хоёр улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж, хамтын ажиллагааг дэмжих” гэсэн зорилгыг биелүүлэхэд уг арга хэмжээ бол томоохон боломж болж байдаг. Тиймээс Япон төв үйл ажиллагаагаа тэлэхийн тулд бие даан арга хэмжээнүүдийг тасралтгүй төлөвлөж зохион байгуулахад идэвхтэй оролцохоор төлөвлөж байна.



Зураг 13. Япон фестивал Монгол үйл ажиллагааны үеэрх Япон компанийн асар



Зураг 14. Япон фестивал Монгол үйл ажиллагааны үеэрх олон хүн цугларсан асар

3) Бизнесийн хамтын ажиллагаа болон гадаадын ажиллах хүчийг дэмжих хоёр ажиллагааны хамтарсан үр дүн

Монгол-Японы төв нь 2022 оны 4 сараас албан ёсоор Монголын хүний нөөцийн карьер дэмжлэг, Японд ажиллахыг дэмжих зорилготой төслийг эхлүүлж, Бизнесийн хамтын ажиллагааг хариуцсан Накамура мэргэжилтэнд Монголын хүний нөөцийг Японд ажиллахад дэмжих чиглэл албан ёсоор шинээр нэмэгдсэн.

Япон компаниудын хувьд гадаадын зах зээлд гарахад гадаад дах үйл бизнесийг хариуцах хүний нөөц нэн шаардлагатай боловч Японы ихэнх жижиг, дунд аж ахуйн нэгжийн захирлын ярианаас үзэхэд “компани дотроо гадаад зах зээлд гарах ажлыг даатгах хүний нөөц байхгүй” гэдэг шалтгаанаас үүдэн бизнесээ гадагш тэлэх боломжгүй” гэсэн асуудлууд түгээмэл байгаа нь ажиглагдсан. Ялангуяа, Монгол улс нь Японы хувьд нийтэд танигдаагүй Монгол хэлийг ашигладаг, Монголын талаарх мэдээлэл бага байдаг зэрэг шалтгаанаар Японы компаниудад зах зээл рүү нэвтрэхэд саад бэрхшээл тулгардаг.

Бизнесийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд энэ асуудлыг дэмжихээр ажиллаж байгаа ч яг албан ёсоор Монголын зах зээлд гарсаны дараах компанийн дотоод үйл



ажиллагаанд нарийн орж дэмжлэг үзүүлэх одоогоор боломжгүй юм. (Зурагт Ибараки мужид зохион байгуулсан Монголын хүний нөөцтэй холбогдох арга хэмжээний үеийг харуулав.)

Иймээс өөрийнх нь компанид ажиллаж байсан Монгол ажилтан нь гадаад зах зээлд нэвтрэх ажилд түүчээлэн оролцовол удирдлагуудын хувьд итгэлтэй түнш болох болов уу гэж бодож байна. Ур чадварын дадлагажигч ажилтан хүлээн авдаг байсан Японы компаниу тухайн ажилтнаа нутаг буцсантай холбогдуулан Монголд хөрөнгө оруулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн тохиолдол, байгуулсагдсан цагаасаа



Зураг 15. Ибараки мужид зохион байгуулсан Монголын хүний нөөцтэй холбогдох арга хэмжээний үеэр

эхлэн 15 жилийн турш ажшигтай ажиллаж байгаа тохиолдол ч бодитоор байна. Эдгээрээс харахад Бизнесийн хамтын ажиллагааны нэг хэсэг болон гадаад ажилчдыг хүлээх авах ажлууд нь өөр хоорондоо уялдаатай байна. Гэхдээ одоогийн байдлаар Монгол хүмүүсийн Японд ажиллаж хөдөлмөрлөж буй нөхцөл байдлыг харахад тийм ч таатай гэж хэлж болохооргүй байгаа нь бодит байдал юм. JICA нь “Хариуцлагатай гадаадын ажиллах хүчинг хүлээн авах платформ”-д гүйцэтгэгч байгууллагаар оролцож байгаа бөгөөд тус үйл ажиллагаа нь хариуцлагатай гадаадын ажиллах хүчнийг хүлээн авч, гадаад ажилчдаас “сонгогдсон Япон” болж, Япон-Монгол хоёр улсын эдийн засаг харилцан өсөж, хоёр талын харилцаа тогтвортой хэрэгжих нийгмийг бий болгож чадна гэсэн санаан дээр тулгуурлан хэрэгжиж байна. Япон төвийн Бизнесийн хамтын ажиллагааны ажил ч бас Монгол хүн Японд хөдөлмөр эрхлэхэд болон хоёр орны эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах Монгол хүний нөөцийг Японд ажиллахад Японы орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагуудтай хамтран дэмжин ажиллах болно.



3.ОНЦЛОХ МЭДЭЭ

1) Бизнесийн үндсэн сургалтыг анх удаа орон нутагт амжилттай зохион байгууллаа.

2020 оноос бизнесийн сургалтуудыг цахимаар зохион байгуулж ирснээс хойш хөдөө орон нутгаас хамрагдах хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа нь сургалтын эрэлт хэрэгцээ байна гэж Монгол-Японы төвийн зүгээс үзэж 2021 онд сургалтын эрэлтийн судалгаа Орхон аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран хийв. Эрдэнэт хотын байгууллагуудад нэн тэргүүнд тулгамдаж буй асуудал нь стратеги төлөвлөлт, хүний нөөц, үйлдвэрийн процесийг сайжруулах байсан тул байгууллагуудад зориулсан багц сургалтыг гаргаж 2022 оны 1 сараас 6 сарын хооронд “Стратегийн менежмент”, “Хүний нөөцийн менежмент”, “Маркетинг”, “Санхүү удирдлага”, “Үйлдвэрлэлийн удирдлага” гэсэн 5 сэдвээр ЖАЙКА-н дэмжлэгтэй зохион байгууллаа.

Тус сургалтад 11 компанийн 28 хүн хамрагдаж менежментийн олон ур чадваруудыг эзэмшихээс гадна Эрдэнэт хотыг хөгжүүлэхэд цаашдын хамтын ажиллагааны талаар сургалтын явцад санал солилцож байлаа.



Зураг 16. Эрдэнэт хот дахь “Хүний нөөцийн менежмент” сургалтын явц



Зураг 17. Эрдэнэт хот дахь “Стратегийн менежмент” сургалтыг япон мэргэжилтэн багш цахимаар удирдан явууллаа.

2) “Датад суурилсан маркетинг” сэдэвт ахисан түвшний шинэ сэдэв нэмэгдлээ.

Сургалтыг Ямагүчи их сургуулийн ахсан түвшний сургууль, Инноваци & Технологийн менежментийн тэнхимийн профессор Фүкүёо Казүхиро багш удирдан явуулсан бөгөөд шинэ агуулга, шинэ багштай онцгой сургалт болж өндөрлөлөө.

Энэхүү сургалтаар коронагийн нөхцөл байдал нь төрөл бүрийн бизнест нэлээд том нөлөө үзүүлж үр дүнд нь веб, цахим байдалд суурилсан маркетингийн үйл ажиллагааг явуулах шаардлага үүссэн гэдгийг багш маань дурдаж дата мэдээллийг цуглуулах, шинжлэх аргууд болон түүнийгээ ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсруулах, цаашлаад маркетингтай холбох олон төрлийн аргыг онол болон практикийн мэдлэгийг хослуулан олгосон юм.

Энэ удаагийн сургалт нь урьд өмнө явагдаж байгаагүй шинэ сэдэв байсан гэдэг утгаараа оролцогчдын хүлээлт өндөр байсан бөгөөд агуулгын хувьд баялаг мөн сонирхолтой байсан учир тэрхүү хүлээлтэд нь нийцсэн, үр өгөөжтэй сургалт болсон гэдэгт итгэлтэй байна.

3) Үе үеийн бизнесийн сургалт төгсөгчдөдөө зориулсан тусгай семинарыг зохион байгууллаа

2022 онд Монгол-Японы төвийн үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой, Монгол, Япон хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой, ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар байгуулагдсаны 25 жилийн ой тус тус тохиож байна. Ойн үйл ажиллагааны хүрээнд тус төвөөс үе үеийн бизнесийн сургалт төгсөгчдөдөө зориулсан тусгай семинарыг “МОНГОЛЫН КОМПАНИЙН МЕНЕЖМЕНТЭД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, ЯПОНЫ ЖИШЭЭНЭЭС СУРАЛЦАХ НЬ” сэдвийн дор зохион байгууллаа.

Тус семинар нь ЗОЧИН ИЛТГЭГЧДИЙН ИЛТГЭЛ, ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ гэсэн 3 хэсэгтэй зохион байгуулагдсан юм. Семинарыг нээж Монгол-Японы төвийн захирал Ц.Даваадорж мэндчилгээ дэвшүүлсэн ба түүний дараа МЯТ-ийн ерөнхий зөвлөх Ониши Ёшифүми “Байгууллагын соёлын хүч” сэдвээр, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дэд бүтэц, хот байгуулалт, хувийн хэвшлийн салбар хариуцсан суурин төлөөлөгч Койзүми Тайга “COVID-19-н үед Япон компаниудын хэрэгжүүлсэн сайн туршлага” сэдвээр, Монголын Кайзэн холбооны дэд ерөнхийлөгч Ж.Хишигжаргал “Монгол компаниудын менежментийн тулгамдсан асуудлууд ба шийдлүүдийн жишээ” сэдвээр тус тус сонирхолтой илтгэлүүдийг тавьсан юм.



Зураг 18. Тусгай семинарын илтгэгч Ониши Ёшифүми



Зураг 19. Тусгай семинарын зочин панелист



4. СУРАЛЦАГЧДЫН ДУУ ХООЛОЙ

1. Ямар шинэчлэл хийхээ мэдэхгүй гацсан байсан тухайн үед яг нүдээ олсон сургалт байлаа



Зураг 20

Монгол-Японы хооронд дипломат харилцааны тогтоосны 50 жилийн ойн хүрээнд олон сайхан хөтөлбөр амжилттай хэрэгжиж, миний хувьд бизнесийн үндсэн ангийн сургалтанд хамрагдаж, өөрийгөө нээж, насан туршийн сайхан хамт олонтой болж, бизнесийн арга барилын цөм ойлголтуудыг олж мэдсэн.

Өмнө нь 2017 онд үйлдвэрлэлийн удирдлага сэдэвт сургалтад хамрагдаж, үйлдвэрийн зохион байгуулалт, ажиллах зарчим, үнэлгээний систем, аюулгүй ажиллагаа зэргийн талаар мэдэж авсан.

Мөн түүнчлэн дэлхийд танигдсан брэнд компаниудиаас эхлээд япон менежментээр одоо үйлдвэрлэлээ эхэлж буй байгууллагуудын туршлагаас хуваалцаж, монгол хүний сэтгэлгээний онцлог, зан чанартай хослуулсан туршлагаадаас хуваалцан, өөрийн үйлдвэртээ амжилттай хэрэгжүүлсэн. Ямар шинэчлэл хийхээ мэдэхгүй гацсан байсан тухайн үед яг нүдээ олсон сургалт байлаа.

Харин 2022 оны бизнесийн удирдлагын сургалт бол цоо шинэ цогц систем байсан. Эмч мэргэжилтэй миний хувьд үг хэллэг, нэр томъёо нь эхэндээ шинэлэг санагдсан ч “Стратегийн менежмент” сэдэвт хичээл орсноос хойш сонирхол их татаж, хичээл дээр үзсэн мэдлэгээ яаж хэрэгжүүлэх талаар бодож эхэлсэн дээ. “Хүний нөөцийн менежмент”-ийн Дашмаа багшийн сургалтаар монгол компаниудын түгээмэл гаргадаг алдаа, түүнээс хэрхэн сэргийлэх зэрэг бодит тохиолдлууд дээр ажиллаж, манайх яах байсан бэ гэж бодоход хүргэсэн нь хүний нөөцийн бодлогоо шинэчлэж, өөрчлөлт хийхэд хүргэсэн. Энэ нь манай компанийн хүн болгон сэтгэлгээгээ өөрчилж нэг зорилгын төлөө үр бүтээлтэй ажиллахад тусалсан юм.

Удирдлагын ангид маань шинэ залуу гарааны бизнесээ эхэлж буй захирлаас эхлээд зах зээлд байр сууриа аль хэзээний эзэлсэн туршлагатай, мэдлэгтэй, нийгэмд аль хэдийнээ хөлөө олсон бизнес эрхлэгч нар байсан нь нэг хамт олон болоход илүү хурдан нөлөөлсөн. Компания амжилттай удирдаж байгаа захирлуудаасаа суралцаж, хамтран ажиллаж, насан туршийн найз нөхдөө олсондоо маш баяртай байна. Цаашдаа ч гэсэн нэг нэгэндээ тусалж, хамтдаа хөгжинө гэдэгт итгэж байна.

Монгол-Япон төвийн багш, ажилчид, төсөл хэрэгжүүлэгч нарт монголын бизнес эрхлэгчдийн өөрчлөлт шинэчлэлд оюуны томоохон хувь нэмэр оруулж буйд талархал илэрхийлье.

Бизнесийн үндсэн сургалтын 22 дахь элсэлтийн Удирдлагын ангийн төгсөгч

“Одь тан ХХК” компанийн гүйцэтгэх захирал Б.Ширчинмаа



2. Хүний хүсэл мөрөөдөл, зан чанарт тулгуурласан шинжлэх ухааны үндэслэл бүхий менежментийн аргачлал нь маш сонирхолтой байсан



Зураг 21

Юуны өмнө Монгол-Япон төвийн нийт багш ажилчдадаа дахин талархал илэрхийлье.

Өнгөрсөн богино хугацаанд байгууллага маань хурдацтай өргөжин тэлж, анх 5 хүнтэй байгуулагдсанаас хойш 3 үйлдвэртэй, 30 гаруй ажилтантай болсон байна. Энэ үед бизнесийн төлөвлөгөө, стратеги болон хүний нөөцийн асуудал дээр урт хугацааны бөгөөд оновчтой бодлогуудыг гаргаж компаниа дараагийн түвшинд аваачих зайлшгүй шаардлага үүссэнийг мэдэрсэн. Яг энэ мөчтэй зэрэгцэн Монгол-Япон төвөөс явуулдаг “Бизнесийн үндсэн сургалт”-д суралцах боломж олдсон юм.

Тус төвийн “Бизнесийн үндсэн сургалт”-д хамрагдсанаар ажлын байранд практикаар сурч мэдсэн мэдлэгээ илүү гүнзгийрүүлж, эмх цэгцтэй болгосон. Ингэснээр шаардлагатай үед сурч мэдсэн мэдлэг, ур чадвараа ашиглахад илүү хялбар, үр дүнтэй болж чадсан нь ажлын бүтээмжийг маш өндөр болгож өгсөн юм. Уг сургалтаар нийт 4 бүлэг хичээл үзсэнээс миний хувьд “Хүний нөөцийн менежмент”-ийн хичээл маш их таалагдсан. Хүний хүсэл мөрөөдөл, зан чанарт тулгуурласан шинжлэх ухааны үндэслэл бүхий менежментийн аргачлал нь маш сонирхолтой байсан бөгөөд өнөө үед Монголын компаниудад тулгарч буй гол асуудлыг шийдэж чадахуйц мэдлэг олгосон.

Мөн дэлхийн шилдэг Япон маягийн менежментийг байгууллагадаа нэвтрүүлснээр ажилчдын сэтгэл ханамж, бүтээмжийг сайжруулаад зогсохгүй компанийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулж, олон улсын түвшинд хүргэх боломжийг бий болгосонд маш баяртай байна.

Эцэст нь хэлэхэд Монгол-Япон төвийн сургалтад хамрагдсан үе үеийн төгсөгчид маань цаашид байнгын эргэх холбоотой байж, урт хугацааны хамтын ажиллагаа, нөхөрлөлийг бий болгоно гэдэгт итгэлтэй байна.

Бизнесийн үндсэн сургалтын 22 дахь элсэлтийн Менежерийн ангийн төгсөгч

“Битумина Монголиа ХХК” компанийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал П.Цолмон

3. Сургалтын үр дүнг хамт олонтойгоо хуваалцах нь хэрэгжүүлэхэд хялбар болдог



Зураг 22

Арвин туршлагатай, чадварлаг япон багш нарын лекцийг сонсож, багаараа дасгал ажиллаж, нэг анги болон суралцаж буй хүмүүстэй танилцаж, нөхөрлөх сайхан боломжийг олгосон Монгол - Япон төвийн бизнесийн сургалтын багш нар, сургалтын зохион байгуулагч, орчуулагч нартаа туйлын талархаж байгаагаа илэрхийлмээр байна.

Сургалтын хуваарь, зохион байгуулалт, сургалтын танхим, тоног төхөөрөмж, цайны засварлагаа, орчуулга яг л Япон соёлыг шингээсэн, тохиромжтой, гүйцэтгэл сайтай, харилцаа хандлагын тал дээр сэтгэгдэл маш өндөр байна.



Стратегийн менежмент, Хүний нөөц, Санхүүгийн удирдлага, Маркетингийн сургалтуудаас өөрийн ажилдаа хэрэгжүүлэх санаанууд маш олон байсан бөгөөд ажлынхаа хамт олонд сурч мэдсэн зүйлээ тухай бүрт хуваалцдаг байсан.

Цаашид танай төвөөс зохион байгуулагдах үйл ажиллагаа, сургалтад идэвхитэй хамрагдаж, бусдыгаа уриалж, манлайлж ажиллах болно. Баярлалаа. Баярлалаа. Баярлалаа.

Бизнесийн үндсэн сургалтын 22 дахь элсэлтийн Менежерийн ангийн төгсөгч

“Эрдэнэс Тавантолгой” ХК Хүний нөөцийн хөгжил,

сургалтын хэлтсийн Сургалтын ахлах мэргэжилтэн Ж.Ариунсайхан

4. Төлөвлөлтийг сайн хийж чадвал амьдрал илүү хялбар болдог



Зураг 23

Манай компани програм хангамжийн компани бөгөөд үүсэн байгуулагдаад 9 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа юм.Компаниа дараагийн түвшинд гаргахад нэг гол хүчин зүйл нь удирдлагын мэдлэг ур чадвараас хамаарна гэж боддог. Миний хувьд програм хангамжийн инженер мэргэжилтэй салбартаа 20 дахь жилдээ ажиллаж байна. Бизнесийн удирдлагын мэдлэг чадвараа сайжруулах юмсан гэж бодож байсан. Өмнө энэ сургалтад суусан харилцагч маань надад санал болгосон юм. Тэгээд судалж үзээд суухаар шийдсэн юм.

Би өөрийнхөө түвшинг мэдэх, шилдэг туршлагуудаас суралцах бизнесийн удирдлагын мэдлэгээ сайжруулах зорилгоор Монгол-Япон төвийн бизнесийн үндсэн сургалтад 2022 оны намар хамрагдсан. Багш нараасаа маш их зүйлийг сурч мэдсэн. Энэ сургалт нь бизнесийн удирдлагын мастерийн түвшний гол гол хичээлүүдийг богино хугацаанд чадварлаг багш нараар заалган үздэгээрээ онцлогтой сургалт байсан. Япон монголын төвийн үйл ажиллагаа болон япон багш нараасаа төлөвлөлт, эмх цэгцтэй байдлын чухлыг илүү ойлгож авсан. Төлөвлөлтийг сайн хийж чадвал амьдрал илүү амар хялбар байдаг юм байна гэж ойлгож авсан. Мөн сургалтад сууснаар олон сайхан хүмүүстэй танилцаж, туршлага солилцож, харилцан бие биенээсээ суралцан, нөхөрлөж эхэлсэн.

Сурсан мэдсэн зүйлсээсээ стратегийн менежементийг компанидаа 2023 оноос шууд хэрэгжүүлээд эхэлээд явж байна. Мөн үндсэн сургалтад компанийхаа менежментийн багийн бүх гишүүдээ суулгахаар төлөвлөсөн. Миний хувьд ч мөн цаашид ахисан түвшний сургалтуудад хамрагдахаар төлөвлөж байна.

Компаниа дараагийн түвшинд гаргахыг хүсэж байгаа бүх бизнес эрхлэгч нартаа энэ сургалтыг санал болгож байна.

Бизнесийн үндсэн сургалтын 22 дахь элсэлтийн Удирдлагын ангийн төгсөгч

Смарт Ложик ХХК, Үүсгэн байгуулагч & Ерөнхий захирал Б.Анхбаяр

II. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ





1.2022 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Монгол-Японы төвийн Япон хэлний сургалтын тасаг нь 2012 оны 4 сараас Япон сангийн япон хэлний боловсролын стандартад /цаашид JF стандарт гэх/ нийцүүлэн “Япон хэлний сургалт”-ыг зохион байгуулж эхлээд 10 дахь жилээ үдлээ. Сургалтад зааж буй багш нар нь “Нэгж хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлэг”, “Сургалт дууссаны дараах тайлангийн хурал”, “Хичээлийн явцын тэмдэглэл”, “Япон хэлний сургалтын тасгийн багш нарт зориулсан заах аргын сургалт, семинар” зэргээр дамжуулан сургалтын агуулга болон заах аргын чанарыг хадгалах, сайжруулахад тасралтгүй анхаарсаар байна.

2022 онд коронавирус цар тахлын нөхцөл байдал тогтворжсонтой холбогдуулан япон хэлний сургалтуудаа жилийн туршид танхимаар зохион байгуулж чадсан билээ. Гэрээт ажлын хувьд энэ онд ч мөн адил “Тусгай ур чадварын тогтолцоо”-той холбоотой ажлуудыг үргэлжлүүлэн хийснээс гадна Японы Кёото их сургуулийн iUP хөтөлбөрт тэнцсэн оюутанд зориулсан япон хэлний сургалт, мөн Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

1) Япон хэлний сургалтын талаар

Япон хэлний сургалт нь дээр дурдсан JF стандартын дагуу явагдаж байгаа болно. Энэхүү тайлан мэдээ нь 2022 оны 2 сараас 5 сарын хооронд явагдсан хаврын сургалт болон 5 сараас 7 сарын хооронд явагдсан зуны сургалтын эхний хагас, 7 сараас 8 сарын хооронд явагдсан зуны сургалтын сүүлийн хагас, 9 сараас 12 сарын хооронд явагдсан намрын сургалт /сургалт дуусах хугацаа 2023 оны 1 сар/-уудын тайлан болно. Хавар, намрын сургалтуудад суралцагчдын түвшинд тохирсон “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт”-ууд болон “Япон хэлний заах аргын сургалт”-ыг явуулж байна. Дээрх сургалтуудын агуулга болон үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу. Хавар болон намрын сургалт нь 4 сар орчим үргэлжилдэг ба “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1”/суурьгүй анхан шат/-аас “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6” /дунд шат/ хүртэл явагддаг.

Энэ жилийн “Япон хэлний заах аргын сургалт” нь хавар “Япон сангийн япон хэлний боловсролын стандартад үндэслэсэн анхан шатны сургалтын үнэлгээ болон сургалтыг эргэцүүлэн дүгнэх”, намар “Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголт” сэдвээр тус тус явагдав. Зуны сургалтын эхний хагаст “Анхан шатны түргэвчилсэн сургалт”-ыг эхлүүлж, зуны сургалтын сүүлийн хагаст “Хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт”-ыг 3 жилийн дараа дахин сэргээж зохион байгуулснаас гадна, “Анхан шатны түргэвчилсэн сургалт”-ын 3 ангийг нээн хичээллүүлсэн. Мөн намар “11-13 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”-ыг шинээр зохион байгуулсан болно.



2) Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар

2022 онд хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны хувьд, 3 сард “Япон хэлний боловсролын симпозиум”, 9 сард “Нийгата мужын нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн”, 11 сард “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн”, “Монголын япон хэлний сургалт, судалгааны холбооны ээлжит хурал” зэрэг олон төрлийн үйл ажиллагааг Япон Улсын Элчин Сайдын Яам, Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

2022 онд Япон хэлний сургалтын тасгаас зохион байгуулсан үйл ажиллагаа

Хүснэгт 11: Хавар, зун, намрын сургалтууд

№	Сургалтын нэр	Хугацаа	Агуулга	Багш	Суралцагчдын тоо
1	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги /А1 түвшин/	2022/2/9-2022/5/18	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото ньюмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Г.Ариунболор, О.Булган, Сато Кэйичи	25
2	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги /А1 түвшин/	2022/2/9-2022/5/18	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото ньюмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Г.Ариунболор, О.Булган, Сато Кэйичи	25
3	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2А анги /А2 түвшний эхний шат/	2022/2/9-2022/5/18	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	П.Алтанбулаг, Д.Золзаяа, Ц.Онон, Икома Каорү	20
4	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги /А2 түвшний эхний шат/	2022/2/9-2022/5/18	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	П.Алтанбулаг, Д.Золзаяа, Ц.Онон, Икома Каорү	24



5	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А анги /А2 түвшний дунд шат/	2022/2/9- 2022/5/18	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	П.Марал, Д.Золзаяа, Күрияма Томоюки	11
6	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3В анги /А2 түвшний дунд шат/	2022/2/9- 2022/5/18	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	П.Марал, Д.Золзаяа, Күрияма Томоюки	12
7	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /А2 түвшний төгсгөлийн шат-В1 түвшний эхний шат/	2022/2/10- 2022/5/31	А2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан А2 түвшний төгсгөлийн шат болон В1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2/B1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Д.Мөнхтуяа, Күрияма Томоюки	13
8	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /В1 түвшин/	2022/2/10- 2022/5/24	В1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан В1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Д.Мөнхтуяа, Икома Каорү	13
9	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6 /В1 түвшин/	2022/2/10- 2022/5/24	В1 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан В1 түвшний төгсгөлийн шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Ц.Онон, Мицүмото Томоя, Цүрүта Ясүюки	10



10	Япон хэлний заах аргын сургалт /B2-C1 түвшин/	2022/3/17-2022/5/19	1) Япон сангийн япон хэлний боловсролын стандартад тургуурласан асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтад "үзсэн агуулгаа бататгах" шалгалт болон үнэлгээг хийж чаддаг болох 2) Дасгал даалгавар дээр ажиллах, бусад багш нартай харилцан ярилцах замаар өөрийн заах арга зүй, боловсролын талаарх үзэл бодлоо өөрчлөн шинэчлэх	Цүрүта Ясүюки	8
11	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт /A1 түвшин/	2022/5/17-2022/7/5	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нъюмон A1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт.	Г.Ариунболор, П.Алтанбулаг, Д.Золзаяа, Икома Каорү, Күрияма Томоюки	12
12	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-А анги /A1 түвшин/	2022/7/20-2022/8/30	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нъюмон A1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт.	О.Булган, Г.Ариунболор, Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, Д.Золзаяа, Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки	24
13	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-В анги /A1 түвшин/	2022/7/20-2022/8/30	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нъюмон A1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт.	О.Булган, Г.Ариунболор, Ц.Онон, Икома Каорү, Күрияма Томоюки	26
14	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-С анги /A1 түвшин/	2022/7/20-2022/8/30	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нъюмон A1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт.	О.Булган, Г.Ариунболор, Ц.Онон, Икома Каорү, Күрияма Томоюки	26
15	Хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт /8-10 нас/	2022/7/21-2022/8/16	Япон хэлийг хөгжилтэйгөөр сурах хүсэлтэй 8-10 насны хүүхдүүдэд зориулсан сургалт. Мэндчилгээний үг хэллэг, өөрийгөө танилцуулах, гэр бүлээ танилцуулах, дуртай идэх уух зүйлээ хэлэх, өөрийн бие бүтэц, төрсөн өдөр, хобби зэргийн талаар хэлж сурсан. Мөн хирагана үсгийг уншиж, бичиж сурсан. Катакана үсгээр өөрийн нэрийг уншиж, бичиж сурсан.	П.Марал, Яо Юкико, Күрияма Томоюки, Сато Кэйичи, Цүрүта Ясүюки	20



16	Хүүхдэд зориулсан маругото ядог хэлний анхан шатны сургалт /11-13 нас, А1 түвшин/	2022/9/27- 2022/12/22	Япон хэлийг анхлан суралцаж буй 11-13 насны хүүхдүүдэд зориулан Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1, рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт.	Г.Ариунболор, Күрияма Томоюки	12
17	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги /А1 түвшин/	2022/9/26- 2023/1/9	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Д.Золзаяа, О.Булган, Сато Кэйичи	26
18	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги /А1 түвшин	2022/9/26- 2023/1/9	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Д.Золзаяа, О.Булган, Сато Кэйичи	26
19	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2А анги /А2 түвшний эхний шат/	2022/9/26- 2023/1/9	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Ц.Онон, Д.Мөнхтуяа, Икома Каорү	26
20	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги /А2 түвшний эхний шат/	2022/9/26- 2023/1/9	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Ц.Онон, Г.Ариунболор, Цүрүта Ясүюки	24
21	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А /А2 түвшний дунд шат/	2022/9/26- 2023/1/9	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото шокюү-2 А2 кацүдоо,	П.Марал, Д.Золзаяа, Күрияма Томоюки	11



			рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.		
22	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3В /А2 түвшний дунд шат/	2022/9/26-2023/1/9	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	П.Марал, Д.Золзаяа, Күрияма Томоюки	10
23	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /А2 түвшний төгсгөлийн шат-В1 түвшний эхний шат/	2022/9/27-2023/1/24	А2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан А2 түвшний төгсгөлийн шат болон В1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шочюүкюү А2/В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	П.Марал, Икома Каорү	20
24	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /В1 түвшин/	2022/9/27-2023/1/17	В1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан В1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото чюүкюү-1 В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Д.Мөнхтуяа, Икома Каорү	16
25	Япон хэлний заах аргын сургалт /В2-С1 түвшин/	2022/9/29-2022/12/23	1) Хоёр дахь хэл эзэмшихүйн онол болон Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголтод суралцах 2) Анхан шатны япон хэлний нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад суралцаж, өөрийн боловсруулсан хөтөлбөрт үндэслэн жишиг хичээлийг заах	Цүрүта Ясүюки	9
					449

Хүснэгт 12: Тусгай сургалт, семинарууд

№	Сургалтын нэр	Хугацаа	Агуулга	Багш болон хариуцсан ажилтан	Орол цогчдын тоо
1	Марүгото япон хэлний 1 удаагийн танилцуулах хичээл	2022/1/18	"Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1"-т суралцах хүсэлтэй хүмүүст зориулан, японоор мэндэлж, өөрийгөө танилцуулж сурахаас гадна Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу	П.Марал	3



			бэлтгэн гаргасан "Марүгото" сурах бичиг болон сургалтын талаарх танилцуулгыг багтаасан.		
2	ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2022 *Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан цахим сургалт	2022/1/10-2022/1/14	"Сонирхолтой хичээл" сэдвийн хүрээнд ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулан заах аргын сургалтыг зохион байгуулж, Монгол орон даяар япон хэлний боловсролыг сурталчлах, чанаржуулахад хувь нэмэр оруулсан. Үүний зэрэгцээ, ЕБС-ийн япон хэлний багш нарын харилцаа холбоог бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргасан.	Мицүмото Томоя, Э.Эрдэнэцэцэг	41
3	Марүгото сургалтын суралцагчдад зориулсан ханз үсэг сурахын өмнөх удиртгал хичээл	2022/2/25,3/2, 5/27, 8/1, 10/7, 10/17 Нийт 6 удаа	Ханз үсгийн түүх, гарал үүсэл, кана болон ханз үсгийн ялгаа, ханз үсгийн тоо, ангилал, ханзны дүрс хэлбэр, ханзны түлхүүр, унших бичих арга зэргийн талаарх тайлбар хичээл	Г.Ариунболор, О.Булган, Д.Золзаяа, Ц.Онон	297
4	Японы залуу хамтлаг болох "ChakaLand" хамтлаг болон Монгол-Японы төвийн япон хэл суралцагчдын танилцах уулзалт	2022/3/10	Окинава болон Монголын талаарх асуулт хариултын тэмцээн, япон хэл суралцагчдын сонирхсон асуултад хариулах, хамт зураг авахуулах гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	"ChakaLand" хамтлаг, Мицүмото Томоя, О.Булган	67
5	Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын "Мэргэд" сургууль дээр зохион байгуулсан япон хэлний сургалтын үйл ажиллагаатай танилцах, зөвлөгөө өгөх арга хэмжээ болон японы соёлын танилцуулах сургалт *Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа	2022/3/13-2022/3/16	Үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: - Япон хэлний сургалтын үйл ажиллагаатай танилцах, япон хэлний хичээлд сууж үзэн багшид зориулан заах аргын зөвлөгөө өгөх - Сурагчдад зориулан "Япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт"-ын N4-N5 түвшнийг зохион байгуулах, японд суралцах талаар зөвлөгөө өгөх, "Япон орныг хэн сайн мэдэх вэ" асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулах, япон анимэ үзэх - Оригами хийх, кэндама тоглох, юката өмсөж зургаа авахуулах, бийрэн бичлэг бичих зэрэг япон соёлын танилцуулах хичээлийг зохион байгуулах	Цүрүта Ясүюки, Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, Э.Урангоо, Б.Ууганбаяр	284
6	Монгол-Японы төвийн япон хэлний сургалт төгсөгчдөд зориулсан соёлын өдөрлөг *Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа	2022/5/21	Өдөрлөгийн хүрээнд дараах 7 төрлийн соёлын арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1) Япон тоглоом "Кэндама" тоглох 2) Нинжагийн хувцас өмсөж, дүрд хувирах 3) "Садоо" буюу цайны ёслолтой танилцах 4) "Фүрошики" буюу япон баглаа боодлын соёлд суралцах 5) Японы үндэсний хувцас "юката" өмсөж зургаа авахуулах 6) Танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн 7) Талархлын сэтгэгдэл үлдээх булан	Зохион байгуулсан: ЯХСТ Хамтран ажилласан: НСХАТ, БСТ	350
7	Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт *Гэрээт сургалт	2022/5/2-2022/8/11	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Иродори хэрэглээний япон хэл" /A1 түвшний суурь шат/ сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулсан.	Д.Мөнхтуяа, О.Булган, Д.Золзаяа, Сато Кэйичи	15



8	Кёото их сургуулийн iUP хөтөлбөрт элсэн орогчид зориулсан япон хэлний бэлтгэл сургалт-2022 *Гэрээт сургалт	2022/6/13-2022/8/22	Кёото их сургуулийн iUP хөтөлбөрт элсэн орогчид зориулсан япон хэлний гэрээт сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото Япон хэл ба соёл" /чюүкюү-2, В1/ сурах бичиг болон "Минна но нихонго" /чюүкюү-1/ сурах бичгийг ашиглан, суралцагчийн сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь хөгжүүлэхийг зорьсон.	Ц.Онон, Э.Эрдэнэцэцэг, Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки	1
9	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N4 түвшин/ *"BNM-MEIRAI" Гадаад хэлний сургалтын төвийн хүсэлтээр	2022/1/28, 9/16	ЛРТ шалгалтын N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Р.Алтанбулаг, Д.Мөнхтуяа	21
10	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N4, N5 түвшин/ *Эрдэнэт хотын "Билэгт өргөө" сургуулийн хүсэлтээр	2022/5/30	ЛРТ шалгалтын N4, N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Р.Алтанбулаг, Д.Мөнхтуяа	23
11	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2022/4/25-2022/6/9	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, П.Алтанбулаг	118
12	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2022/10/24-2022/11/16	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, П.Алтанбулаг, П.Марал, О.Булган, Б.Буманцэцэг	95
13	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2022/1/20	2021 оны намрын сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2022 оны хаврын сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал болон хурлын тэмдэглэл хөтлөгч: Э.Эрдэнэцэцэг Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	12
14	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2022/6/2	2022 оны хаврын сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2022 оны зуны сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: П.Алтанбулаг Хурлын тэмдэглэл хөтлөгч: Г.Ариунболор Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	11



15	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2022/9/9	2022 оны зуны сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2022 оны намрын сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: Э.Эрдэнэцэцэг Хурлын тэмдэглэл хөтлөгч: Күрияма Томоюки Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	7
16	2022 оны хаврын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт	2022/1/11-2022/2/7	Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6-гийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт	Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, Г.Ариунболор, П.Марал, О.Булган	78
17	2022 оны намрын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт	2022/9/7-2022/9/26	Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6-гийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт	Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, П.Марал, О.Булган	64
18	Япон хэлний сургалтын тасгийн багш нарт зориулсан заах аргын сургалт, семинар	2022/1/6, 1/20, 2/17, 2/24, 3/17, 3/24, 4/7, 4/21, 5/5, 5/26, 6/2, 6/16, 10/18, 11/22, 11/29, 12/16 Нийт 16 удаа	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Япон сангийн хэлний төвийн сургалт хариуцсан багш нарт зориулан япон хэлний боловсрол, заах аргын талаарх мэдлэгээ өргөжүүлэх, харилцан мэдээллээ хуваалцах зорилготой сургалт бөгөөд сурч мэдсэн зүйлээ өөрийн хичээлд хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт.	Мицүмото Томоя, Цүрүта Ясүюки	123
19	Шинэ ажилтанд зориулсан сургалт	2022/9/28, 9/29	Төвийн ерөнхий танилцуулга, тасгуудын үйл ажиллагааны танилцуулга, багуудын үйл ажиллагааны танилцуулга, шинэ ажилтны баримтлах дүрэм журам, шинэ ажилтнаас хүсэх хүлээлт, япон хэлний сургалтын тасаг доторх ажлын агуулга болон бусад тайлбар, ажлаа хүлээн авах гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	Захирал, тасгийн дарга нар, багуудын дарга нар	3
20	“Тусгай ур чадвартай ажилтан тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд зохион байгуулсан тусгай семинар	2022/3/16	Семинарын сэдэв: "Япон улсад ажиллаж амьдарч буй гадаадын иргэдэд тулгардаг соёлын ялгаатай байдал болон харилцааны үл ойлголцол"	Семинарын зочин багш: Асами Ичиро /“Найтэй Бридж” ХХК-ий ТУЗ-ийн дарга, Японы засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сангийн зочин багш, Японы гадаад худалдааг дэмжих байгууллага JETRO-ын гадаад ажилтны хүний нөөцийн салбарын зөвлөх мэргэжилтэн/	91



21	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар	2022/1/27	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерийн дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	П.Алтанбулаг, О.Булган	13
22	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар *Цахим семинар	2022/3/12	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерийн дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	П.Алтанбулаг	16
23	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар *Цахим семинар	2022/5/17	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерийн дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	П.Алтанбулаг	29
24	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар *Цахим семинар	2022/8/11	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерийн дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	О.Булган	35
25	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар	2022/11/23	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерийн дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	О.Булган, Б.Буманцэцэг	28
26	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар *Цахим семинар	2022/4/25, 4/26, 4/29, 5/9, 5/10	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт юм. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Т.Баасанжаргал, П.Алтанбулаг, О.Булган	15



27	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2022/9/14, 9/15, 9/16, 9/19, 9/20	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт юм. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүнгэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Т.Баасанжаргал О.Булган, Э.Эрдэнэцэцэг	14
28	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2022/12/7, 12/8, 12/9, 12/12, 12/13	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт юм. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүнгэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Т.Баасанжаргал О.Булган, Э.Эрдэнэцэцэг	16
29	"Иродори япон хэлний онлайн сургалт"-ын танилцуулах хичээл *Шинэ үйл ажиллагаа	2022/8/12	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг түгээн дэлгэрүүлэх, Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн /JFT-Basic/ шалгалтад тэнцэх Монгол суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд туслах зорилгоор "Иродори япон хэлний онлайн сургалтын"-ын талаарх ерөнхий ойлголт өгөх, хэрхэн хэрэглэх аргыг сурч, дасгал даалгавар ажиллаж үзсэн.	П.Алтанбулаг	20
30	"Иродори япон хэлний онлайн сургалт"-ын танилцуулах хичээл	2022/10/31	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг түгээн дэлгэрүүлэх, Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн /JFT-Basic/ шалгалтад тэнцэх Монгол суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд туслах зорилгоор "Иродори япон хэлний онлайн сургалтын"-ын талаарх ерөнхий ойлголт өгөх, хэрхэн хэрэглэх аргыг сурч, дасгал даалгавар ажиллаж үзсэн.	О.Булган, Б.Буманцэцэг	7
31	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /"Монгол тэмүүлэл" сургуулийн хүсэлтээр/	2022/1/19	Кембрижийн сургалтын хөтөлбөрийн AS түвшинд тохирсон сурах бичиг ("Иродори хэрэглээний япон хэл" сурах бичиг, "Минна но нихонго" сурах бичиг, AS түвшний өмнөх шалгалтын материалууд)-ийн талаар зөвлөгөө өгч ярилцсан.	Мицүмото Томоя	2
32	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /Монгол-Оросын хамтарсан 3-р сургуулийн хүсэлтээр/	2022/1/20	Цагийн хуваарийн өөрчлөлтийг хэрхэн шийдвэрлэх, соёлын хичээлийг хэрхэн нэвтрүүлэх болон заах арга зүйн шинэлэг санаа, шинэлэг арга барилын талаар зөвлөгөө өгч ярилцсан.	Мицүмото Томоя	1
33	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /Монгол-Оросын хамтарсан 3-р сургууль болон Монгени цогцолбор сургуулийн хүсэлтээр/	2022/1/28	Япон улсад суралцахад чиглэсэн Монгол-Японы төвөөс явуулж буй үйл ажиллагааны талаар, сурагчдад зориулсан мэдээ мэдээлэл, Японд суралцагчдад зориулсан шалгалт EJU болон засгийн газрын тэтгэлэгт шалгалтанд сурагчдаа хэрхэн бэлдэж чиглүүлэх талаар зөвлөгөө өгч ярилцсан.	Мицүмото Томоя	2



34	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /Монгол-Оросын хамтарсан 3-р сургуулийн хүсэлтээр/	2022/2/1	Сургуулийн сургалтын цогц хөтөлбөр, анги тус бүрийн сургалтын зорилго ба үнэлгээ, анги тус бүрийн сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүний талаар зөвлөгөө өгч ярилцсан.	Мицүмото Томоя	1
					1903

Хүснэгт 13: Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Агуулга	Илтгэгч болон хариуцсан багш	Оролцогчдын тоо
1	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 105 дахь удаагийн хурал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2022/2/19	1) "Анхан шатны сүүлийн хагасын дүрмийг хэрхэн заах болон заах арга зүйгээ сайжруулах тал дээр хэрхэн ажилласан тухай - Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3-ын жишээн дээр" сэдэвт илтгэл болон асуулт хариулт 2) Япон хэлний "бусдаар үйлдүүлэх хэв"-ийг хэрхэн заах талаарх багийн хэлэлцүүлэг	Илтгэгч: П.Марал, Күрияма Томоюки /Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний багш/	14
2	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 106 дахь удаагийн хурал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2022/4/16	Илтгэлийн сэдэв: 1) "Хоёрдогч хэлээр дүрмийн мэдлэгийг олж авах үйл явц - Үйл үгийн -тэ хэлбэрийн хэрэглээний тухайд" 2) "Ханз үсгийн зурагт ном бүтээх тухай"	Илтгэгч: Н.Баярмаа /МУБИС-ийн япон хэлний багш/ Наканиши Рэйко /Монгени цогцолбор сургуулийн япон хэлний багш/	16
3	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 107 дахь удаагийн хурал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2022/5/28	Илтгэлийн сэдэв: "Монголын Япон Хэлний Багш нарын Холбооны 2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлан" /Япон хэлний боловсролын симпозиум, Сургууль хоорондын уран илтгэлийн тэмцээн, Ханзны наадам, Япон хэлний түвшин тогтоох шалгалт /JLPT/, Японд суралцагчдад зориулсан шалгалт /EJU/, Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны ээлжит хурлууд, Ханзны унших ном боловсруулсан талаарх тайлан/	Илтгэгч: Э.Батжаргал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбооны тэргүүн/	11
4	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 108 дахь удаагийн хурал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2022/9/24	Илтгэлийн сэдэв: 1) "Шинэ Монгол Технологийн Коллежийн зуны сургалтын талаар" 2) "Хичээлээс гадуурх сурагчдыг идэвхжүүлэх үйл ажиллагааны арга зүйн талаар"	Илтгэгч: У.Солонго /Шинэ Монгол Технологийн Коллежийн япон хэлний багш/ Огава Нобүхиро /Эрдэнэт хотын "Маргад" дээд сургуулийн япон хэлний багш/	19



5	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 109 дэх удаагийн хурал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2022/10/22	Илтгэлийн сэдэв: 1) "Сурах үйлийг идэвхжүүлэх үйл ажиллагааны талаар" 2) "Сурах үйлийг идэвхжүүлэх үйл ажиллагааны талаар - Ярианы хичээлийн тухайд" 3) "Ханз үсгийн зурлагыг хэрхэн заах тухай"	Илтгэгч: Шимизү Шинго /Шинэ Монгол Харүмафүжи сургуулийн Япон хэлний багш/, Д.Лувсанжаргал /18-р сургуулийн япон хэлний багш/, Маки Күмиго /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо/	19
6	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 110 дахь удаагийн хурал /Монголын Япон Хэлний Багш нарын Холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2022/12/17	Илтгэлийн сэдэв: 1) "Ой тогтоолтын мнемоник арга ашиглан япон хэлний анхан шатны суралцагчдын үгийн санг нэмэгдүүлэх нь" 2) Багшид зориулсан мэдээлэл, зөвлөмж: ""Ба" ба "га" нөхцлийн ялгаа: Монгол суралцагчдад тэдгээрийг хэрхэн заах тухай"	Илтгэгч: Д.Оюунсүрэн /МУИС-ын магистр/, Ц.Онон /МУИС-ийн япон хэлний багш/	13
7	Япон хэлний боловсролын 14 дэх удаагийн симпозиум *Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа /Зохион байгуулагч: Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо Хамтран зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан Дэмжигч: Япон улсын Элчин Сайдын Яам/	2022/3/5	Симпозиумын сэдэв: “Монгол дахь япон хэлний сургалтын хөтөлбөр-ICT-гийн хэрэглээ ба цаашдын төлөв” Зочин багшийн илтгэлийн сэдэв: "Япон хэлний сургалтын хөтөлбөр-ICT сургалтын хөгжил ба багшийн үүрэг-"	Зочин илтгэгч: Тагүчи Мана /Кёотогийн Их Сургуулийн Дээд боловсролын судалгаа, хөгжлийн төвийн дэд профессор/ Симпозиумын зохион байгуулах комисс	99
8	"2022 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн"-ий өмнөх бэлтгэл	2022/9/16	Тэмцээний өмнөх бэлтгэл	Тэмцээний зохион байгуулах комисс	10
9	"2022 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн" *Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа /Зохион байгуулагч: Нийгата мужийн Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг Хамтран зохион байгуулагч:	2022/9/17	Монголд япон хэл суралцаж буй их дээд сургуулийн оюутан залуусыг дэмжих, тэдэнд Нийгата мужийг танилцуулах зорилгоор Нийгата мужийн нэрэмжит “Япон хэлний уран илтгэлийн тэмцээн”-ийг хамтран зохион байгуулсан. Уралдаанд их дээд сургуулийн нийт 8 оюутан "Япон улстай найрамдалт харилцаагаа хэрхэн өргөжүүлэн хөгжүүлэх вэ" сэдвээр илтгэл тавьсан.	Тэмцээний зохион байгуулах комисс	60



	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Монгол-Нийгатагийн хамтын ажиллагааны нийгэмлэг Дэмжигч: Япон Улсын Элчин Сайдын Яам, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Нийгата муж, Нийгата-Монголын найрамдлын нийгэмлэг/				
10	6 дахь удаагийн ханзны наадам *Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа /Зохион байгуулагч: Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо, Наран бүрэн сургууль, 18-р сургууль Хамтран зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, МУБИС, НХУС, Дорно дахины хэлний тэнхим Дэмжигч: Япон улсын Элчин Сайдын Яам/	2022/10/15	Япон хэлний сургалт явуулж буй ЕБС-ийн дунд зохион байгуулдаг ханзны наадам. Дунд болон ахлах ангийн сурагчдын ангиллаар 1 багт 3 сурагчтайгаар хуваагдаж, хоорондоо мэдлэг чадвараа сорьж уралдсан.	Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки	90
11	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий зохион бичлэгийн шалгаруулалт	2022/10/29	Тэмцээнд оролцохоор зохион бичлэгээ ирүүлсэн ахлах ангийн 29 сурагчаас 15 сурагч, их дээд сургуулийн 13 оюутнаас 10 оюутан зохион бичлэгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн. Зохион бичлэгийн сэдэв: Ахлах ангийн ангилал: "Алдаанаасаа суралцсан зүйл", оюутны ангилал: "Орон зай"	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	42
12	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий ярилцлагын шалгалт	2022/11/5	Зохион бичлэгийн сонгон шалгаруулалтаас тунаж үлдсэн ахлах ангийн 15 сурагч, их дээд сургуулийн 13 оюутнаас ярилцлагын шалгалтыг авч, ахлах ангийн 9 сурагч, их дээд сургуулийн 8 оюутан төгсгөлийн шалгаруулалт болох илтгэлийн тэмцээнд оролцохоор болсон.	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	28
13	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий өмнөх бэлтгэл	2022/11/17	Тэмцээний өмнөх бэлтгэл	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	17
14	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн" *Хайбрид хэлбэрийн тэмцээн *Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой, Монгол-Японы хүний нөөцийн	2022/11/19	Зохион бичлэг болон ярилцлагын шалгалтын дүнгээр тунаж үлдсэн ахлах ангийн 9 сурагч, их дээд сургуулийн 8 оюутан илтгэл тавьсан. Илтгэлийн сэдэв: Ахлах ангийн ангилал: "Алдаанаасаа суралцсан зүйл", Оюутны ангилал: "Орон зай"	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	125




	хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа /Хамтран зохион байгуулагч: Япон улсын элчин сайдын яам, Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо, ШУТИС-ийн гадаад хэлний институт, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон сан Дэмжигч: Монгол дахь япончуудын холбоо, Монгол Японы худалдааны танхим/				
15	Япон фестиваль Монголд-2022 *Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа	2022/8/20,8/21	Төвийн үйл ажиллагааг танилцуулах хэсэгт жилийн турш явагдах япон хэлний сургалтууд болон намрын сургалтаа танилцуулж, сурталчилгаа хийсэн.	Э.Эрдэнэцэцэг, П.Марал, О.Булган	456
					1019

Хүснэгт 14: Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо

	2021 он	2022 он
Хаврын сургалт	119	161
Зуны сургалт	34	108
Намрын сургалт	109	180
Нийт	262	449

График 6: Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо

Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо



Хүснэгт 15: Тусгай сургалтад хамрагдсан хүний тоо

	2021 он	2022 он
Тусгай сургалт	796	1,903

Хүснэгт 16: Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон хүний тоо

	2021 он	2022 он
Хамтарсан үйл ажиллагаа	482	1,019



График 7: Тусгай сургалт




График 8: Хамтарсан үйл ажиллагаа



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) 2022 оны зуны “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”

2022 оны 7 сарын 21-ээс 8 сарын 16-ны хооронд “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт” зохион байгуулагдав. Энэхүү сургалт нь 2019 онд явагдсанаас хойш 2 жилийн турш корона вирус цар тахлын нөлөөгөөр завсарлаад байсан бөгөөд 2022 оны зун дахин явагдсан юм.

Энэ удаагийн хүүхдийн сургалт нь өмнөх сургалтын адил эрэлт ихтэй байсан бөгөөд хүүхдийнхээ зуны амралтыг үр дүнтэй өнгөрүүлэх хүсэлтэй 20 гаруй эцэг эхээс хүүхдээ сургалтад хамруулах хүсэлт ирсэн.



Зураг 24. “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”

Сургалтын эхний өдөр сурагчид нэг нэгэнтэйгээ танилцах үедээ биеэ барьж, өөртөө итгэл муутай хичээлдээ оролцож байсан бол 3 хоногийн дараагаас идэвх оролцоо нь нэмэгдэж нээлттэй болж ирсэн.

Тус сургалтын нэг онцлог нь үндсэн болон туслах багш гэсэн 2 багшийн бүрэлдэхүүнтэйгээр хичээл орсон. Үүний үр дүнд хоцорсон хүүхдүүддээ тухай бүрд нь нэмэлтээр тайлбар өгч, бичих болон ярианы дасгалын үеэр ч мөн хүүхэд бүртэй тулж ажилласны үр дүнд бүх суралцагчид амжилттай сургалтаа дүүргэсэн юм. Сургалтын агуулгын хувьд нэг удаагийн хичээл 2 цаг үргэлжлэх ба энэ хугацаанд хүүхдүүдийг 30



минут тутамд тогтмол завсарлуулж амрах цаг гаргаж, хэт их ачаалал өгөхгүй байх тал дээр анхаарч ажилласан. Хичээлийн хажуугаар багш нар хүүхдүүдэд Японы сургууль соёлын ялгаа гэх зэрэг япон орны талаар ярьж өгөх үед хүүхдүүд их анхааралтайгаар чих тавин сонсох дуртай байлаа. Энэ мэтчилэн хүүхдүүд маань өдөр бүр бага багаар япон хэл болон япон орны талаар хамтдаа эргэцүүлэн бодож, өөрийн мэддэг бүхнээ нэгэндээ хуваалцаж хамтдаа суралцсаар байсан юм. Хэдий богино хугацаа ч гэсэн эрч хүчээр дүүрэн бяцхан суралцагчид маань япон хэл болон соёлын талаарх мэдлэгээ тэлэхээс гадна японоор бусадтай мэндчилж гэр бүл, дуртай зүйлс, сонирхол хобби зэрэг өөрийнхөө талаар товчхон танилцуулж чаддаг болоод сургалтаа дуусгасан юм.

Энэхүү сургалт нь суралцагч хүүхдүүдийн маань хувьд зуны амралтынх нь нэгэн дурсгалт мөч болсон болов уу хэмээн найдаж байна. Хүүхдүүд маань цаашид ч япон хэл, соёлын талаар сонирхон судалж, Монгол, Япон 2 улсыг холбох гүүр нь болох болтугай.

2) “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”

“Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”-ыг 2022 оны 5 сараас 8 сар хүртэл 3 сарын хугацаанд 100 цагаар амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн сургалт “Иродори хэрэглээний япон хэл” A1 түвшин хэмээх сурах бичгийг ашигласнаараа онцлогтой. Сурах бичгийн тухайд японд ажиллаж амьдрах зорилготой гадаад хүмүүст зориулсан амьдралд хэрэглэгдэх бодит хэрэглээний япон хэлийг эзэмшүүлэх агуулгатай бөгөөд “Япон хэлээр дамжуулан хийж чадах зүйлс”-ийг нэмэгдүүлэхийг зорьдог. Агуулгаас дурдвал “Японд ажиллах, худалдан авалт хийх, зугаалах, хооллох, хүмүүстэй харилцах гэх мэт янз бүрийн нөхцөл байдалд хэрэглэгдэх бодит хэрэглээг тусгаж өгсөн. Тус сургалтын 15 суралцагчид 20-30 насныхан ба бүгд төрийн албан хаагчид юм. Өөрсдийн үндсэн ажлын дараа япон хэлний сургалтад 7 хоногт 4 өдөр 18:30-20:30 цаг хүртэл хичээллэдэг байв. Сургалтын хугацаанд япон хэлний цагаан толгойн үсгээс эхлэн суралцаж, өөрийгөө танилцуулах, хобби сонирхолоо хэлэх, амралтын өдөр юу хийсэн талаар ярих, дуртай хоол хүнснийхээ талаар ярилцах гэх мэт өөрт ойр олон сэдвийн хүрээнд япон хэлийг үзэж судалсан. Сургалтыг үндсэн агуулгаас гадна давтлага, соёлын хичээл, ярианы дадлага, явц ба төгсөлтийн бичгийн болон ярианы шалгалт гэсэн хөтөлбөртэйгээр зохион байгууллаа. Сургалтад нийт 4 багш баг болон хамтран ажилласан бөгөөд сургалтын хөтөлбөрийн бүх материалыг хамтран бэлтгэлээ. Гэрийн даалгавар, жижиг тест, бичиг болон ярианы шалгалт гэх мэт материалыг үндсэн сурах бичгийн стандарттай уялдуулан боловсруулсан болно.

Сургалтын төгсгөлд авсан санал асуулгад суралцагчид “Сургалтад хамрагдсандаа сэтгэл ханамжтай байна”, “Япон хүнтэй ярилцаж үзсэн нь том туршлага болсон”, “Япон бийрэн бичлэгийн хичээл сайхан байсан” хэмээн сургалтыг дүгнэсэн байв. Хамгийн гол нь бидний хичээнгүйлэн зохион байгуулсан сургалтын агуулга болон багш нарын заах ур чадварыг суралцагчид маань өндрөөр үнэлж, сэтгэл хангалуун байсан нь багш бидний хувьд нэгэн том урам зориг боллоо.

Хичээнгүйлэн суралцсан суралцагчид маань одоо Японд өөрсдийн элссэн их



сургуульдаа амжилттай суралцаж буй бөгөөд өдөр тутмын амьдралд нь Монгол-Японы төвд суралцсан япон хэл нь тун их хэрэг болж байгаа гэдэгт итгэлтэй байна. Нийт суралцагчиддаа цаашдын сурлага хөдөлмөрт нь өндөр амжилт хүсье.



Зураг 25. “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”

3) “Кёотогийн их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөрт элсэн орогчдод зориулсан япон хэлний бэлтгэл сургалт-2022”

Энэхүү сургалт нь Кёотогийн их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөр /Kyoto University International Undergraduate Program (Kyoto iUP)/-т тэнцсэн оюутанд зориулан тухайн оюутны хөтөлбөрт тэнцсэн цаг үеэс Японд очиж суралцах хүртэлх хугацаанд явуулж буй япон хэлний бэлтгэл сургалт бөгөөд тухайн суралцагчийн япон хэлний мэдлэгийг 1 түвшнээр ахиулж, 2022 оны 10 сараас эхлэх бакалаврын хөтөлбөртөө хэлний бэрхшээлгүй суралцаж чадахуйц мэдлэгийг олгох зорилготой сургалт юм.

Сургалтыг Кёотогийн их сургуулийн хүсэлтээр 3 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд тус их сургуулийн хүсэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулан, 2022 оны 6 сарын 13-ны өдрөөс 8 сарын 22-ны өдрийг дуустал 7 хоногт 3 удаа, 1 удаад 3 цагаар, нийт 75 цагийн сургалтыг амжилттай зохион байгуулав. Сургалтын үндсэн сурах бичгээр "Марүгото Япон хэл ба соёл" /дунд шат-2, B1/, нэмэлт сурах бичгээр "Минна но нихонго" /дунд шат-1/-ийг ашигласан бөгөөд гэрийн даалгавар, бие даалтын ажлыг google classroom ашиглан явуулсан юм.

Сургалтад хамрагдсан 1 суралцагчийн хувьд суралцах хүсэл эрмэлзэл өндөр, хичээлийн оролцоо хандлага сайн байсны дээр бүхий л даалгавар, дасгал ажлыг хичээнгүйлэн гүйцэтгэж байсан нь үнэхээр сайшаалтай байлаа. Давтлага, бие даалт болон хичээлийн өмнөх урьдчилсан бэлтгэл зэрэг гэрээр бие даан хийх ажлуудыг цаг тухайд нь идэвх чармайлттай хийж, хичээлийн ирц болон бие даалт 100%, төгсөлтийн шалгалтыг 100 онооноос 90 оноотой өгч амжилттай төгссөн юм.

Сургалт эхлэх үеийн суралцагчийн хэлний чадварын хувьд сонсох, унших чадвар өндөр байсан ч, ярианы хувьд хоорондоо уялдаа холбоогүй, дүрмийн алдаа ихтэй байсан бол сургалтын дунд үеэс ярианы бүтэц мэдэгдэхүйц сайжирч, дүрмийн алдаа ч



багасаж ирсэн юм. Нөгөөтэйгүүр бичих чадварын хувьд, багш нарын зүгээс бүтцэд нь илүү анхаарч чиглүүлснээр өөрийн үзэл бодол, сэтгэгдлийг зөв ойлгуулж бичих чадвартай болж ирсэн. Японд намраас зохион байгуулагдах урьдчилсан сургалт нь тэдний япон хэлний мэдлэгийг улам дээшлүүлнэ гэж найдаж байна.

Кёотогийн их сургуулийн хүсэлтийн дагуу явуулж буй энэхүү гэрээт сургалтын хувьд бид цаашид ч гэсэн хөтөлбөрт тэнцсэн оюутнуудын япон хэлний түвшинд тохируулсан сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулах, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулахын төлөө хичээн ажиллах болно.



Зураг 26. “Кёотогийн их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөрт элсэн орогчдод зориулсан япон хэлний бэлтгэл сургалт-2022”

4) “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв болон Япон сан нь 2019 оноос эхлэн “Тусгай ур чадварын тогтолцоо”-г сурталчлан таниулах, ялангуяа тус тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай япон хэлний боловсролыг дэмжин ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байгаа билээ. Гэрээт ажлын хэрэгжилтийн хүрээнд дараах 3 гол чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Япон хэлний багш нарт зориулсан “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийн заах аргын сургалтыг зохион байгуулах
2. Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-ын талаарх зар мэдээлэл түгээх, удирдамж семинарыг зохион байгуулах
3. Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгууллагын судалгаа, япон хэлний сургалтын талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх

2022 онд Япон сангаас томилогдон ажиллаж буй япон хэлний мэргэжилтэн Цүрүта Ясүюкигийн удирдлага дор монгол хэлээр орчуулагдан гараад буй “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийг сургалтад хэрхэн ашиглах тухай заах аргын сургалтыг зохион явуулав. Япон хэлний багш нарыг дэмжих зорилгоор тус семинарыг танхимын хэлбэрээр нийт 3 удаа зохион байгуулж, 37 багш оролцлоо. Сургалтад оролцсон багш нартаа “Иродори” сурах бичгийн 3 боть болон “Иродори Японд амьдрах талаарх зөвлөмжүүд” номыг бэлэглэсэн.


Дараагийн нэг том ажил бол JFT-Basic шалгалтын талаарх мэдээлэл түгээх ажил юм. Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалтын талаарх мэдээлэл түгээх зорилго бүхий “JFT-Basic in Mongolia” фэйсбүүк хуудсанд шалгалтын талаарх үндсэн мэдээлэл, шалгалтын тов болон бүртгэл эхлэх өдөр зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүрт



нь оруулав. Мөн JFT-Basic шалгалтын талаарх удирдамж семинарыг явуулсан ба 2022 онд цахим болон танхим хэлбэрээр нийт 5 удаа зохион байгуулж, семинараар дамжуулан 121 хүнд мэдээлэл хүргэж ажиллалаа. Удирдамж семинарт JFT-Basic шалгалт гэж ямар шалгалт болох, шалгалтын бүртгэл, шалгалтын үйл явцыг нарийвчлан тайлбарласан бөгөөд жишээ асуултын дагуу дасгал ажиллаж, шалгалтын бэлтгэлд ашиглах сурах бичиг болон “Иродори онлайн сургалт” цахим хуудсыг танилцуулсан.

Мөн шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын хүрээнд, 1-рт япон хэлний JFT-Basic шалгалтад бэлдэж буй суралцагчид болон япон хэлийг бие даан суралцах хүсэлтэй хүмүүст зориулан “Иродори япон хэлний онлайн сургалт”-ын танилцуулах хичээлийг 2 удаа танхимаар зохион байгуулсан. Нийт 27 хүн орлцсон ба тухайн танилцуулах хичээлийг мөн видео хэлбэрээр хийж “JFT-Basic in Mongolia” фэйсбүүк хуудсанд байршуулж олны хүртээл болгосон. JFT-Basic шалгалт өгөгчдийн зүгээс туршлага хуваалцсан видеог хийж мөн адил фэйсбүүк хуудсанд байршуулсан. 2-рт өнгөрсөн жил Япон сангаас эрхлэн гаргасан “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийг суурь шатнаас эхлэн монгол хэлээр үзэх боломжтой болсон билээ. Тус “Иродори хэрэглээний япон хэл” 3 боть сурах бичгийн шинэ үгийн жагсаалтыг монгол хэлээр хөрвүүлэн, дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүст хялбархан ашиглах боломж олгох үүднээс вэбсайтад байршуулсан болно. Энэхүү сурах бичиг нь япон хэл, соёлыг сонирхон судалж, JFT-Basic шалгалтад бэлдэж буй хэн бүхэн үнэгүй татан авах боломжтой юм.

2023 онд Япон улс руу ажиллах хүч илгээгч байгууллага болон япон хэлний сургалтын үйл ажиллагаа явуулж буй хэлний төвийн нийт багш нарт зориулан “Иродори сурах бичгийн заах арга зүйн туршлага солилцох семинар” зэрэг олон төрлийн үйл ажиллагааг төлөвлөгөөндөө тусгахыг зорьж байна.



Зураг 27. “Иродори” сурах бичгийн заах арга зүйн туршлага солилцох семинар

“2022 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн”

“2022 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн” нь 2022 оны 9 дүгээр сарын 17-ны Бямба гарагт зохион байгуулагдлаа. Энэхүү уран илтгэлийн тэмцээн нь 2 жилд 1 удаа зохиогддог бөгөөд энэ жил 4 дэх удаагаа амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэхүү уран илтгэлийн тэмцээн нь япон хэлийг суралцаж, Нийгата мужийн талаар сонирхон судалдаг Монголын оюутан залууст



зориулан зохион байгуулагддаг бөгөөд Монгол дахь япон хэлний боловсролын хөгжил, Монгол улс болон Нийгата мужийн харилцааг улам бэхжүүлэх зорилготой юм. Тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Нийгата мужийн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, хамтран зохион байгуулагчаар Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Монгол-Нийгатагийн хамтын ажиллагааны нийгэмлэг, дэмжигч байгууллагаар Япон Улсын Элчин Сайдын Яам, JICA-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Нийгата муж, Нийгата мужийн хамтын ажиллагааны нийгэмлэгүүд тус тус хамтран зохион байгуулсан юм.

Энэ жилийн тэмцээн “Япон улстай найрсаг харилцааг хэрхэн хөгжүүлэх вэ?” сэдвээр явагдсан бөгөөд япон хэлний сургалт явуулж буй 4 их сургууль болон коосэн технологийн коллежийн 6 мэргэшлийн нийт 9 оюутан амжилттай оролцлоо. Энэ удаагийн илтгэлийн тэмцээн нь танхим болон цахимаар шууд дамжуулалт хосолсон хэлбэрээр зохион байгуулагдсанаараа онцлог юм. Танхимд хүрэлцэн ирсэн үзэгч, хөгжөөн дэмжигчид өмнөх жилүүдээс цөөн буюу 60 орчим хүн байсан ч, тэмцээний дараа илтгэлийн бичлэгийг олон хүн үзэж сонирхсон юм.



Зураг 28. “2022 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн”

3. МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ОНЦЛОХ МЭДЭЭ

1) "ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2022"

2022 оны 1 сарын 10-аас 14-ний өдрүүдэд орон нутаг болон нийслэлийн ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулан “ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2022”-ыг амжилттай зохион байгууллаа. 2020 оноос эхэлсэн энэхүү сургалт маань энэ онд 3 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдаж байгааг хэлэхэд таатай байна. 2020 онд зохион байгуулагдсан анхны сургалтыг зөвхөн орон нутгийн япон хэлний багш нарыг дэмжих зорилгоор зохион явуулж байсан ч нийслэлийн япон хэлний багш нараас оролцох хүсэлт олноор ирсэнтэй холбоотойгоор өнгөрсөн жил буюу 2 дахь



удаагийн сургалтаас эхлэн цар хүрээгээ тэлэн, орон нутаг төдийгүй нийслэлийн ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулан зохион явуулсан юм.

Энэ жил ч гэсэн өмнөх жилүүдийн нэгэн адил ЕБС-ийн өвлийн амралтын хугацаанд зохион байгууллаа. Сургалтад оролцох багшийн тоог нийт 25 багш байхаар тооцсон боловч, 56 багш оролцох хүсэлт гарган бүртгүүлж, сонгон шалгаруулалтын дүнд эцсийн байдлаар 43 багшийг сонгож авснаас 41 багш сургалтдаа бүрэн хамрагдсан юм. Сургалтад орон нутгийн 6 багш, Япон 6 багш оролцов. Сургалт 5 өдрийн турш цахим хэлбэрээр явагдсан бөгөөд “Хичээлийг хөгжилтэйгөөр удирдан явуулах заах аргын үндэс”, “Иродори” сурах бичгийг сургалтдаа хэрхэн ашиглах тухай”, “Ханз үсгийг хэрхэн заах тухай”, “Соёлын хичээлийг хэрхэн заах тухай”, “Бичих чадварыг хөгжүүлэх хичээлийг хэрхэн заах тухай”, “Цахимаар суралцаж болох сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн зөв ашиглах тухай” сэдвийн дор явагдлаа. Сургалтын 5 өдрийн сэдэв тус бүр багш нараас өндөр үнэлгээ авсан бөгөөд сэтгэл ханамжийн хувь ч өндөр байлаа. Сургалтын дараах санал асуулгыг 34 багш бөглөснөөс сургалтад хамрагдсан сэтгэгдлийн хувьд “маш сэтгэл хангалуун” хэмээх хариулт 91.2%, “сэтгэл хангалуун” хэмээх хариулт 8.8%-ийг эзэлж байна.

Эцэст нь дүгнэхэд, цар тахлын нөхцөл байдал үргэлжилж буй энэ цаг үед цахим болон танхимын хичээлийн шинэчлэлт, ахиц дэвшлийн төлөө хичээн зүтгэж буй багш нарын хүчин чармайлт, суралцах идэвхийг мэдэрсэн үр дүн бүхий сургалт болж өндөрлөлөө хэмээн үзэж байна. Сургалтаар дамжуулан нийслэл болон орон нутгийн япон хэлний багш нар хоорондын харилцаа холбоог идэвхжүүлж, өдөр тутмын хичээлийн арга барилаа эргэн харах, шинээр мэдлэг мэдээлэл олж авах зэрэг багшийн хувьд хөгжих боломж олгосон сургалт болж чадлаа.

Бид ирэх жил ч гэсэн уламжлал ёсоор энэхүү сургалтаа зохион байгуулах бөгөөд энэхүү сургалт нь ЕБС-ийн япон хэлний боловсролыг хөгжүүлэн дэмжихэд хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

2) “14 дэх удаагийн япон хэлний боловсролын симпозиум” зохион байгуулагдлаа

2022 оны 3 сарын 5-ны Бямба гарагт “14 дэх удаагийн япон хэлний боловсролын симпозиум” Монгол-Японы дипломат харилцаа үүсгэн байгуулагдсаны 50 жилийн ой, Монгол-Япон хүний нөөцийн хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдлаа. Ерөнхий зохион байгуулагчаар Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо, хамтран зохион байгуулагчаар Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв болон Япон сан, дэмжигчээр Монгол улс дахь Япон Улсын Элчин Сайдын Яам ажиллалаа. Симпозиумын сэдэв нь “Монгол дахь япон хэлний сургалтын хөтөлбөр - ICT -ийн хэрэглээ ба цаашдын төлөв” бөгөөд Кёотогийн Их Сургуулийн Дээд боловсролын судалгаа, хөгжлийн төвийн дэд профессор Тагүчи Мана багш "Япон хэлний сургалтын хөтөлбөр - ICT сургалтын хөгжил ба багшийн үүрэг -" гэсэн сэдэвтэй үндсэн лекцийг уншлаа. Түүний дараа монголын их дээд сургуулийн 3 багш “Монгол Улсын их сургуулиудад япон хэлтэй мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн өнөөгийн байдал-МУИС, МУБИС ШУТИС-ийн жишээгээр-”, ЕБС-ийн 5 багш "Монголын бага, дунд сургуулийн япон хэлний хичээлийн хөтөлбөр, онлайн хичээлийн талаар авч үзэх нь", сургалтын төвийн 12 багш хамтран “Монгол дахь сургалтын



төвүүдийн япон хэлний сургалтын өнөөгийн байдал” гэсэн сэдвийн хүрэн илтгэл тавьлаа.



Зураг 29. “14 дэх удаагийн япон хэлний боловсролын симпозиум”

3) Өвөрхангай аймгийн Мэргэд сургуульд ажилласан томилолтын талаар

Шинэ төрлийн коронавирус батлагдаж цар тахал болсноос хойш 2 жил гаруй хугацаа өнгөрч, энэ хугацаанд танхимаар зохион байгуулагддаг ажлууд ар араасаа цуцлагдсан. Бидний хувьд япон хэл суралцагчид болон япон соёлыг сонирхдог хүмүүстэй харилцаж үйл ажиллагаа явуулж чадахгүй, томилолтоор ч явж чадахгүй байгаадаа сэтгэл дундуур байлаа.

Харин 2022 оноос бүх зүйл бага багаар хэвийн байдал руу шилжиж, орон нутаг дахь томилолтыг хэрэгжүүлэх боломжтой болсноор бид Өвөрхангай аймгийн Мэргэд сургуулийг зорьсон юм. Ингээд 2022 оны 3 сарын 14-өөс 15-ны өдрүүдэд тус сургуульд 2 өдрийн үйл ажиллагаа зохион байгуулав.

Мэргэд сургууль нь 1998 оноос хойш 24 дэх жилдээ япон хэлний боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ жилийн хувьд 3-12 дугаар ангийн нийт 284 орчим сурагчид япон хэл сурч байна. Мөн япон хэлний түвшин тогтоох шалгалтыг тус сургуулийн байранд зохион явуулдаг. Биднийг зорин очиход сургуулийн захирал, гадаад хэлний сургалтын менежерүүд болон япон хэлний багш Дуламсүрэн нар халуун дотноор угтан авч уулзсан. Мэргэд сургууль бол чадварлаг багш боловсон хүчинтэй бөгөөд япон хэл сурдаг сурагчид нь JLPT шалгалтыг идэвхтэй өгдөг, япон хэлний уран илтгэлийн тэмцээнд байнга оролцдог, мөн төгсөгчдөөс нь Япон руу зорьж очдог хүмүүс ч олон байдаг гэж байлаа. Тус сургуулийн япон хэлний сургалтын ач холбогдлынх нь талаар сонирхоход, тэд байгуулагдсан цагаасаа эхлэн Япон улстай найрсаг харилцаатай, цаашлаад дэлхийд өрсөлдөхүйц боловсон хүчнийг бэлтгэх хүсэл зорилго дүүрэн байв.

Мөн Мэргэд сургууль нь 2020 оны Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд “Япон хэлний ангийн кабинет тохижуулах төсөл”-ийг өргөн барьж буцалтгүй тусламжийн гэрээ байгуулснаар хуучирсан анги танхимуудыг засварлаж, мэдээлэл технологийг ашигласан сургалтын орчныг



сайжруулж байв. Төслийн ажлыг төлөвлөгөөний дагуу 2022 оны эцэс гэхэд дуусгах төлөвлөгөөтэй байлаа.

Ингээд бид сургуультай танилцаж мэдээлэл солилцсоны дараа япон хэл суралцагчдын суралцах идэвхийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанууд болон сургуулийн хүсэлтийн дагуух үйл ажиллагааг явуулсан юм. Үүнд, Японы цаасан нугалбар, уран бичлэг, японы үндэсний хувцас юката, япон тоглоом кэндама зэрэг соёлын хичээлүүд, “Япон орныг хэн сайн мэдэх вэ” тааварт тэмцээн, анимэ, японд сурах зөвлөгөө, япон хэлний түвшин тогтоох шалгалт өгөх талаар удирдамж тайлбар зэргийг явуулав.

Япон сангийн мэргэжилтний зүгээс Дуламсүрэн багшийн япон хэлний хичээлийг үзэж, зөвлөгөө өгсөн. Мөн суралцагчдад ярианы дадлага хийлгэх зорилгоор Арвайхээр хотыг японоор танилцуулах бяцхан аялал хийв. Дараа нь Монголын цагаан сарын тухай ахлах ангийн сурагчдын илтгэлийг сонсож, асуулт хариулт өрнүүлсэн.

Сурагчдаас авсан санал асуулгад “Үйл ажиллагаанууд их таалагдлаа”, “Хөгжилтэй гоё байсан”, “Олон зүйл сурч авлаа”, “Сонирхолтой байсан”, “Маш их хэрэгтэй мэдээлэл авлаа”, “Япон соёлтой танилцах боломж олгосонд маш их баярлалаа” гэсэн сэтгэгдэл олон байсан юм. Хэдий богино хугацаа байсан хэдий ч орон нутаг дахь япон хэл суралцагчдад тусалж чадсандаа үнэхээр баяртай байна.

Томилолтын төгсгөлд сургуулийн зүгээс бидэнд “Манай сургуулийг зорин ирсэнд баярлалаа” хэмээн Мэргэд сургуулийн япон хэлний боловсролыг дэмжин ажилласан тухай талархлын бичгийг гардуулсан юм.

Өвөрхангай аймгийн Арвайхээр хот нь япон хэлийг ашиглах орчин хомс газар хэдий ч, сурагчдын суралцаж буй байдал, хандлага, илтгэл зэргээс тэдэнд япон хэл, япон соёлыг суралцах хүсэл тэмүүлэл ямар их байгааг бид мэдэрсэн. Орон нутагт япон хэл сурч буй сурагчид болон тэдний боловсролыг дэмждэг япон хэлний багш нар, боловсролын байгууллагуудыг Япон сан, Монгол-Японы төв, Элчин Сайдын Яам зэрэг газрууд үргэлжлүүлэн дэмжих шаардлагатай бөгөөд иймэрхүү үйл ажиллагаа нь япон хэлний боловсролыг дэмжихэд зайлшгүй байх хэрэгтэй гэдгийг ч мөн дахин ойлгож авсан юм.



Зураг 30. Өвөрхангай аймгийн “Мэргэд” сургуульд ажилласан томилолт



4) Монгол-Японы төвийн япон хэлний сургалт төгсөгчдийн уулзалт болон соёлын өдөрлөг

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 сарын 21 өдөр Бямба гарагт Монгол-Японы төвийн япон хэлний сургалт төгсөгчдийн уулзалт болон соёлын өдөрлөгийг зохион байгууллаа.

Тус өдөрлөгөөр төвийн япон хэлний сургалтад хамрагдаж байсан үе үеийн 350 орчим төгсөгчид цугларч, соёлын арга хэмжээнүүдэд оролцож дурсгалын зураг татуулан, багш нартайгаа хууч хөөрч дахин нэг дурсамж дүүрэн өдрийг өнгөрүүлсэн юм.

Монгол-Японы төвийн япон хэлний сургалтад япон хэл заах төдийгүй суралцагчдын япон хэл соёлд хандах хандлага, хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор япон соёлыг танилцуулах хичээлүүд ч ордог юм. Энэ удаагийн өдөрлөгөөр Японы уламжлалт гар урлал болох зангилаан чимэглэл “Мизүхики” хийх, “Садоо” буюу цайны ёслолтой танилцах, “Фүрошики” япон баглаа боодлын соёлд суралцах, япон үндэсний хувцас “Юката” өмсөж үзэх, Нинжагийн дүрд хувирах, япон тоглоом “Кэндама” тоглох, “Япон орныг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн гэсэн япон соёлтой танилцах 7 төрлийн арга хэмжээг зохион явуулсан.

Өдөрлөгт оролцсон нийт төгсөгчдөөс санал асуулга авахад “Өмнө нь гар бие оролцож үзэж байгаагүй япон соёлуудтай танилцсандаа баяртай байна”, “Маш сэтгэл хангалуун байна”, “Жил бүр ийм өдөрлөг зохион байгуулж байвал гоё байна” гэсэн сэтгэгдэл олон байсан бөгөөд сэтгэл ханамжийн хувь ч өндөр байсан юм. Ийнхүү тэдний сэтгэл ханамж өндөр байсан гол шалтгаан нь олон төрлийн соёлын арга хэмжээнд оролцсоны дээр, Нинжагийн дүрд хувирах болон Японы уламжлалт гар урлал болох зангилаан чимэглэл “Мизүхики” хийх зэрэг анх удаа зохион байгуулсан соёлын арга хэмжээ олон байсантай холбоотой гэж үзэж байна.

Ингээд тус арга хэмжээнд оролцохоор зорьж ирсэн үе үеийн төгсөгч хүүхдүүдээ мөн зохион байгуулахад хамтран ажилласан хүмүүстээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Тус арга хэмжээнд оролцсоноор төгсөгчдийн маань япон соёлын талаарх мэдлэг туршлага болон цаашид япон хэл сурах хүсэл эрмэлзэлд нь багахан ч болов хувь нэмэр болж чадсан болов уу гэж найдаж байна.



Зураг 31. Монгол-Японы төвийн япон хэлний сургалт төгсөгчдийн уулзалт болон соёлын өдөрлөг



Зураг 32. Монгол-Японы төвийн япон хэлний сургалт төгсөгчдийн уулзалт болон соёлын өдөрлөг

5) “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн”

2022 оны 11 сарын 19-ний өдөр “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн”-ийг амжилттай зохион байгууллаа.

Хамтран зохион байгуулагч: Монгол дахь Япон улсын элчин сайдын яам, Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, ШУТИС-Гадаад хэлний сургууль, Япон сан

Дэмжигч байгууллага: Монгол дахь Япончуудын холбоо ТББ, Монгол Японы худалдааны танхим ТББ.

Тэмцээнд “Ахлах ангийн сурагч” ангилалд 9 сурагч, “Их, дээд сургуулийн оюутан” ангилалд 8 оюутан оролцов. “Ахлах ангийн сурагч” ангиллын сурагчид “失敗から学んだこと” буюу “Алдаанаасаа суралцсан зүйл” гэсэн сэдвээр, “Их, дээд сургуулийн оюутан” ангиллын оролцогчид “距離” буюу “Орон зай” гэсэн сэдвийн дагуу тус тус илтгэлээ тавьсан.

Энэ жил ангилал тус бүрээс 4 оролцогч шагналт байранд шалгарсан бөгөөд энэ жилийн тэмцээн нь Монгол, Япон хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан учир Монгол дахь Япон улсын элчин сайдын яамнаас шагналт байранд шалгарсан 8 оролцогчдыг бүгдийг нь “JENESYS” буюу Япон орны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх солилцооны хөтөлбөрт хамрагдах эрхээр шагнасан онцлогтой жил боллоо.

Оролцогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаа дээр “Япон хэлний чадвар сайжирлаа”, “Япон орон болон Япон орны соёлын талаар илүү мэдэх хүсэлтэй болсон”, “Өнөөг хүртэл ямар ч зорилгогүйгээр япон хэлийг сурч ирсэн. Харин одоо бол япон хэлээ илүү сайн сураад япон явж сурна гэсэн хүсэл мөрөөдөл, зорилготой боллоо” зэрэг сэтгэгдлүүдийг бичсэн байсан. Мөн хамтран зохион байгуулагчдын зүгээс “Өнөөг хүртэлх тэмцээнүүдтэй харьцуулахад өөрийн амьдрал дээр туулж мэдэрсэн туршлагад үндэслэсэн сэдвийн талаарх илтгэл сонсох нь их сонирхолтой байлаа”, “Орон зай гэсэн агуулгыг олон талаас нь илэрхийлсэн илтгэлүүдээс надад сурах зүйл их байлаа” гэх зэрэг сэтгэгдлүүдийг үлдээсэн байлаа.



Зураг 33. “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 28 дахь удаагийн тэмцээн”

4. СУРАЛЦАГЧДЫН ДУУ ХООЛОЙ

Та бүхэнд баярлалаа!

Сайн байна уу? Миний нэрийг Түмэн-Өлзий гэдэг. Япон хэлний сургалт маш гоё байсан. Яагаад гэвэл би япон үсэг, япон үг, япон тоглоом, япон дуу мөн бүжиг сурсан. Би дарүмагийн тэмцээнд өрсөлдөөд ялсан. Тэгээд бэлэг авсан. Бэлэг дотор зааны хэлбэртэй баллуур, харандаа байсан. Надад дарүма тоглоом, төгсөлтийн баяр, сургалтын эхний өдөр, ер нь бүх зүйл гоё байсан.



Зураг 34

“8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”

Суралцагч С.Түмэн-Өлзий

Сайн байцгаана уу?

Монгол-Японы төвөөс зохион байгуулсан “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт”-д 2022 оны 7 сард хүүгээ сургасан. Зуныхаа амралтыг үр дүнтэй өнгөрүүлсэн төдийгүй сургуулийнхаа орчныг солиод шинэ анги, шинэ найз нөхөдтэй болсон.

Япон хэлний үсэг сурахаас гадна, үндэсний тоглоом тоглож бас дуу бүжиг сурсан байсан. Ангийн багш нар нь хичээлээ хүүхдэд ойлгомжтой заадаг төдийгүй бага ангийн хүүхдэд яаж хөгжилтэй байдлаар хичээлээ зааж ойлгуулах вэ? гэдэг тал дээр маш сайн ажилласан санагдсан. Хичээлийн дараа ангидаа үлдээд гэрийн даалгавраа хийж болдог нь маш давуу талтай санагдсан. Анги танхим нь тухтай, хичээл заах хэрэгслээр бүрэн тоноглогдсоны дээр хүүхдэд үнэхээр үр дүнтэй сургалт болж өнгөрсөн.

Суралцагчийн ээж С.Мэнд-Амар



Мөрөөдөлд хүрэх зам

Миний бага нас Япон улсын Акита хотод өнгөрсөн. Намайг 2 настай байхад ээж маань Япон улс руу докторын зэрэг хамгаалахаар явах болсноор бид гэр бүлээрээ япон улсыг зорьж миний япон хэл сурах эхлэл тавигдсан юм. Акита хотын “Кодомоно күни” болон “Асахи” цэцэрлэгүүдэд явдаг байсан сайхан дурсамжаас одоо зураг л үлдэж дээ. Ээж маань докторын зэргээ амжилттай хамгаалж Монголдоо ирэхэд би 4 нас гарантай монгол цэцэрлэгт орсон. Энэ үеэс япон хэл хэрэглэгдэхгүй, ярьж ойлголцох хүмүүс байхгүй учраас нэг л мэдэхэд япон хэлээ мартсан. Гэхдээ япон улсын талаарх сайхан дурсамжууд үе үе санаанд ордог. Улс орныхоо амьдрал соёлыг тусган харуулсан япон анимэ үзэх бүрт япон хэлээ сэргээх юмсан, оюутан болоод япон улсад сурах юмсан гэж бодогддог.



Зураг 35

Ингээд энэ намар Монгол-Японы төвд суралцах болсноор мөрөөдлийн маань эхлэл тавигдсан. Анх сургалтын төвд ирээд “ЕБС-ийн сургуулиуд ийм болчихвол хүүхэд бүхэн хичээлдээ дуртай болох байхдаа” гэсэн сэтгэгдэл төрж байлаа.

Хичээлийн 1 цаг 30 минутад өмнөх хичээлд үзсэн үг, дүрмүүдээ давтах, богино хэмжээний эхүүд унших, сонсох, ярих дасгалууд, шинээр үзсэн үгнүүдээ давтах хөгжилтэй тоглоомууд зэрэг их зүйл амжуулдаг нь үнэхээр сонирхолтой байдаг. Мөн хэд, хэдэн хичээл орсны дараа өөрийгөө үнэлэх хуудсан дээр хичээлийн тухай сэтгэгдэл бичүүлж авч, түүнийгээ шалгаад буцааж өгөхдөө багшийн бичсэн байдаг тэр сайхан урмын үгс, зөвлөмж зэргээс урам зориг, баяр хөөр авдаг байсан. Ийм сайхан орчин бүрдүүлж эелдэг найрсаар мэдлэгээ хуваалцдаг багш, сургалтын төвийн хамт олонд баярлаж явдаг юм.

Эхний шатны төгсөлт аавын маань төрсөн өдрөөр тохиосон. Ингээд аавынхаа төрсөн өдрөөр анхан шатны сургалтаа амжилттай төгссөн сертификат, өөрийн гараар бэлтгэж японоор бичсэн мэндчилгээгээр бэлэг барьж аавыгаа ихэд баярлуулсан. Аав маань япон хэлээ төгс эзэмших хүртэл сургалтаа үргэлжлүүлэхийг надаас хүссэн юм. Өөрийнхөө мөрөөдөлд хүрэх, аавынхаа хүслийг биелүүлэхийн төлөө цаашид япон хэлээ хичээнгүйлэн сурах болно.

“Хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт”

Суралцагч Э.Хонгорзул



Сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Э.Шижир гэдэг. Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний сургалтын заах арга, хичээл, сурах бичиг гэх мэт маш олон зүйл нь надад таалагдсан. Би ер нь л гадаад хэл сурах дуртай. Багаасаа л япон хэл сурна гэж боддог байсан. Сургуулиа төгсөөд Япон явах зорилготой учраас япон хэл сурах шаардлагатай ч болсон. Тэгээд Монгол-Японы төвд ийм сургалт байдаг юм байна гэдгийг мэдэж аваад шууд бүртгүүлсэн. Анх удаа очих гээд явж байхад маш их сандарч байсан. "Яах бол", "Ямар багш нар байдаг бол" гээд зөндөө л бодол толгойд эргэлдэж байсан. Гэхдээ зориглон очоод хичээлдээ суутал тэр бодлууд маань шууд л алга болсон. Орчин нь тохилог цэвэрхэн, яг Японд оччихсон юм шиг санагдаад, хүмүүс нь үнэхээр гоё ааштай, багш нар нь хичээлээ маш ойлгомжтойгоор заадаг гээд л маш олон зүйл нь таалагдсан. Тэгээд сургалтынхаа хугацаанд япон хэл, япон улсад илүү дуртай болж эхэлсэн. Японд очиж сурна гэдэг хүсэл мөрөөдөл минь үнэхээр зөв сонголт болохыг эндээс ойлгосон.



Зураг 36

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги” Суралцагч Э.Шижир

Мөрөөдөлдөө хүрэхэд нэг алхам ойртсон нь

Сайн байцгаана уу? Намайг Номин-Эрдэнэ гэдэг. Би Соёл урлагийн их сургуулийн төгсөх курсийн оюутан. Уран зураг мэргэжлээр сурдаг. Япон улсад очиж хүүхэлдэйн кино зурж хийж сурах явдал бол миний хамгийн том мөрөөдөл. Өөрөөр хэлбэл мэргэжлийнхээ дагуу Япон улсыг сонирхон тэндээ суралцах зорилготой учраас юун түрүүнд япон хэл сурахаар Монгол-Японы төвийг сонгон ирсэн. Мөн би япон улсад анхнаасаа дуртай, анимэ их үздэг байсан учир хэлийг нь сурахад маш сонирхолтой байсан. Анх ангидаа орж ирээд маш олон мэдэхгүй үсэг, үгнүүдийг хараад энэ бүгдийг уншиж чаддаг болоод гарнадаа гэсэн зорилго тавьж байснаа маш сайн санаж байна. Хичээлийн дунд үед нэг л мэдэхэд тэр бүх үсэг, үгнүүдийг уншдаг болсон байсан. Энэхүү сургалтаар япон хэлээс гадна бусдад төвөг болохгүй байх, цаг баримтлах, бусдыг хүндлэх гэх мэт олон зүйлийг сурч өөртөө хэвшүүлж чадсан.



Зураг 37

Багш нартаа их талархаж байгаагаа илэрхийлмээр байна. Багш нар маань хичээлийг ойлгомжтой заахаас гадна биднийг япон улсын соёлын талаар ихээхэн мэдлэгтэй болгож чадсан. Сургалт миний хүлээлтэд хүрсэн. Зарим талаар бүр төсөөллөөс ч илүү байж чадсан. Нарийн зохион байгуулалт, зөв системтэй сургалт байсан учир би Япон улс руу явах хүртлээ Монгол-Японы төвд суралцсаар байх болно.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги” Суралцагч Ж.Номин-Эрдэнэ



Хүн насан туршдаа суралцдаг

Бага охин маань япон хэл сурах хүсэлтэй байгаагаа бидэнд хэлэхэд судалж үзээд Монгол-Японы төвийг сонголоо. Нөхөр маань намайг охинтойгоо хамт япон хэл үзэхийг санал болгоход сайхан санагдаж байсан ч сурч чадах эсэхдээ бага зэрэг эргэлзэж байлаа. Сүүлийн арваад жил гэртээ суусан, мөн нас минь ч зуугийн талаас хэтрээд яваад өгчээ. Гэхдээ үзээд алдахаар шийдсэн юм.

Ингээд сургалт эхэллээ. Их цэвэрхэн сайхан газар юм. Өлгүүрийн хүүхдүүдээс эхлээд их хүндэтгэлтэй харьцаж байна. Ангидаа орлоо. Голдуу 10 жилийн хүүхдүүд, цөөн хэдэн оюутнууд, ганц нэг ажил хөдөлмөр эрхэлдэг бололтой залуус харагдана. Бүртгэлийн дугаараар нь суудал хуваарилсан байлаа. Миний насны хүн сурч байгаа нь ер үзэгдэхгүй байсан болохоор дэмий ч юм хийж байна уу гэж бодогдоно. Гэтэл тус төвийн багш нар намайг ер гайхаж байгаа юм алга. Бүх зүйл их энгийн хэрнээ ойлгомжтой байсан нь надад маш сайхан санагдлаа.



Зураг 38

“Мэддэгт мэргэн цоохор, мэддэгтүйд эрээн цоохор” гэдэг шиг яаж цээжилнэ дээ гэж бодож байсан үсэгнүүд болон ханзууд үзэх тусам их сонирхолтой санагдах болсон. Багш нар маань хичээлээ үнэнхүү сэтгэлээсээ заах бөгөөд шавь нартайгаа их сайхан найрсаг харьцах юм. Урд нь би ийм сайхан сургалтад ер сууж байсангүй. Багш нар маань ч намайг их дэмжиж байсан учраас би “Эзэн хичээвэл заяа хичээнэ” хэмээн бодож хичээлдээ ч мэрийн, сургалтын төв рүүгээ яаран очно. Мөн япон соёлтой танилцаж, төвөөс зохион явуулж байгаа бусад арга хэмжээнүүдэд дуртайяа оролцоно. Ингэх нь надад үнэхээр сайхан мэдрэмжийг төрүүлдэг.

Ингээд би япон орон очиж үзэхийг хүсдэг болсон. Япон орноор аялангаа хүмүүсийн амьдрал ахуй, эрхэлдэг ажил хөдөлмөртэй танилцаж, тэднээс их зүйл сурч мэдэхийг хүсэж байна. Монгол-Японы төв бол сурч мэдэх юм ихтэй, эрдэм оюуны их өргөө юм.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги” Суралцагч Ч.Пүрэвдулам



Зураг 39

Яаж эхлэх нь чухал биш яаж дуусах нь чухал

Намайг Алтан-Од гэдэг. Би гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 23-р сургуулийн 10-р ангид сурдаг. Анх 3-р ангиасаа хойш солонгос хэл сурч эхэлсэн боловч сайн сурч чадахгүй байсан болохоор өөрийгөө ямар ч хэл сурах авьяасгүй юм байна гэж бодож байсан. 9-р ангид байхад ээж маань япон хэлийг надад санал болгосноор “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1”-т сурахаар болов.

9-р ангид улсын шалгалт гээд хичээл ном ихтэй байсан болохоор давхар сургалтад явах тийм ч дуртай байгаагүйн дээр багш, орчин нь ямар бол, хэр их хичээлээр шахах бол, сурч чадахгүй байх вий гэх мэт янз бүрийн сөрөг

бодлууд толгойд эргэлдэж байсан.



Гэвч сургалтандаа очсон эхний өдрөөс л миний бодсон бүгд буруу байсан гэдгийг ойлгосон. Багш нарын харилцаа, цэвэр орчин, хичээлээр их шахахгүй ч гэсэн маш үр дүнтэй энэ сургалт намайг үнэхээр алмайруулж чадсан. Тэр чинээгээр сонирхол маань ч нэмэгдэж анимэ үзэж, япон дуу сонсож эхэлснээр зогсохгүй Японы их сургуульд сурах, ажиллаж амьдрах талаар хүртэл бодож эхэлсэн.

Ямар ч үед сурагчдаа ойлгож хичээж ажилладаг Монгол-Японы төвийн багш нарт маш их талархаж байна. Анх айдастайгаа хамт энэ сургалтын төв рүү алхан ороход өөдөөс мишээн угтаж, айдсыг минь багасгаж, урам зориг оруулсан үүдний угтагч нарт хамгийн их баярлаж явдаг.

Төвд ирэх болгондоо ганцхан япон хэл сураад дуусдаггүй. Төвд байдаг хүмүүс хоорондын харилцаа, байгаа байдлыг хараад надад маш олон суралцмаар санагддаг зүйл байдаг. Үүднээс угтах хүмүүсийн халуун дулаан уур амьсгал, багш нарын хүн нэг бүртэй хүндэтгэлтэй харилцаж байгаа байдал гээд л ... нүдэн дээр минь дандаа шинэ сайхан зүйлсийг заасаар байдаг. Тиймээс би энэ төвдөө их хайртай, бас ийм сайхан газрыг хэзээ ч мартажгүй байх аа.

Дараагийн түвшингийн сургалтдаа суухыг тэсэн ядан хүлээж байна. Одоогоор яг ямар мэргэжлийн хүн болмоор байгаагаа сайн мэдэхгүй байгаа ч, ирээдүйд Японы их дээд сургуульд сурахыг их хүсэж байна. Тийм болохоор төвийн сургалтандаа тууштай хамрагдаад, хамгийн сайнаараа хичээнэ гэж бодож байна.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А анги” Суралцагч Б.Алтан-Од

Бодох биш яг одооноос эхэл

Миний япон хэл сурах шалтгаан бол ажлаас улбаатай. Япон хэл мэдэхгүй анхны ажилтан нь болж компанидаа орж байлаа. Ажлаа хийхийн тулд ханз үсэг зурж сурсан, дараа нь хирагана, катакана үсэг цээжилсэн. Монголоор ойлгохгүй ч гэсэн ажлын хүрээний мэйл, зааврыг яаж ийж байгаад ойлгоод ажлаа хийсээр л байсан. Гэхдээ ажлаас гадуурх хүрээний япон хэлний мэдлэг юу ч байхгүй. Тэгээд нэг сургалтад суусан боловч өгөөж байсангүй. Өөрөө бие дааж үзлээ бас л явцгүй. Монгол-Японы төвийн сургалтыг эртнээс сонсож байсан ч суух цаг, боломж таарахгүй явсаар 2022 оны хаврын сургалтад шалгалт өгөөд, цогц сургалт-3 ангид суралцаад өөрийгөө юу ч мэддэггүй юм байна гэдгээ мэдэж авсан. Зун нь N3 түвшний шалгалт өгнө гэж байсныгаа шууд болиод ахиад суух хэрэгтэй юм байна гэж бодоод, цогц сургалт-4 ангид суралцсан. Одоо бас үргэлжлүүлээд цогц сургалт-5-д суух гэж байна. Сургалтад суух тусам их зүйл мэдэж аваад урам ороод, цааш нь сурах хүсэл улам төрөөд байдаг юм байна. Надад энд үргэлжлүүлээд суух болсон шалтгаан олон байсан. Сургалтын агуулга амьдралд ойрхон сэдвүүдтэй байгаа нь маш их таалагдсан. Сургалтын явц бас их таалагдсан. Нэг сэдвээ дүрэм, яриа гээд 2 удаа үзэхээр үнэхээр үр дүнтэй байсан. Тэгээд сэдэв дуусаад шалгалт авч байгаа болохоор ахиад бататгаад авчихна. Мөн тухайн сэдвийн хичээл орохоос өмнө гэртээ бас урьдчилж харахаар их



Зураг 40



зүгээр санагдсан. Бас нэг сурах болсон шалтгаан нь азаар ажлын ачаалал багатай үе нь таарсан. Мөн хичээл орсон бүх багш нар болон ангийнхан маань ч гэсэн их таалагдсан.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4” Суралцагч М.Өлзийсайхан

Сургалтын талаарх сэтгэгдэл

Сайн байцгаана уу? Би саяхан Монгол-Японы төвийн цогц сургалт 5-д суралцаж төгссөн. Урьд нь япон хэлийг ЕБС-д сурдаг байхдаа судалдаг байсан. Гэвч сургуулиа төгссөнөөс хойш 11 жил огт япон хэлээ ашиглаагүй тул мартсан байлаа. Хүн гэдэг чинь мэдлэгээ ашиглахгүй л бол мартаад хэрэггүй болчихдог юм билээ. Мартчихсан гээд япон хэлээ хаяхад үнэхээр хайран санагдаад байдаг байсан. Сэргээгээд илүү их сурах юмсан гэж их бодогдоно. Битүүхэн аятайхан сургалт сураглаад л тэгсэн хэрнээ ажлын хажуугаар амжихгүй гээд шалтаглаж явсаар байлаа. Харин өнгөрсөн зун Япон соёлын өдөрлөг дээр очиж элдэв зүйл сонирхож яваад Монгол-Японы төв дээр сургалт явагддагийг мэдэж авсан. Тэр дороо л суралцана гээд бүртгүүлж орхив. Яг сургалт эхлэх үед ажлаасаа ч чөлөөлөгдөөд чөлөө зав ихтэй болчихсон тул итгэл дүүрэн өөртөө хөрөнгө оруулж эхэлсэн дээ.



Зураг 41

Япон улсын өндөр хөгжил, ард иргэдийнх нь соёл, хөдөлмөрч нягт нямбай зан чанар Монгол-Японы төвөөс нэвт шувт мэдрэгддэг. Ороод гарахад таатай уур амьсгалтай, амар тайванг мэдэрдэг учир би тус төвөөр зочлох дуртай. Тийм дээ ч хичээлдээ их дуртай очдог байсан. Сургалтын хөтөлбөр хийгээд үйл явц, бүтэц маш сонирхолтой. Багш нар маань ч эелдэг, сайхан сэтгэлтэй байсан тул харилцахад ч амар байдаг. Суралцагчдыг зөвхөн лекц илтгэлээр сургах бус бие даан ажиллах хэсгүүд дээр сонсох, бичих, унших, ярих 4 чадварыг зэрэг зэрэг хөгжүүлж өгч байгаа нь хамгийн том давуу тал.

Эцэст нь тус сургалтад хамрагдсандаа бүрэн сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлмээр байна. Миний дутуу дулимаг мэдлэгийг нөхөж засаж сэргээж өгсөнд маш их баярлалаа. Та бүхний цаашдын ажил үйлсэд өндөр амжилт хүсье.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5” Суралцагч М.Энхномин



Сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Дэлгэрсүрэн гэдэг. Япон хэлний орчуулагч мэргэжилтэй. Япон хэл, япон оронтой амьдралын замаа холбоод 20 гаруй жил өнгөрсөн байна. Бага ангийн сурагч байх үеэс япон хэлийг үзэж, Японы бага, ахлах сургуульд солилцоогоор суралцаж, их сургуулиа япон хэлний судлаач, орчуулагч мэргэжлээр төгссөн.

2022 оны зун “Иродори”, намар “Марүгото”-гийн япон хэлний заах арга зүйн сургалтад хамрагдсан. Япон хэлний заах арга зүй болон сурах бичиг бидний япон хэл суралцаж байх үеэс маш ялгаатай болсныг тус 2 сургалтад хамрагдсанаар мэдэж аваад үнэхээр сонирхолтой байлаа. Иродори болон Марүгото-гийн заах арга зүй нь олон талаараа адил боловч, ялгаатай талууд мөн байсан. Заах арга зүй, сурах бичгийн агуулгын шинэлэг талыг дурдвал:



Зураг 42

- Япон хэлийг анхлан суралцагчдад маш тохиромжтой, нийгмийн харилцаанд өргөн хэрэглэгдэх үг хэллэг, харилцан яриа, сонсголын дасгалтай, бичих тексттэй.
- Хичээлийн бүлэг бүрийн агуулга нь японы өдөр тутмын амьдралд нэн дөхөм сэдэвтэй, тухайн сэдвийн хүрээний сонирхол татам зураг, тухайн орны зан заншил, түүх соёлын өргөн тайлбар мэдээлэлтэй.
- Бүлэг бүр нь сонсох, унших, ярих, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх дасгалтай.
- Суралцагч танхимаар болон бие даан цахимаар сурах боломжтой.
- Сонсгол болон харилцан яриа түлхүү байгаа нь суралцагч нийгэмд гараад өдөр тутмын ойр зуурын яриаг ашиглах, хэлж дадсан харилцан яриаг дуурайж өөрөө ярьж сурахад тун дөхөм санагдсан.

Япон сан болон Монгол-Япон төвийн чадварлаг багш нар сурах бичгийн агуулгыг сайтар тайлбарлаж, загвар хичээлийг бодитоор заасны дараа, суралцагч багш нараар хичээлийн агуулгыг бие даан бэлдүүлж, багаар загвар хичээл заалгуулж байсан нь бидний хувьд маш том туршлага болсон. Тус сурах бичиг нь хичээл бэлдэхэд зориулсан хэрэглэгдэхүүнээр элбэг байсан тул цаашид энэ сургалтын аргаар япон хэл заах багш нарт хэрэглэхэд тохиромжтой бөгөөд энэхүү сургалтад заавал суралцаарай гэж япон хэлний багш нартаа зөвлөж байна.

“Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийн заах аргын семинар” болон “Япон хэлний заах аргын сургалт” Суралцагч Д.Дэлгэрсүрэн



Багш нартаа баярлалаа!

Япон улсын засгийн газраас хэрэгжүүлдэг Монгол улсын төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрийн 2022 оны сонгон шалгаруулалтад нийт 15 төрийн албан хаагч тэнцэж, Япон улсын 7 их сургуульд холбогдох чиглэлээр магистрын хөтөлбөрт суралцаж байгаа бөгөөд миний бие Кюүшүгийн их сургуулийн Хуулийн магистрын хөтөлбөрт суралцаж байна. Сонгон шалгаруулалтын эцсийн хариу гарсны дараа бид хөтөлбөрийн дагуу 2022 оны 5 дугаар сараас эхлэн япон хэлний анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдсан нь бидний хувьд япон хэлтэй анх удаа нүүр тулан танилцсан үйл явдал юм.



Зураг 43

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс "Иродори: Хэрэглээний япон хэл" суурь шатны А1 түвшний сурах бичигт үндэслэн, нийт 100 цагийн агуулга бүхий сургалтыг амжилттай зохион байгуулж, бидэнд япон хэлний анхан шатны мэдлэгийг олгосон. Япон хэлийг анх удаа суралцаж байгаа тул үсэг, тооноос эхлээд анхан шатны дүрэм, ханз үсгүүдийг заалгах хүртэл бүх л зүйл миний хувьд шинэ содон, амаргүй хэрнээ сонирхолтой санагдсан. Үүний зэрэгцээ хичээлийн давтамж, агуулга, багш нарын хичээл заах болон бататган шалгах арга барил нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой байснаас гадна японы соёл, амьдралын хэв маягийн зарим мэдлэгийг өгснөөрөө энэхүү сургалт нь үндсэн зорилгоо бүрэн дүүрэн биелүүлсэн.

Биднийг 2022 оны 8 дугаар сард Японд ирсний дараа JDS тэтгэлэгт хөтөлбөрийн 2022 оны сонгон шалгаруулалтад тэнцсэн дэлхийн 15 улсын 260 гаруй оюутнуудыг хамруулсан чиг баримжаа олгох нэгдсэн хөтөлбөр болон япон хэлний анхан шатны сургалт Токио хотод зохион байгуулагдсан. Өөр өөр улсаас ирсэн оюутнуудыг суралцах их сургууль, бүс нутгаар нь бүлэг болгон сургалтыг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр Япон багш нарын зүгээс Монгол оюутнуудын япон хэлний анхан шатны мэдлэгийг сайшааж байсан нь бидэнд анх зааж сургасан багш нарын маань ажлын үр дүн байлаа.

Хэдийгээр бидний суралцаж байгаа магистрын хөтөлбөрийн хичээлүүд англи хэл дээр явагдаж байгаа ч сургуулиас гадуурх өдөр тутмын амьдралд япон хэлний анхан шатны мэдлэг зайлшгүй шаардлагатай болдог. Төгсгөлд нь бид бүхэнд япон хэлийг танилцуулж, анхан шатны мэдлэгийг олгосон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвд болон багш Д.Мөнхтуяа, О.Булган, Д.Золзаяа, Сато Кэийчи нартаа талархаж байгаагаа үүгээр илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь амжилт бүтээлийн дээдийг хүсье.

***“Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт” Суралцагч Н.Цогтбаяр
2023.02 Япон улс, Фүкүока хот***



Сургалтын талаарх сэтгэгдэл

Би 2022 оны 6 сараас Монгол-Японы төв болон Кёото их сургууль хоорондын гэрээт япон хэлний сургалтад суух болоод нэлээн сандарч билээ. Хэдийгээр 6 жил гаруй хугацаанд япон хэлийг суралцсан ч япон хүнтэй ярих, харилцах чадвар дутмаг байсан тул япон багшаар удирдуулан ганцаараа хичээлд сууна гэдэг амаргүй даваа шиг санагдаж байсан. Гэсэн хэдий ч Монгол-Япон төвийн багш нарын ачаар өмнө нь хэзээ ч гаргаж байгаагүй тийм ахиц дэвшилтийг гаргаж чадсан билээ. Сургалт дуусах үед үзэл бодлоо өөрийн үгээр чөлөөтэй илэрхийлэн ярьж, 300 гаруй үсэгтэй зохион бичлэгийг түүртэхгүй бичих зэрэг чадваруудыг эзэмшсэн байлаа. Мөн сургалтын үеэр япон хэлний мэдлэгээс гадна, япон хүмүүс болон тэдний соёлын тухай олон олон зүйлс заалгаж авсан нь аз завшаантай.



Зураг 44

Сургалт ганц суралцагчтай буюу зөвхөн надад зориулагдсан байсан болохоор, мэдэхгүй чадахгүй зүйлсээ чөлөөтэй асууж, өөрийгөө хөгжүүлэх маш том боломж байсан юм. Тэрхүү боломжийг ашиглан зуны хугацаанд нийт 75 цагийн турш хичээллэсний эцэст хүссэн түвшиндээ хүрч, Японд ирсэн хойноо ч санаа зоволгүйгээр японоор харилцаж байна. Мөн энэхүү сургалтынхаа ачаар Кёото их сургуулийнхаа япон хэлний бэлтгэл сургалтын хүссэн түвшний ангидаа амжилттай дэвшин суралцаж байгаагаа хэлэхэд таатай байна.

Сургалтын туршид зааж чиглүүлж, тусалж дэмжиж байсан Монгол-Японы төвийн бүх багш нартаа БАЯРЛАЛАА.

“Кёотогийн их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөрт элсэн орогчдод зориулсан япон хэлний бэлтгэл сургалт-2022” Суралцагч Т.Гэрэл

III. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ





1. 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн номын сан, хамтын ажиллагааны тасаг нь хоёр орны хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд нээлттэй семинар, япон киноны өдөр, Японд суралцахыг хүссэн оюутан сурагчдад зориулсан “Мэдээллийн яармаг, семинар”, Японд тэмдэглэдэг уламжлалт баяр наадмаар дамжуулан япон соёлыг мэдэж авах “Япон хэл, соёлын танилцуулга хичээл” зэрэг ажлуудыг зохион байгуулахын зэрэгцээ нийтийн номын сангийн үйл ажиллагаа явуулдаг.

Энэ онд МУИС байгуулагдсаны 80 жил, Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил, төв үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой зэрэг олон тэгш ой тохиосон жил боллоо. Энэхүү ойд зориулан зохиосон олон ажлын дундаас дурдвал Япон сангийн дэмжлэгээр япон хэлний сургалтгүй баруун бүсийн 3 аймагт, Баян-Өлгий аймгийн соёл урлагийн газар, Увс аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Ховд аймгийн Ховд их сургууль, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газруудтай тус тус хамтран орон нутгийн иргэд, хүүхэд залууст төвийнхөө үйл ажиллагааны талаар танилцуулан мөн япон соёлын танилцуулга сургалт явууллаа. Үүнээс гадна ойн хүрээнд Япон улсаас мэргэжлийн цайны ёслолын багш, МУИС-ийн багшийн хамтарсан хүндэтгэлийн цайны ёслолыг нээлттэй семинарын хэлбэрээр зохион байгуулав. Түүнчлэн төвийн 20 жилийн замналыг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн, “Миний мэдэх Япон төв” зохион бичлэгийн уралдааныг тус тус хариуцан гүйцэтгэлээ.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал намжиж сүүлийн 2 жил цахимаар явагдаж байсан сургалт, үйл ажиллагаа бүгд танхимаар явагдлаа. Харин Японы Жайка Чикюү Хиробагаас зохион байгуулсан “Өнөөгийн Монгол руу аялцгаая! Нүүдэлчдийн амьдрал болон хотын амьдрал” семинар болон цахим хуудас идэвхжүүлэх уралдаант аяныг цахимаар зохион байгууллаа. Дээр дурдсан үйл ажиллагаануудын талаар та онцлох мэдээ хэсгээс дэлгэрүүлэн уншина уу.

Энэ жил компьютерийн цогц болон бичээчийн сургалт танхимаар, цахимаар нийт 27 удаа хичээллэлээ.

1) Номын сангийн үйл ажиллагаа

Номын сангийн бүртгэлтэй уншигчдын тоо 2022 оны 12-р сарын байдлаар 28,278 болсон ба жилийн хугацаанд номын сан бүтэн нээлттэй байж 7072 хүнд үйлчилсэн нь корона вирустэй байсан жилүүдтэй харьцуулбал 3 дахин ихэссэн дүн бөгөөд үйлчилгээ эргэн сэргэж байгаа нь мэдрэгдэж байлаа.

Номын сангийн фондод япон хэл суралцагчдад зориулсан ном, толь бичиг, Японд суралцах шалгалт, япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх ном, товхимол, япон, монгол зохиолчдын бүтээл, дэлхийн сонгодог зохиол, комик зэрэг 11,300 гаруй ном материал байна. Түүнээс гадна Японы 100 гаруй их, дээд сургуулийн танилцуулга, холбогдох материалууд номын санд бий. Энэ жил номын сангийн фондоо 400 гаруй номоор баяжуулжээ. “Read Japan Project” төсөлд хамрагдан Японы улс төр, түүх нийгэм, урлагийн талаарх англи хэлээр гарсан 50 ном хүлээн авлаа.



Түүнээс гадна монгол, япон хэлээрх ном хандивласан монгол, япон хувь хүн, албан байгууллага, хэвлэлийн газарт гүнээ талархаж байна.

Номын сангийн мэдээллийн буланд Японы ЭСЯ-аас хариуцан явуулдаг тэтгэлэгт шалгалт, Япон хэлний багш нарын холбоо, ЖАССО /Японы оюутныг дэмжих байгууллага/-оос явуулдаг хувийн зардлаар Японд суралцах шалгалт, мөн Япон сангийн япон хэлний түвшин тогтоох шалгалттай холбоотой мэдээллийг түгээдэг.

2) Япон киноны өдөр

Соёлын уламжлалт үйл ажиллагааны нэг болох япон киноны өдрийг энэ онд Японы элчин сайдын яам болон Filmbank media компанитай хамтран 6 болон 11-р саруудад зохион байгууллаа. Эхний үзвэрээр Кон Сатоши найруулагчийн анимэ төрлийн “Паприка” киног монгол хадмал орчуулгатайгаар үзэгчдэд хүргэлээ. Уг киног Монгол-Японы төв нь Filmbank media компаниас 1 удаа 100 хүнд үзүүлэх албан ёсны эрхтэйгээр гаргасан юм. Мөн киноны дараа үзэгчидтэй киноны тухай санал бодлоо хуваалцав. Хэлэлцүүлгийн үеэр киноны гол санаа болон сонирхол татсан хэсгүүдийн талаар олон асуулт гарч ирэв. Ийнхүү олон шинэ санаа гарч, киноны үйл явдлыг өөр өөр өнцгөөс харж ойлгон харилцан ярилцсан сайхан хэлэлцүүлэг болж өнгөрөв.

Түүнчлэн Японы элчин сайдын яамтай хамтран 11 сард өмнөх онд гаргасан кинонуудын дундаас үзэгчдээс хамгийн өндөр үнэлгээ авсан “Аавын БЭНТО” буюу “Хамгийн амттай хоол” киног дахин гаргалаа.

3) Нээлттэй семинар

Төв нээгдсэн цагаасаа хойш нээлттэй семинарыг тогтмол зохион байгуулж ирсэн билээ. 2022 онд тохиосон олон тэгш ойг угтан зохион байгуулсан ажлын нэг болж япон талаас Японы Хохокафү компанийн, үрасэнкэй цайны урсгалын багш Мияваки Шихо болон бусад ажилтнууд монгол талаас МУИС-ийн япон судлаач, япон хэлний багш С.Баттулга нар хамтран “Нөхөрлөл” хүндэтгэлийн цайны ёслолыг хийж гүйцэтгэлээ. Дэлгэрэнгүйг “Онцлох мэдээ”-ээс хүлээн авна уу.

4) Японд суралцах мэдээллийн яармаг – 2022

Хоёр жил цахимаар зохион байгуулагдсаны дараа энэ жилийн 10-р сард 13 дахь удаагийн “Японд суралцах мэдээллийн яармаг”-аа, Японоос ирсэн 13 их сургуулиудын төлөөлөлтэй хамтран төвдөө зохион байгууллаа. Нийт 2 өдөр зохиогдсон мэдээллийн яармагт Японоос хүрэлцэн ирсэн 13 их сургуулийн төлөөлөгчид өөрсдийн сургуулийн талаар танилцуулж, ганцаарчилсан зөвлөгөө өглөө.

Оролцогч их сургуулиудын явуулсан танилцуулга материалуудыг хүлээн авах танхимд булан байгуулан танилцуулгыг байршуулж, мөн номын сан дахь тараах материалын булангаар дамжуулан тараахын зэрэгцээ үйлчлүүлэгчийг тухайн сургуультай холбож өгөх үйлчилгээг үзүүлж байна. 14 дэх удаагийн Японд суралцах мэдээллийн яармагийг 2023 оны 10-р сард зохиохоор төлөвлөж байна. Дэлгэрэнгүйг онцлох мэдээнээс хүлээн авна уу.



5) Гэрээгээр гүйцэтгэх ажил

Корона вируст цар тахлын улмаас 2 жил завсарлаад байсан Хакүходо боловсролын сангийн япон хэл сурч буй хүүхдийн боловсролыг дэмжих “Япон хэл, солилцооны хөтөлбөр” маань энэ жилээс дахин зохион байгуулагдаж эхэллээ. Энэ удаагийн 13 дахь хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад Дархан-Уул аймгийн 19-р сургуулийн япон хэлний багш Л.Энхтуяа тэнцэн энэ оны 11 сард Японд багшийн чадамж дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдаад ирлээ. Хөтөлбөрийн дараагийн шат болох шавь нарын хамт 2023 оны 5-р сард Япон улс руу сурагчдад зориулсан танилцах хөтөлбөрт явахаар бэлтгэл ажилдаа ороод явж байна.

Хүснэгт 17: Нээлттэй семинар

№	Сэдэв	Илтгэгч	Он сар өдөр	Хаана	Оролцогчдын тоо
1	№82 Нээлттэй семинар "Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд "Нөхөрлөл" хүндэтгэлийн цайны ёслол"	Японы цайны ёслолын Үрасэнкэ нийгэмлэгийн багш Мияваки Шихо, МУИС-ийн багш, япон судлаач С.Баттулга	2022.12.14	Их танхим	50
2			2022.12.15		33
	Нийт				83

Хүснэгт 18: Япон киноны өдөр

№	Киноны нэр (Хадмал орчуулгатай)	Он сар өдөр	Хаана	Хүний тоо
1	"Паприка" анимэ	2022.06.17	Их танхим	37
2	"Аавын хоол хамгийн амттай нь" уран сайхны кино	2022.11.25		38
Нийт				75

Хүснэгт 19: Гэрээгээр гүйцэтгэх ажил




№	Үйл ажиллагааны нэр	Он сар өдөр	Оролцогчид	Хаана	Хүний тоо
1	Хакүходо боловсролын сангийн "Япон хэл, солилцооны хөтөлбөр" гэрээт ажил	2022.11-р сар	ЕБС-ийн япон хэлний багш	Япон, Токио	1
2	Кюүшюү их сургуулийн гэрээт ажил	2022. 6, 7, 8-р сар	Тухайн их сургуулийн оюутнууд	Цахим	51
3	Анагаах ухаан, нийгмийн халамжийн олон улсын их сургуулийн гэрээт ажил	2022. 9, 10, 11	Тухайн их сургуулийн багш, мэргэжилтнүүд, элсэгчид	АШУҮИС, Монгол-Японы төв	15
Нийт					67

Хүснэгт 20: Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо

	2022												
Сараар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
Үйлчлүүлэгчдийн тоо	351	495	687	737	700	498	136	519	909	806	703	531	7072

График 9: Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо 2022.01-12



Хүснэгт 21: Компьютерийн сургалт



№	Сургалтын нэр	Хугацаа	Давтамж	Агуулга	Багшийн нэр	Оролцогчдын тоо
1	Арван хурууны бичээчийн сургалт /танхим, цахим	2022.01-2022.12	13 удаа	Компьютерийн гарын үндсэн байрлалыг эзэмшиж, МонТТ программ ашиглан арван хуруугаар зөв, хурдан бичиж сурна.	Т.Болормаа	85
2	Компьютерийн цогц сургалт		14 удаа	Тус сургалтаар анхан шат, интернетийн хэрэглээнээс эхлээд MS-Word, MS-Excel, MS-Powerpoint программыг цогц хэлбэрээр заана. MS-Word, MS-Excel программын үндсэн функц, зураг, хүснэгт, график, диаграмм, санхүүгийн тооцоо, цалингийн тооцоо хөтлөх, түгээмэл хэрэглэгддэг томъёоны функц гэх мэт аргачлалуудыг сурна. PowerPoint ашиглан сонирхолтой боловсронгуй байдлаар илтгэл бэлтгэх аргачлалыг сурна.	Э. Сүх-Эрдэнэ А.Мөнхмагнай	126
Нийт						211

Хүснэгт 22: 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Удаа
1	Увс, Ховд, Баян-Өлгий аймаг дахь япон соёлын танилцуулга сургалт	2022.02	3
2	“Миний мэдэх Япон төв” зохион бичлэгийн уралдаан	2022.06	1
3	Цахим хуудас идэвхжүүлэх уралдаант аян	2022.01~12	9
4	Зохиолч, уншигчдын уулзалт / Номын хэлэлцүүлэг	2022.06	1
5	20 жилийн ойн гэрэл зургийн үзэсгэлэн	2022.06	1
6	ЖАЙКА Чикюү Хироба- "Өнөөгийн Монгол руу аялцгаа ! Нүүдэлчдийн амьдрал болон хотын амьдрал" цахим семинар	2022.08	1
Нийт			16

2. Онцлох мэдээ



1) “Японд суралцах талаар цахим мэдээллийн яармаг – 2022”



Зураг 45. Мэдээллийн яармагийн постер

Сүүлийн жилүүдэд цар тахлын нөлөөгөөр цахим хэлбэрээр явагдаж байсан “Японд суралцах тухай мэдээллийн яармаг” 2 жилийн дараа 2022 оны 10-р сарын 8 (Бя), 9 (Ня)-ний өдрүүдэд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвд дахин танхимаар зохион байгуулагдлаа. 13 дахь удаагаа зохион байгуулагдаж буй тус арга хэмжээнд Японы 13 их сургууль танхимаар, 1 сургууль материалаар оролцлоо. Энэхүү арга хэмжээнд Японд суралцах хүсэлтэй оюутан залуус маш ихээр оролцсон бөгөөд 2 хоногийн нийлсэн дүнгээр 2200 гаруй хүн ирсэн нь урьд өмнөх мэдээллийн яармагт ирсэн хүмүүсийн тоог илт давсан үзүүлэлт болсон юм.

Мэдээллийн яармагийн өмнөх өдөр буюу 10-р сарын 7 (Ба)-ны өдөр, Японы их сургуулиудын төлөөлөгчид япон болон англи хэлийг

гүнзгийрүүлэн суралцдаг бүрэн дунд боловсролын сургуулиудтай танилцах хөтөлбөрт хамрагдсан юм. Энэхүү хөтөлбөр нь мэдээллийн яармагт оролцож буй япон сургуулийн танилцуулах семинар болон элсэлтийн талаарх мэдээллийг тухайн сургуулийн сурагчидтай хуваалцаж, Японд суралцах талаар санал солилцдог билээ.

Мэдээллийн яармагийн эхний өдөр буюу 10-р сарын 8-ны бямба гарагт арга хэмжээг нээж Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Кобаяши Хироюки үг хэлэн, МУИС-ийн санхүү төлөвлөлт хариуцсан дэд захирал Ц.Болормаа, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц.Даваадорж нар мэндчилгээ дэвшүүлэв.



Зураг 46. Нээлтийн үйл ажиллагаа

“Японд суралцах тухай мэдээллийн яармаг”-ийн хөтөлбөр нь Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн танилцуулга, Японд суралцах талаар ерөнхий танилцуулга, Япон улсад тэтгэлгээр суралцаж ирсэн оюутны яриа, мэдээллийн яармагт оролцож буй сургуулиудын танилцуулга болон сургууль тус бүрийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх булан зэргээс бүрддэг. Оюутан залуус маань өөрсдийн суралцах чиглэлээр элсэлт авч буй сургуулийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх буланд очиж тэтгэлэгт хөтөлбөрөөс гадна өөрт хэрэгтэй мэдээллүүдээ олж авч байлаа.



Мэдээллийн яармагийн сүүлийн өдөр буюу 10-р сарын 9 (Ня)-ний өдөр, Японд сургууль төгсөгчдийн “Жугамо” нийгэмлэгээс “Японд сурч мэдсэн туршлага” сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг хийлээ. Тус нээлттэй хэлэлцүүлэг нь “Жугамо” нийгэмлэгээс зохион байгуулдаг “TALKio-Let’s about ideas & opportunities”-ын 3 дахь цуврал бөгөөд улсын болон хувийн зардлаар, япон англи хэлээр, 1000 инженерийн хөтөлбөрөөр Японд суралцсан залуус өөрсдийн туршлагаа хуваалцаж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан.



Зураг 47. “Японд сурч мэдсэн туршлага”-ын илтгэгчид

Япон улсад суралцах монгол оюутны тоо жилээс жилд өсөж байна. Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголынхоо оюутан залуусыг Японы их дээд сургуульд амжилттай суралцаж төгсөөд, ирээдүйд Монгол орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах боловсон хүчин болохыг дэмжиж жил бүр энэхүү мэдээллийн яармагийг зохион байгуулахын сацуу Японд суралцах талаар зөвлөгөө зөвлөмжийг байнга өгдөг билээ.

Ирэх жил ч гэсэн Япон улсаас олон олон их сургууль, байгууллагын төлөөлөгчид “Японд суралцах мэдээллийн яармаг”-т оролцож, Японд суралцахыг хүсэж буй оюутан залууст хэрэгцээтэй мэдээлэл өгнө гэдэгт итгэж байна.

Хүснэгт 23. “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2022”-т оролцогч их сургуулиуд



 IWATE UNIVERSITY <i>Иватэ их сургууль</i>	 KUAS KYOTO UNIVERSITY of ADVANCED SCIENCE <i>Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль</i>	 <i>Күмамото мужийн асаргааны консерциум</i>	 大阪大学 OSAKA UNIVERSITY <i>Осака их сургууль</i>	 IUJ INTERNATIONAL UNIVERSITY OF JAPAN Where the World Cooperates Since 1982 <i>Олон улсын их сургууль</i>
 NUCB Undergraduate School <i>Нагоя худалдаа, бизнесийн их сургууль</i>	 Shape your world APU Ritsumeikan Asia Pacific University <i>Рицүмэйкан Ази Номхон далайн их сургууль</i>	 Saitama University 埼玉大学 <i>Сайтама их сургууль</i>	 TOOKYO INTERNATIONAL UNIVERSITY <i>Токио олон улсын их сургууль</i>	 <i>Токүшима их сургууль</i>
 TOKAI UNIVERSITY <i>Тоокай их сургууль</i>	 UNIVERSITY OF HYOGO <i>Хёого мужийн их сургууль</i>	 Yamagata University <i>Ямагата их сургууль</i>	 INTERNATIONAL UNIVERSITY OF HEALTH AND WELFARE <i>Анагаах ухаан, нийгмийн халамжийн олон улсын их сургууль</i>	

2) 82-р нээлттэй семинар: “Нөхөрлөл” хүндэтгэлийн цайны ёслол

Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулан Японы Хохокафү компаний дэмжлэгтэй үрасэнкэ урсгалын багш Мияваки Шихо, түүний шавь Кобаши Рүри, Като Күмико нар, МУИС-ийн багш, япон судлаач С.Баттулга нар хамтран “Нөхөрлөл” хүндэтгэлийн цайны ёслол үйл ажиллагааг зохион байгууллаа.

Уг цайны ёслол 12-р сарын 14, 15-ны хоёр өдөр үргэлжилж 100 орчим хүн оролцлоо. Арга хэмжээг нээж Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд



Зураг 48. Оролцогчдод цай барьж буй нь



Зураг 49. Тусгай зочдод цай барьж буй Мияваки Шихо багш

Кобаяши Хироюки үг хэллээ. Цайны ёслолын хүндэт зочноор элчин сайд гэргийн хамт, мөн Монгол улсаас Япон улсад онц



бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байсан Б. Жигжид, төвийн захирал Ц.Даваадорж нар оролцлоо. Эхний өдрийн цайны ёслол 2 хэсгээс бүрдэж байв. Эхний хэсэгт Мияваки багш, Баттулга багш нар ээлжлэн цай бэлтгэн хүндэт зочдод барьж, дараах хэсэгт 2 багш цайны ёслолын талаар тайлбарлан, багшийн шавь нар бэлтгэсэн цайгаа тусгайлан бэлдсэн япон амттаны хамт ирсэн хүмүүст түгээлээ. Цайны ёслолд харилцагчаа хүндэтгэж байгаа хүндэтгэл, нарийн дэг жаяг, танхимын дотоод уур амьсгал, чимээгүй, нам гүм байдал зэрэг нь гүн сэтгэгдэл төрүүлээ гэж цайны ёслолд оролцогчдын сэтгэгдэлд олонтаа дурдагдсан байв. 2 дахь өдрийн үйл ажиллагаанд Монголын радиогийн сэтгүүлч оролцож, оролцогчдын сэтгэгдлийг авч, мөн цайны ёслолын багш нараас яриа аван Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан цуврал нэвтрүүлэгтээ оруулахаар болов.

3) Зохиолч уншигчдын уулзалт: Дазай Осамү “Хүн байх эрхгүй” номын хэлэлцүүлэг

Сүүлийн жилүүдэд японы уран зохиолын олон бүтээлүүд монгол хэл рүү орчуулагдан гарч монголын уншигчид ч мөн маш ихээр сонирхон унших болсон билээ. Номын дэлгүүрүүдийн шилдэг борлуулалттай номын жагсаалтад япон бүтээлүүд цөөнгүй харагдах болсон. Манай төвийн номын сангийн хувьд уншигч, үйлчлүүлэгчдэдээ зориулан японы уран зохиолын бүтээлүүдээр зохиолч уншигчдын уулзалт зохиох, тухайн бүтээлийг монгол хэл рүү хөрвүүлсэн орчуулагчтай ярилцлага хийх зэрэг олон үйл ажиллагаануудыг зохион байгуулсаар ирсэн билээ.



Зураг 50. “Хүн байх эрхгүй” ном

Энэ удаагийн зохиолч уншигчдын уулзалтаа бид арай өөр хэлбэрээр зохион байгуулахаар зорьсон. Урьд жилүүдэд зохион байгуулж байсан зохиолч уншигчдын уулзалт маань тухайн бүтээлийг орчуулсан орчуулагч, монгол уншигчид, төвийн номын санч оролцож өөр өөрийн уншсан сэтгэгдлээ илэрхийлдэг байсан бол бид энэ удаа япон уншигчид тухайн номыг уншаад ямар сэтгэгдэл төрсөн бол япончуудад хэр хүрсэн бол гэх сониуч сэдлээр япон уншигчдыг анх удаа урьж оролцуулсан.

Үйл ажиллагаа зохион байгуулагдахаас 1 сар гаруйн өмнөөс номын сангийн фэйсбүүк хуудсаар японы 4 зохиолчийн 4 бүтээлээр (Оэ Кэнзабүро “Хувийн асуудал”, Мүраками Харүки “Эрэг дээрх Кафка”, Дазай Осамү “Хүн байх эрхгүй”, Кавабата Ясүнари “Мянган тогоруу”) уншигчдаас санал асуулга авч, эцсийн байдлаар Дазай Осамүгийн “Хүн байх эрхгүй” ном шалгарч, энэхүү бүтээлээр бид 2022 оны 3-р сарын 19-ний өдөр ээлжит “Зохиолч уншигчдын уулзалт”-аа зохион байгуулсан. Мөн уншигчид хоорондоо тухайн номоор хэлэлцүүлэг өрнүүлэхээс гадна номыг олон өнцгөөс харж ярилцах боломжийг уншигчдаа олгох үүднээс номын орчуулагч Д.Алтанцэцэгийг урьж оролцуулсан.



Тухайн өдөр бид “Хүн байх эрхгүй” номын орчуулагч Д.Алтанцэцэгийн мэндчилгээгээр үйл ажиллагаагаа нээж, номоо орчуулахад нь гарч байсан бэрхшээл, өөрт нь төрсөн сэтгэгдлийг сонссон. Дараа нь Дазай Осамүгийн намтар, уран бүтээл болон тухайн үеийн нийгэм “Хүн байх эрхгүй” номд хэрхэн тусгалаа олж буй талаар уран зохиол, нийгэм, философийн онолтой холбон өөрсдийн зүгээс задалж ярин, дэлгэрүүлж унших номын жагсаалтыг оролцогчдодоо танилцуулсан.

Эцэст нь монгол, япон уншигч, номын орчуулагч гэсэн 3 өөр байр суурины хүмүүсээ тойрог хэлбэрээр суулган чөлөөт хэлэлцүүлэг хийсэн бөгөөд оролцогчдоос маш сонирхолтой сэтгэгдлүүд ар араасаа хөврөн гарч байлаа. Үйл ажиллагаа дууссаны дараа оролцогчид сэтгэгдэл маш өндөр, дахин ийм хэлбэрээр зохион байгуулахыг хүссэн хүсэлтүүд их ирсэн нь номын санч бидэнд дахин зохион байгуулах урам зоригийг өгсөн.



Зураг 51. Чөлөөт хэлэлцүүлэг

4) Баруун бүсийн Увс, Ховд, Баян-Өлгий аймаг дахь япон соёлын танилцуулга

Төв үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг угтан зохион байгуулсан олон ажлын нэг бол хөдөө орон нутаг дахь япон соёлын танилцуулга билээ. 2 жилийн өмнөөс япон хэлний сургалтгүй аймгуудад бүсчлэн очиж танилцуулга хийхээр хуваарилан төлөвлөж байсан ч Корона вируст цар тахлын улмаас бусад аймгийн томилолт цуцлагдсан юм. Харин энэ оны эхээр хотоос хамгийн хол орших, Монголын олон ястны өлгий гэгддэг Увс, Ховд, Баян-Өлгий аймагт очоод ирсэн билээ. Япон хэлний сургалттай аймгуудад томилолтоор явах үед сургуулиудтай хамтран зохион байгуулдаг байсан бол энэ удаа Баян-Өлгий аймгийн соёл урлагийн газар, Увс аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт, Ховд аймаг дахь МУИС-ийн Ховд салбар сургууль, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газруудтай тус тус хамтран орон нутгийн иргэд, хүүхэд залууст төвийнхөө үйл ажиллагааны талаар танилцуулан мөн япон соёлын танилцуулга сургалтыг 2-р сарын 18-аас 2-р сарын 24-ний өдрүүдэд зохион явууллаа.



Зураг 52. Фүрошики /Баян-Өлгий аймаг, Өлгий сум/

Увс аймагт “Эрдмийн эхлэл” хувийн дунд сургууль, ЕБС-ийн 1, 2, 6, 7-р сургуулийн сурагчид болон багш нар, иргэд, Ховд аймагт МУИС-ийн Ховд салбарын оюутнууд, ЕБС-ийн сурагчид, иргэд, Баян-Өлгий аймагт “Дарин” хувийн дунд сургууль, мөн 2, 4-р ЕБС-ийн сурагчид, багш нар, иргэд гээд нийт 216 хүн оролцлоо.



Зураг 53. Гар урлал / Ховд аймаг, Ховд сум/

ажлуудаа түлхүү танилцуулахыг хичээлээ. Хүүхдүүд машинд сонирхон, тун идэвхтэй оролцож байв. Ялангуяа “Япон орныг хэн сайн мэдэх вэ” тэмцээний үеэр хэдий япон хэл үздэггүй ч Япон орны талаар ойлголт сайтай нь мэдэгдэж байлаа. Хүүхэд залуус Япон анимэ, мангад дуртай нь хаа ч ялгаагүй адил болох нь эндээс харагдаж байв. Японы уран зохиолыг хүүхэд залууст таниулах зорилгоор аймгуудын номын санд болон хүүхэд хөгжлийн төвд О.Жаргалсайханы орчуулга “Гэнжийн туульс” “Хайрын ааш” хэмээх японы уран зохиолын номуудыг хандивлалаа.

Бид аль болох цөөн хоногт томилолтоо амжуулахын тулд хотоос Улаангом хот хүртэл нисэж, тэндээсээ Ховд, Өлгий хотууд руу машинаар хүрч очсон юм. Зам зуур сүрлэг мөнгөн дуулгатай цаст өндөр хайрханууд, цасан цагаан тал, сэнгэнэсэн цэвэр агаар, мал сүрэг гээд Монголынхоо сайхан байгалийг нүд алдан харж явлаа. Далайн түвшнээс дээш 2,500 метрт явж байгааг машины заалтаас хараад аргагүй л Монголынхоо хамгийн өндөр газарт явж байгаагаа мэдэрч явав. Арга хэмжээнд оролцсон хүмүүсийн сэтгэгдэл тун өндөр байсан бөгөөд “хотод очвол танай төвд заавал очно оо”, “энэ гоё япон хувцсаа бидэнд зарахгүй юм уу”, “дараа дахин манай аймагт заавал ирээрэй” “Япон явж сурмаар санагдлаа” гэсэн халуун дулаан сэтгэгдлүүд бичсэн байсан юм.

Япон сангийн дэмжлэгээр явагдсан энэ удаагийн томилолт маань ийнхүү тун амжилттай өндөрлөлөө. Цаашид боломж олдвол бусад аймгуудад ч эл сургалт, үйл ажиллагаагаа зохион явуулах хүсэлтэй байгаа бид энэ удаагийн томилолтоороо чамгүй туршлага хуримтлуулж авлаа.

Аймаг бүрт үдээс өмнө, үдээс хойш 2 удаа танилцуулгаа хийж байв. Үйл ажиллагааны эхэнд төвийн үүсэл хөгжил, одоо явуулж буй сургалт үйл ажиллагааг танилцуулан, хуваарийн дагуу японы баадангийн соёл болон сүлжээсэн гар урлал, юката өмсөх цаг, Японд суралцах талаар мэдээлэл, “Япон орныг хэн сайн мэдэх вэ” уралдаант тэмцээн, Япон киноны цаг зэргээр номын сангийн тасгийн голчлон явуулдаг соёлын



Зураг 54. Юката өмсөж үзсэн нь / Увс аймаг, Улаангом сум/



5) ЖАЙКА Чикюү Хироба

2022 он бол Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50-н жилийн ой болон бусад тэгш ой давхцсан түүхэн жил болсон билээ. Энэ ойн хүрээнд Монгол Японыг хамарсан олон сайхан үйл ажиллагаа болсон.

Жайка Чикюү Хиробагаас 2022 оны 8-р сарыг Монголыг сурталчлах сар болгон зарласан. /Жайка Чикюү Хироба гэдэг нь Японд “Иргэдийн оролцоотой олон улсын хамтын ажиллагааны үндэс” болж иргэд олон нийт хүрэлцэн ирж, хөгжиж буй орнуудын хүмүүст туслах, эв нэгдлийг эрхэмлэх, олон улсын хамтын ажиллагаанд оролцож буй хүмүүс болон бүлгүүдийн мэдээллийг түгээх, солилцох, сургалтын бааз болгох зорилгоор байгуулсан газар юм.




Зураг 55. Дээлний танилцуулга бичлэг

Энэ удаа бид Жайка Чикюү Хиробагаас зохион байгуулсан “Өнөөгийн Монгол руу аялцгаая! Нүүдэлчдийн амьдрал болон хотын амьдрал” цахим семинарт оролцож үндэсний хувцас болох “Дээл”-ийн талаар танилцуулга видео бэлтгэж танилцуулсан. Семинар өнөөгийн Монголын талаарх танилцуулгаар эхэлж нүүдэлчдийн амьдрал, хотын

амьдрал, үндэсний хувцас гэх сэдвүүдээр үргэлжилсэн. Улаанбаатар хотын өнөөгийн байдал болон амьдралыг МУИС-н япон оюутан танилцуулсан нь ихээхэн сонирхолтой болсон. Олон жилийн өмнө Монголд ирж байсан хүмүүс хотоор алхан танилцуулах бичлэгийг үзээд өнөөгийн Улаанбаатарыг ихээхэн сонирхож төрөл бүрийн асуулт асууж байсан.

Бидний хувьд дээлийн талаар япон хүмүүст ойлгомжтой бөгөөд өргөн цар хүрээтэй мэдээлэл хүргэхийг зорьсон билээ. Дээлийг гарал үүсэл, онцлог чанар, материал, хэрэглээ, эртний болон орчин үеийн гэх зэргээр ангилан танилцуулгаа бэлтгэсэн. 2022 оны 8-р сарын 24-нд болсон уг цахим семинарт нийт 116 хүн оролцсон ба семинарын дараа хүмүүсийн сонирхсон асуултанд хариулж дурсгалын зураг татуулснаар семинар маань өндөрлөсөн юм. Бид энэхүү үйл ажиллагаанд оролцсоноор зорилтот бүлэг болох монголыг сонирхдог хүмүүст монголын талаар өнөөгийн бодит мэдээлэл хүргэхийн сацуу япон хүмүүст монгол орны талаар үнэн зөв мэдээлэл хүргэж чадсан гэж үзэж байна.

Мөн оролцсон хүмүүс бидэнд эерэг сэтгэгдэл хэлж, сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлсэн нь бидний цаашдын ажилд ихээхэн урам зориг өгсөн юм.



Зураг 56. Дурсгалын зураг

6) Read Japan Project-2021

2022 оны 3-р сарын 3-ны өдөр Япон улсын элчин сайдын яам төвд санал болгосноор “Read Japan Project-2021” төсөлд хамрагдах боломжтой болсон билээ. Энэхүү төслийг анх Ниппон сан 2008 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд гадаад орны их сургууль, нийтийн номын сангуудад англи хэлээрх японы улс төр, олон улсын харилцаа, эдийн засаг, бизнес, нийгэм, соёл урлаг, уран зохиол, түүх зэрэг 200 ном дундаас хандивлаж Япон улсын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх зорилготой. Одоогийн байдлаар 138 орны 1100 гаруй их сургууль, нийтийн номын санд хандивлаад байна.

Манай номын сан уг төслийн хүрээнд Японтой холбоотой түүх, уран зохиол, нийгэм, соёл урлагийн тухай англи хэлээрх 50 гаруй ном хүлээн авлаа. Японы элчин сайдын яамнаас ном хүлээлгэн өгөх арга хэмжээ 12-р сарын 14-ний өдөр болж өндөрлөлөө. Энэхүү арга хэмжээнд Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Кобаяши Хироюки хүрэлцэн ирж Монгол-Японы хүний нөөцийн төвийн захирал Ц.Даваадорж-д гардууллаа.



Зураг 57. Англи хэлээрх Японы тухай 50 ном



Зураг 58. Ном гардуулах ёслол

IV. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ТАСАГ





1.2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Ерөнхий удирдлагын тасаг нь төвийн санхүү хөрөнгийн удирдлага, хүний нөөц, мэдээлэл технологи, аж ахуй, албан бичиг хөтлөлт, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын зохицуулалт гэсэн үндсэн ажлуудаа 2022 онд 98%-ийн гүйцэтгэлтэйгээр амжилттай зохион байгуулж ажиллалаа.

2022 онд цар тахлын эсрэг авах арга хэмжээг буруулсантай холбоотойгоор төвийн сургалтууд урьдын адил хэвийн зохион байгуулагдаж, хөл хөдөлгөөн ихтэй жил боллоо.

Мөн бид дотоод нөөц бололцоогоороо төвийн барилга байгууламжийн засвар үйлчилгээг цаг тухайл нь хийж, цар тахлын хууль цуцлагдах хүртэл ЗГ болон УОК-оос заасан журмын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь тогтмол хийж төвийн ажилтнууд болон төвөөр үйлчлүүлэгчдийн аюулгүй, тайван орчинд ажиллаж үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж чадсан. Энэхүү ажлын бүтээмж өндөр гүйцэтгэлтэй гарсан нь төвийн хамт олны хичээл зүтгэл, хамтын ажиллагааны үр дүнтэй салшгүй холбоотой.

Танхим ашиглуулсан байдал

Хүснэгт 24: Байгууллагаар

№	Зохион байгуулагч	Үйл ажиллагааны тоо (удаа)
1	Япон Улсын Элчин Сайдын Яам	8
2	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага ЖАЙКА	15
3	Монгол Улсын Их Сургууль	6
4	Монголын Япон хэлний багш нарын холбоо	8
5	Бусад байгууллага	80
Нийт		117

Эх сурвалж: Монгол-Японы Төв, Ерөнхий удирдлагын тасаг



Хүснэгт 25: Үйл ажиллагааны төрлөөр


№	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны тоо (удаа)
1	Сургалт, семинар	74
2	Шалгалт	15
3	Уралдаан тэмцээн	12
4	Эрдэм шинжилгээний хурал	4
5	Бусад	11
Нийт		117

Эх сурвалж: Монгол-Японы Төв, Ерөнхий удирдлагын тасаг

тасаг

Дээрх ажлуудыг ЖАЙКА, Япон сан болон МУИС-ийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн удирдлага заавар, бүх талын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн. Үйл ажиллагааны тоо өмнөх онтой харьцуулахад харьцангуй өссөн нь дээр дурьдсанчлан цар тахлын эсрэг авах арга хэмжээг бууруулсантай холбоотой билээ. Гэвч бид төвийн хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, сургалтад оролцогч бүрийн халууныг үзэж, агааржуулалт, ариутгал, цэвэрлэгээг тогтмол хийж ажиллалаа.

График 10: Сүүлийн 5 жилийн төвийн үйлчлүүлэгчийн тоо
2022 оны 12-р сарын 31 хүртэл нийт: 2,559,080 хүн (давхардсан тоо)



Эх сурвалж: Монгол-Японы Төв, Ерөнхий удирдлагын тасаг



График 11: Сүүлийн 7-н жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны тоо





График 12: Сүүлийн 3 жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны чанарын үзүүлэлт





2. Онцлох мэдээ

1) 20 жилийн ойгоо угтлаа

Энэ жил тус төвийн үүсгэн байгуулагдсаны 20 жилийн болон Монгол Япон хоёр улсын дипломат харилцаа тогтсоны 50 жилийн тэгш ой тохиож байгаагаараа онцлог жил болж өнгөрлөө. Хэдийгээр дэлхий даяар халдварт цар тахалтай эдийн засгийн хувьд хүндрэлтэй жил болсон ч бид өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан төвийнхөө өнгө үзэмж, үйлчлүүлэгчдийг тав тухтай үйлчлүүлэхэд анхаарлаа хандуулан

1. Төвийн гадна хаалганы засвар
2. Хойд хаалганы коридорын засвар
3. Гадна фасадын цэвэрлэгээ үйлчилгээ
4. Борооны ус зайлуулах шугам татах
5. Дулааны болон цэвэр усны шугамын хэсэгчилсэн засвар
6. Дээврийн хэсэгчилсэн засвар болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 59. Гадна фасад цэвэрлэгээ

Үйлчлүүлэгч та бүхэнтэйгээ өнгөрүүлсэн 20 жилийн туршид бид давхардсан тоогоор 2,500,000 гаруй хүнд үйлчилж олон олон арга хэмжээг гүйцэтгэсэн билээ. Цаашид ч улам цэвэр тохилог орчинд та бүхэндээ үйлчлэн монгол япон хоёр улсын хооронд боссон гүүр байх болно гэдэгтээ итгэлтэй байна 20 жил бидэнтэй хамт байсан та бүхэндээ баярлалаа.

V. БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА





2022 ОНЫ БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн нийт ажилтнууд өөрийн хариуцсан ажлаас гадна төвийн нийт үйл ажиллагааны сайжруулалт болон ажилтан хоорондын харилцааг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хэд хэдэн багт хуваагдан ажиллаж байна. 2022 онд тасаг бүрийн ажилтны төлөөллөөс бүрдсэн “Маркетинг баг”, “5S Кайзен баг”, “Эрүүл мэнд, спортын баг”, “Үйл ажиллагаа зохион байгуулах баг”, “Харилцан туслалцах баг” гэсэн 5 баг тус тусын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Ингэснээр ажилтан хоорондын багийн ажиллагаа, уялдаа холбоо сайжрахас гадна шинийг санаачлах, өөрийгөө шинээр нээх боломжтой болж байна.

1. МАРКЕТИНГИЙН БАГ

Тус баг нь Монгол-Японы төвийг олон нийтэд таниулахын зэрэгцээ төвөөс явуулж байгаа сургалт, үйл ажиллагаанд хамрагдах суралцагч, оролцогчдын тоог өсгөх, тогтоон барих зорилготойгоор 2016 онд анх тасаг бүрийн төлөөлөгч 4 гишүүнтэйгээр байгуулагдаж, өдийг хүртэл амжилттай үйл ажиллагаа явуулж ирлээ.

2022 оны үйл ажиллагааны тойм:

№	Огноо	Үйл ажиллагаа	Зураг	Тайлбар
1	2022.02	20 жилийн ойн лого шалгаруулах уралдаан		Энэ жил төвийн үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиож буйтай холбогдуулан лого шалгаруулах уралдааныг ажилтнууд дундаа зохион байгуулав.
2	2022.03	Төвийн арван дөрөвдүгээр тайлан		Тухайн жилийн үйл ажиллагааг тайлан болгон гаргадаг бөгөөд 2022 оны 14 дэх удаагийн тайланг гаргалаа. Энэ жилийн тайлан урьд жилүүдийнхээс хамгийн олон хуудастай тайлан болсон.



3	2022.04	Фотошопын анхан шатны сургалт		Шинэ ажилтнууддаа зориулан фотошопын анхан шатны сургалт зохион байгуулав.
4	2022.06	20 жилийн ойн хүлээн авалтын урилга		20 жилийн ойн урилгыг шинэлэг дизайнаар Монгол, Япон 2 хэлээр хэвлэгдэв.
5	2022.11	Ажилтны үнэмлэхний оосор		Төвийн нэр, лого оруулсан шинэ ажилтны үнэмлэхний оосортой болов

2. 5S КАЙЗЕН БАГ

Цар тахлын хорио цээр суларсаар эргэн хэвэндээ орж, төвийн үйл ажиллагаа ч бүрэн сэргэсэнтэй холбоотойгоор сайн дурын багуудын ажил ч идэвхжин, үйл ажиллагаагаа амжилттай явуулж ирлээ. Энэ жилийн хувьд багийн нэг гишүүн японд сурахаар явж, шинэ залуу ажилтнаар солигдон амжилттай ажиллалаа.

Үндсэн чиглэл, зорилго:

Үргүй зардлыг бууруулж, ажилтнуудын 5S-ийн талаарх ойлголтыг нэгтгэх, шинэ ажилтнуудад зөв ойлголтыг суулгах зорилготой ажиллаж, үүнтэйгээ холбоотойгоор дотоод нөөц бололцоогоо ашиглан ажилтнуудад зориулсан сургалтыг 3 удаа явуулж, мөн эргүүл хяналтыг тогтмол хугацаагаар хийсэн. Ингэснээр төв нийтийн эмх цэгц дээшилж, мэдлэг мэдээлэлтэй байсан ажилтнуудын хувьд тэрхүү мэдлэг нь баталгаажиж, шинээр хүлээн авч буй ажилтнууд зөв ойлголттой болж, 5S-ийг хэрэгжүүлэнгээ ажиллах боломж бүрддэг.

Оны эцэст шилдэг 5S, сайжруулалт болон үргүй зардлыг бууруулж чадсан тасгийг шалгарууллаа.



Гүйцэтгэсэн ажил:

1. Багийнхаа жилийн ажлын төлөвлөгөөний дагуу тогтсон хугацаанд эргүүл хийснээр төвийн эмх цэгц сайжирч, ном, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн хамгийн өргөнөөр ашигладаг япон хэлний сургалтын тасгийн хувьд 5S кайзэн хэвшил дадал болон хэрэгжсээр байна.
2. Түүнчлэн өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан үргүй зардлыг бууруулсан үр дүнтэй жишээ хэд хэд гарсны нэг нь ЕУТ-ийн слесарь борооны усыг хуримтлуулж, зүлэг модоо усалснаар байгууллагаас гарах цэвэр усны зардлыг бодитойгоор хэмнэж чадсан юм.
3. Мөн бизнесийн сургалтын тасаг Mailing list-ээр бизнесийн сургалтын зар болон бусад мэдээллийг явуулах аргыг IT-ийн ажилтнаар заалган авч, гарын авлага боловсруулсанаар өөрсдөө хариуцан явуулдаг болсон нь ажлын цагийг хэмнэсэн үр дүнтэй арга болсон.
4. Номын сан, хамтын ажилагааны тасгийн тухайд номын сангаар үйлчлүүлэгчиддээ зориулан номын сангаар хэрхэн үйлчлүүлэх тухай зааварчилгааг боловсруулж, суудал захиалгын төхөөрөмжидөө байрлуулснаар үйлчүүлэгч нэг бүрт адил зүйл тайлбарлаж цаг алдахгүйгээс гадна үйлчлүүлэгчийг удаан хүлээлгэх зүйлгүй болж, ажлын цагийг ч хэмнэсэн маш үр дүнтэй сайжруулалт болсон.
5. 5S сайжруулалт багийн үйл ажиллагааны үр дүнд ажилтнуудын ойлголт нэгдэж, бүгд төвийнхөө эмх цэгцтэй, тав тухтай байдлыг хангах нэг зорилгоор бие биенээ дэмжин ажиллаж байна.
6. Багаараа ахлах зөвлөх Оониши Ёшифүмигаас зөвлөгөө аван хамтарч ажилласан бөгөөд түүний хэлсэн санаа оноог дараа жилийнхээ төлөвлөгөөнд тусгах, мөн дээр дурдагдсан ажлуудаа ч гэсэн улам сайжруулах, хэмнэлт хийх замаар аливаа зардлыг бууруулж чадсан тооцоонд илүү төвлөрч ажиллахыг зорьж байна.

3. ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН БАГ

Зорилго:

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх замаар ажилтнуудын харилцаах холбоог сайжруулах, эрүүл амьдралын хэмнэлийг хэвшүүлэхэд оршино

1) Спортын цаг

Ажилтнуудын бие бялдар болон дархлааг дэмжих, хамт олны уур амьсгалыг бүрдүүлхээр ажилтнууд өөрсдийн сонирхлын дагуу, өөрсдийн зардлаар нийт 4н удаагын волейболын анхан шатны бэлтгэлийг амжилттай зохион байгууллаа.



Зураг 60. Воллейболын бэлтгэлийн явц

2) Иогийн дасгал

Ажлын бус цагаар төвийн их танхимд нийт ажилтны 80 орчим хувь хамрагдсан нийт 3 удаагийн сургалтыг зохион байгууллаа.



Зураг 61. Иогийн дасгалын явц



3) Теннис, дартсын тэмцээн

Төвийн нийт ажилтнууд 4 багт хуваагдан дартс болон ширээний теннисний эрэгтэй хос, эмэгтэй хос, холимог хос, болон гацаарчилсан төрлүүдээр өрсөлдөн аваргаа шалгарууллаа.



Зураг 62. Теннис эрэгтэй хосын тэмцээн



Зураг 63. Дартсын тэмцээн

4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ БАГ

2022 онд Монгол-Японы төвийн үйл ажиллагаа зохион байгуулах баг нь “Ажлын байр, ажилтнууд хоорондын уур амьсгалыг сайжруулж, ажиллахад таатай орчин бүрдүүлцгээе” гэсэн зорилгын хүрээнд 227 хүнийг хамарсан дотоод арга хэмжээг зохион байгууллаа.

1) “Дээлтэй Монгол” өдөрлөг

Энэ жил шинэ оны эхний арга хэмжээ болгон уламжлал ёсоор “Дээлтэй Монгол” өдөрлөгөө зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Монгол-Японы төвийн захирал Ц.Даваадорж, мэндчилгээ дэвшүүлж бар жилийн эхний ажлын өдрийг эхлүүлэв.



Зураг 64. “Дээлтэй Монгол” өдөрлөг



2) Мэргэжилтэн болон ажилтнуудыг угтах, үдэх өдөрлөг



Зураг 65. Баруун гар талаас JF мэргэжилтэн Мицүмото Томоя, Б.Цацрал, JF мэргэжилтэн Цүрүта Ясүюки, Б.Эрдэнэсайхан нар

Монгол-Японы төвд Япон сангийн хэлний төвийн мэргэжилтнүүд тодорхой хугацаагаар томилогдож ирдэг. Тус жил 4 жилийн хугацаанд Монгол-Японы төвд мэргэжилтнээр томилогдон ажилласан Мицүмото Томоя багш болон шинээр томилогдон ирсэн Цүрүта Ясүюки багшийн угталт үдэлтийг хийхийн хамт шинээр орж ирсэн ажилтнуудаа ч мөн нийт төвийн хамт олноороо угтаж авах өдөрлөг зохион байгуулав.

3) Эх үрсийн баярын хүрээнд төвийн ажилтнуудын хүүхдүүдэд бэлэг бэлэглэв

Жил бүр “Эх үрсийн баяр”-ын хүрээнд хүүхдүүдэд зориулсан хөгжилтэй арга хэмжээ зохион байгуулдаг байсан хэдий ч, энэ жил ч мөн халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх үүднээс хүүхдийн нас хүйсний онцлогт тохирсон бэлгийг бэлдэж бэлэглэлээ.

Энхрий бяцхандүүдээ

Эх үрсийн баярын мэнд хүргэе.
Баяраа тасархай гоё тэмдэглээрэй



Монгол-Японы төвийн ах эгч нараас нь



Зураг 66. Эх үрсийн баярын бэлэг



4) Ажилтнуудад зориулсан хээрийн дадлага сургалт

Монгол-Японы төв үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ажилтнуудад зориулсан 2 хоногийн дадлага сургалтыг зохион байгуулав. Тус сургалтын хүрээнд төвийн нийт ажилтнууд 5S хөдөлгөөнийг хэрэгжүүлэгч “Моншибасаки ХХК” компани дээр туршлага солилцохоор очиж танилцав. Мөн сургалтын хүрээнд Жайкагийн Оониши Ёшифүми зөвлөх мэргэжилтэн ажилчднуудад зориулан “Байгууллагын соёл” сэдвээр сургалт орсон бөгөөд сургалтын хугацаанд спорт болон хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулж хамт олноороо 2 өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлээ.



Зураг 67. Ажилтнуудад зориулсан хээрийн дадлага сургалт

5) Ажилтнуудад зориулсан төрсөн өдрийн цахим мэндчилгээ

Жил бүр байгууллага дотооддоо төрсөн өдөр болон бусад тэмдэглэлт баярт үйл явдлын үеэр мэндчилгээ дэвшүүлдэг уламжлалтай бөгөөд энэ жил ямар нэгэн тэмдэглэлт баярт үйл явдлын мэндчилгээг ихэвчлэн цахим хэлбэрээр дэвшүүлсэн юм. Тэр тусмаа ажилтнуудын төрсөн өдрийн мэндчилгээг бичлэг хэлбэрээр бэлдэн фэйсбүүк хуудсаар дэвшүүлсэн юм. Ингэснээр тэр бүр уулзаж ярилцах боломж бага ажилтнуудын хувьд харилцах боломж нэмэгдэж, тэр хэмжээгээр ажилтнууд хоорондын уур амьсгал нэмэгдэхэд ч мөн тодорхой хэмжээгээр нөлөөлсөн болов уу.



Зураг 68. Ажилтнуудад зориулсан төрсөн өдрийн цахим мэндчилгээ